



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ
15 ДАХЬ ИЛТГЭЛ**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот

2016 он

ГАРЧИГ

Танилцуулга	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.	
Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт	
1.1 Ялтны эрхийн хэрэгжилт	7
1.1.1 Хорих байрны орчин нөхцөл	9
1.1.2 Тахир соёот дахь Хорих 405 дугаар анги буюу Гяндан	13
1.1.3 Эмнэлгийн тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн талаар	15
1.1.4 Зөрчил ба сахилгын шийтгэл	19
1.1.5 Ялтны хөдөлмөр эрхлэлт ба цалин хөлс	22
1.1.6 Сурч боловсрох эрхийн талаар	25
1.1.7 Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар	27
1.1.8 Эргэлт уулзалт авах эрхийн талаар	29
1.2 Тодорхой хүрээнд эрх нь хязгаарлагдаж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилт	30
1.2.1 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчдын эрхийн хэрэгжилт	30
1.2.2 Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлэгчдийн эрхийн хэрэгжилт	38
1.2.3 Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн харьяа Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байраар үйлчлүүлж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилт	44
ХОЁРДУГААР БҮЛЭГ.	
Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт	50
2.1. Аливаа этгээдийг баривчлах үед өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх эрхтэй болох, түүнчлэн баривчилсан талаар шүүхэд гомдол гаргах эрхийг тайлбарласан байдал	55
2.2 Цагдан хорих тухай шийдвэрийг танилцуулж буй байдал	57
2.3 Өмгөөлөгчөө сонгох эрхийг хангасан байдал	58
2.4 Хууль зүйн туслалцаа авсан үе шат	63
2.5 Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ	65
2.6 Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо	69
2.7 Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах нөхцөл боломж	75
2.8 Өмгөөлөгч ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшилж буй байдал	79
2.9 Өмгөөлөгчөөс татгалзаж буй тохиолдол, шалтгаан	82
2.10 Хууль зүйн туслалцааны талаар гомдол гаргаж буй байдал	86
ГУРАВДУГААР БҮЛЭГ.	90
Ахмад настны эрхийн хэрэгжилт	92

3.1	Олон улсын санаачлага, үйл ажиллагаа	94
3.2	Ахмад настны нийгмийн хамгааллын өнөөгийн нөхцөл байдал	95
3.2.1.	Ахмад настны тэтгэвэр	99
3.2.2.	Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт, дэмжлэг туслалцаа	111
3.2.3.	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	113
3.2.4.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ	115
3.2.5.	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	
	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	117
	Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт	118
4.1	Ажлын байрны орчин нөхцөл	120
4.2	Ажлын цаг, цалин хөлс	125
4.3	Дүрэмт хувцасны хангалт	126
4.4	Тусгай хэрэгсэл	127
4.5	Эрүүл мэндийн асуудал	128
4.6	Сургалт	131
	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Их Хуралд шийдвэр гаргуулахаар хүргүүлж буй санал	

ТАНИЛЦУУЛГА

“Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэнэ.”

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалт)

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцэж, Монгол Улсын Их Хуралд өргөн барьж байна.

Тус илтгэлийг Комиссын хийсэн хяналт шалгалт, судалгаа, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас Комисст хандан гаргасан гомдол, гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт болон холбогдох төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, иргэний нийгэм, бусад байгууллагын хийсэн судалгаанд тулгуурлан боловсруулав.

Энэхүү илтгэлд хүний эрхийн дараах асуудлыг авч үзлээ.

Нэгдүгээр бүлэгт. Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн хүрээнд хорих ял эдэлж буй хүмүүсийн хуулиар хязгаарлаагүй, баталгаатай эдлэх ёстой эрх хэрхэн хангагдаж байгаа талаар Комисс 2015 онд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа чанга дэглэмтэй Хорих 401, гяндан буюу Хорих 405, эмэгтэйчүүдийн Хорих 407, чанга дэглэмтэй Хорих 409, насанд хүрээгүйчүүдийн Хорих 411, чанга дэглэмтэй Хорих 415, жирийн дэглэмтэй Хорих 421, чанга дэглэмтэй Хорих 429, жирийн дэглэмтэй Хорих 443 дугаар ангиудад хяналт шалгалт, судалгаа хийж, хорих байрны орчин нөхцөл, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, ялтны хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс олголт, сахилгын шийтгэл оногдуулж буй шалтгаан нөхцөл, ялтны сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг тусгав.

Мөн тус бүлгийн 2 дахь хэсэгт тодорхой хүрээнд эрх нь хязгаарлагдаж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн талаар авч үзэв. Комисс 2015 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчид, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлэгчид, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн харьяа Түр хамгаалах байраар үйлчлүүлж буй иргэд болон насанд хүрээгүй хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт, судалгаа хийлээ. Хүний эрх, тэр дундаа эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн эдлэх ёстой эрхийг баталгаажуулж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орсон боловч эдгээр баримт бичгүүд тэр бүр хэрэгжиж чадахгүй байна.

Хоёрдугаар бүлэгт. Баривчлах, цагдан хорих арга хэмжээ нь хүний халдашгүй, эрх чөлөөтэй байх үндсэн эрхийг хөнддөг тул гэмт хэрэгт холбогдсон хүн бүр өөрийгөө өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхтэй болохыг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээ,

зарчмаар тодорхойлсон болно. Гэтэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч бие дааж нотлох баримт цуглуулах, хэрэгт ач холбогдол бүхий гэрчийг өөрийн санаачлагаар дуудах эрхгүй зэрэг хязгаарлагдмал хүрээнд оролцож, ялангуяа шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгч нь мэтгэлцээний үр нөлөөтэй тал болж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөл байдлыг өөрчилж, үндэсний эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишиг стандарт, хэм хэмжээнд нийцүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна.

Гуравдугаар бүлэгт. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” болохыг баталгаажуулж, Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн халамжийн багц хуулийг тус тус мөрдөж байгаа нь төрөөс зайлшгүй дэмжлэг туслалцаа үзүүлбэл зохих иргэдийн “ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрх”-ийг хангаж, хамгаалах нийгмийн хамгааллын тогтолцоог олон улсын хэм хэмжээ, зарчимд нийцүүлэхэд томоохон дэвшил болсон билээ.

Гэсэн хэдий ч ялангуяа ахмад настны эрхийг баталгаатай эдлүүлэхэд тэдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын цогц бодлого, үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг сайжруулах шаардлага тулгарч байгааг тус илтгэлд тусгасан болно.

Дөрөвдүгээр бүлэгт. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хүн бүр хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах ... эрхтэй.” гэж заасан билээ. Комисс энэ удаагийн илтгэлдээ Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлтэй танилцаж, тэднийг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, оношлогоонд хамруулах, зарим анги, албадын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, албан хаагчдад илүү цагаар, амралтын болон баярын өдөр ажилласан нэмэгдэл цалинг заавал олгож хэвших, аюулгүй байдлыг хангах үүднээс ажилтан бүрийг нэг бүрийн тусгай хэрэгслээр бүрэн хангах, одоо ашиглагдаж буй тусгай хэрэгслүүдийг шинэчлэх, сайжруулах, албан хаагчдын тухайн улирлын албаны дүрэмт хувцасны хангалтыг хугацаанд нь тавьж хэвших зэрэг асуудлыг хөндсөн болно. Монгол Улсын Үндсэн хууль (1992), Хөдөлмөрийн тухай хууль (1999), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2002), бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, мэргэших, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс авах, амрах зэрэг хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн байдлыг тусгалаа.

Харин Монгол Улсын Их хуралд 2014 оны 3 дугаар сарын 31-нд өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл, 2015 оны 3 дугаар сарын 30-нд өргөн барьсан 14 дэх илтгэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо нэгтгэн хэлэлцэж, 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдөр 28, 29 дүгээр тогтоолыг тус тус гаргасан болно. Монгол Улсын Засгийн газарт уг тогтоолыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангах арга хэмжээ авч, хэрэгжилтийн талаар 2016 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мэдээлэхийг чиглэл болгосон байна. Иймд Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13, 14 дэх илтгэлд дэвшүүлсэн санал хэрэгжилтийг цаг хугацааны хувьд энэхүү илтгэлд тусгаж танилцуулах боломжгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу дээрх асуудлаар тодорхой саналыг энэхүү илтгэлд тусган Монгол Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулахаар хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

“Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.”

(Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл)

Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ.

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ...Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

1.1 Ялтны эрхийн хэрэгжилт

Аливаа этгээдийг гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах, шүүн таслах, түүнд ял оногдуулах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нь тухайн улс орны хүний эрхийн хэрэгжилтийн гол шалгуур үзүүлэлт болдог билээ.

Дэлхийн улс орнууд эрүү шүүлт тулгах болон хүний нэр төрийг гутаан доромжилж, харгис хэрцгийгээр харьцаж шийтгэхийн эсрэг байж, хүнийг хорьж мөрдөх, түүнд хорих ял оногдуулж, ялыг биечлэн эдлүүлэхдээ баримтлах олон улсын стандартуудыг өөрийн улсын дотоодын хууль тогтоомждоо тусгаж зохицуулдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олон улсын нийтээр дагаж мөрдөх стандарт, дүрэм, журам, гэрээ, конвенцуудыг батлан гаргасан бөгөөд эрх чөлөөгөө хасуулсан гэдэг утгаараа “эмзэг бүлэгт” хамаарах хүмүүстэй төрөөс туйлын болгоомжтой харьцах, тэдэнд эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хатуу хориглодог юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт², Эрүүдэн

¹Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III дугаар тогтоолоор баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц³, Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль⁴, Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм⁵, Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд⁶, Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд⁷, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц⁸ зэрэг зарчим, стандарт, баримт бичгүүдэд эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн баталгаатай эдлэх эрх болон хоригдох орчин нөхцөлийн талаар тодорхой шалгуур тавьсан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд⁹ “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан бөгөөд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс болохын хувьд тус байгууллагаас батлан гаргасан баримт бичгүүдийг дагаж мөрдөх тодорхой үүргийг хүлээдэг билээ.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ.” гэж заасны дагуу шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа жир, чанга, онцгой дэглэм бүхий төвлөрсөн хорих анги болон гянданд хорих ялыг биечлэн эдлүүлж байна. Хэдийгээр шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд хорих ял оногдуулж тэдний тодорхой эрхүүдийг хязгаарладаг боловч Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан, баталгаатай эдлэх ёстой эрхүүдийг хязгаарлахыг хориглодог болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой харилцааг Монгол улсын Үндсэн хууль (1992), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2002), Прокурорын байгууллагын тухай хууль (2002), Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль (1999), Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль (2002) болон Монгол Улсын Хууль зүйн сайд, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын тушаалаар баталсан холбогдох дүрэм, журмаар зохицуулж байна.

Манай улсын хэмжээнд баривчлах ял эдлүүлэх анги 1, жирийн дэглэмтэй хорих анги 11, чанга дэглэмтэй хорих анги 10, онцгой дэглэмтэй хорих анги 1, гяндан 1, насанд хүрээгүйчүүдийн хорих анги буюу хаалттай сургууль 1,

²Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200/A/XXI дугаар тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

⁴Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан.

⁵Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 68 дугаар хуралдаанаар баталсан.

⁶1955 онд Женевт хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэгдүгээр Их хурлаар баталсан.

⁷Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 дүгээр тогтоолоор баталсан.

⁸Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан.

⁹Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дах заалтууд.

эмэгтэйчүүдийн жир, чанга дэглэмтэй хорих анги 1 нийт 25 төвлөрсөн хорих анги үйл ажиллагаа явуулж байна.

Нийт хорих ангиудад 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 4279 ялтан ял эдэлж байгаагаас жирийн дэглэмд 1844, чанга дэглэмд 1998, онцгой дэглэмд 267, гянданд 83, баривчлах байранд 87 ялтан байна¹⁰.

Комисс байгуулагдсан цагаасаа хойш хорих ял эдэлж буй хүмүүсийн хуулиар хязгаарлаагүй, баталгаатай эдлэх ёстой эрх хэрхэн хангагдаж байгаа талаар хяналт шалгалт, судалгаа, мониторинг хийх замаар хөндлөнгийн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажилласаар ирлээ.

Комисс 2015 онд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа чанга дэглэмтэй Хорих 401, гяндан буюу Хорих 405, эмэгтэйчүүдийн Хорих 407, чанга дэглэмтэй Хорих 409, насанд хүрээгүйчүүдийн Хорих 411, чанга дэглэмтэй Хорих 415, жирийн дэглэмтэй Хорих 421, чанга дэглэмтэй Хорих 429, жирийн дэглэмтэй Хорих 443 дугаар ангиудад ял эдэлж буй ялтнуудын олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан эрхийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт, судалгаа хийв.

Энэ удаагийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд зохион байгуулсан хяналт шалгалтын явцад хийгдсэн судалгаанд нийт 900 ялтан хамрагдсан бөгөөд хорих байрны орчин нөхцөл, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, ялтны хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс олголт, сахилгын шийтгэл оногдуулж буй шалтгаан нөхцөл, ялтны сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг тус тус шалгаж баримтжуулсан болно.

1.1.1 Хорих байрны орчин нөхцөл

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1955 онд батлан гаргасан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд "... Хоригдлуудын ашиглаж байгаа бүх өрөө тасалгаа, түүний дотор унтлагын өрөө нь ариун цэврийн бүх шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд тэгэхдээ цаг уурын нөхцөл тэдгээр өрөөний хэмжээ, ноогдох талбай, гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалтыг онцгой анхаарвал зохино¹¹, Хорих өрөө тасалгаанууд нь байгалийн гэрэлд ном уншиж, ажиллах хангалттай хэмжээтэй, агааржуулалтын хиймэл системтэй эсэхээс үл хамаарч цэвэр агаар орохоор хийгдсэн байхаас гадна хиймэл гэрэлтүүлэг нь хоригдлуудын хараанд аюулгүй, уншиж ажиллахад хангалттай байвал зохино¹²." гэж заажээ. Сүүлийн жилүүдэд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа төвлөрсөн хорих ангиуд болон аймаг орон нутаг дахь цагдан хорих байруудыг шинээр барьж, засвар үйлчилгээг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн энэ салбарт дэвшилттэй өөрчлөлтүүдийг хийж байгаа боловч зарим төвлөрсөн хорих ангиудын орчин нөхцөлийг өөрчлөх, анхаарах зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Хорих 401 дүгээр анги нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Тогтоол гүйцэтгэх газрын

¹⁰Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын 2016 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 2а/117 дугаар албан бичгээр ирүүлсэн судалгаа.

¹¹Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1955 онд батлан гаргасан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 10 дугаар зүйл.


¹²Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1955 онд батлан гаргасан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 11 "а".


Нэгдсэн эмнэлэг, Дамжин өнгөрүүлэх анги гэсэн давхар чиг үүргийг гүйцэтгэж байна. Тус ангийн эмнэлгийн барилга нь 1954 онд эмнэлгийн зориулалтаар баригдсан бөгөөд ашиглалтын явцад барилгын чанар илтэд муудсан, нэгдсэн эмнэлгийн хэсгийг дотоод нөөц бололцоогоороо засвар хийж тохижуулсан боловч зарим өрөөний орчин нөхцөл муу, ялангуяа эрэгтэй өвчтөнүүдийн 2 өрөөний хана, тааз хөгцөрч мөөгөнцөртсөн, дээврийн дээд талаас ус нэвтэрч тааз цөмөрснөөс өвчтөнүүд хэвтэн эмчлүүлэх боломжгүй нөхцөл байдалтай болсон байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/195 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Дамжин өнгөрүүлэх ангид мөрдөх дэглэм, харуул хамгаалалтын журам”-ын 1.3-т “Дамжин өнгөрүүлэх ангийн дэглэм, харуул хамгаалалт нь чанга дэглэмтэй хорих ангитай адил байх бөгөөд түүний гадна хамгаалалтыг чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих төв болон гяндангийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журамд нийцүүлж зохион байгуулна.” гэж заажээ.

Дамжин өнгөрүүлэх байр нь гэм буруутай нь шүүхээр тогтоогдож хорих ялаар шийтгүүлсэн ялтныг хорих ангид нь хүргэхийн өмнө, нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж эмчилгээ нь дууссан ялтан, оргож баригдсан ялтан, хуулийн байгууллагын дуудлагаар болон тогтоол гүйцэтгэх газрын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шилжин ирсэн ялтныг 30 хүртэлх хоногоор байрлуулах зориулалттай бөгөөд эмнэлгийн зоорийн хэсэгт байрлах 24-25 метр квадрат бүхий хорих 8 өрөөтэй байна. Ялтнуудыг хорих ангиас ирсэн, шинээр ирсэн, давтан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон ял эдлэх дэглэмээс хамаарч хуваан нэг өрөөнд 8-10 ялтан байрлуулж байна. Тус байрны орчин нөхцөл маш муу, өрөөний агааржуулалт, байгалийн гэрэлтүүлэг хангалтгүй, механик агааржуулалтын төхөөрөмжтэй боловч ажиллагаагүй, урсгал засвар хийгээгүйгээс гадна ялтнууд хорих өрөөндөө хувинд бие зассан байсан нь тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх, эмчилгээ үр дүнгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Санал асуулгад нийт 156 ялтан оролцсоноос “Хорих ангийн байрны орчин нөхцөл ямар вэ” гэсэн асуултад эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 16 ялтан сайн, 44 ялтан дунд, 22 ялтан муу гэж, аж ахуйн ялтнуудын хувьд 6 ялтан сайн, 15 ялтан дунд, 20 ялтан муу гэж, дамжин өнгөрүүлэх байранд хоригдож байсан 4 ялтан сайн, 4 ялтан дунд, 21 ялтан муу гэж тус тус хариулсан байна. Хорих ангийн байрны орчин нөхцөл дунд, муу гэж хариулсан 122 ялтан буюу 78,2 хувь нь хангалтгүй үнэлгээ өгчээ.





Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 460 дугаар тогтоолоор 2016 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Цагдан хорих 461 дүгээр ангийн харьяанд Дамжин өнгөрүүлэх байрны чиг үүргийг шилжүүлснээр тус байрны нөхцөл байдал сайжирсан байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах эмэгтэйчүүдийн Хорих 407 дугаар ангийн жирийн болон чанга дэглэмтэй ялтны байрууд нэг хашаанд байрлах бөгөөд байруудыг стандартын дагуу төмөр торон хаалтаар тусгаарласан байна. Мөн жирэмсэн, нярай хүүхэдтэй ялтны байр, эмнэлэг, үйлдвэр гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд чанга дэглэмтэй ялтны амьдрах байр нь 10 өрөөтэй, 80 ялтны багтаамжтай, нэг өрөөнд 8-10 ялтан байрлуулж, өрөө тус бүрийг камержуулжээ.

Хорих өрөө бүр механик агааржуулалтын төхөөрөмжтэй, байгалийн агааржуулалт орохуйц салхивчтай байгаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 11-д “агааржуулалтын механик системтэй эсэхээс үл хамааран цэвэр агаар орохоор хийгдсэн байвал зохино.”, Монгол Улсын Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/230 дугаар тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журмын 3.4-т “... өрөөний халаалт, агааржуулалт нь хууль тогтоомжид заасан, олон улсын хэмжээнд дагаж мөрдөж байгаа хэм хэмжээний шаардлагыг хангасан байвал зохино.” гэж тус тус заасныг хангаж байна.

Монгол Улсын Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/230 дугаар тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журмын 3.3-т “Ялтныг 2.5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байрлуулна...” гэж заасан бөгөөд жирийн дэглэмтэй ялтны амьдрах байр нь 224 ялтан байрлуулах багтаамжтай боловч хяналт шалгалтын үед 266 ялантай байгаа нь дээрх журмын заалтыг зөрчиж байна.

Тус хорих ангийн жирэмсэн болон нярай хүүхэдтэй ялтны байр нь 2013 онд ашиглалтад орсон, гал тогооны өрөө, ариун цэврийн өрөө, угаалгын өрөө, хүүхдийн тоглоомын өрөө, ялтны амьдрах өрөөнөөс бүрдэж байна. Ялтны амьдрах нэг өрөө нь 6 ортой бөгөөд орчин нөхцөл, агааржуулалт, дулаан, агаарын чийглэг хэвийн байсан нь дээрх журмын шаардлагыг хангаж байна.

Шалгалтын үед жирэмсэн 2, нярай (6-10 сартай) хүүхэдтэй 3 ялтныг ялтны амьдралын бүсийн гадна барьсан байрны нэг өрөөнд хүүхдүүдтэй нь хамт байлгаж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх хэсэгт заасан “жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж”-ийг нярай хүүхэдтэй ялтнууд авдаггүй байх тул хорих ангийн зүгээс холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах насанд хүрээгүйчүүдийн Хорих 411 дүгээр анги буюу хаалттай сургуулийн барилга нь 1960 онд ашиглалтад орсон, урсгал засвар норм, дүрмийн дагуу хийгдээгүйгээс хана таазанд чийг цохиж, мөөгөнцөртсөн, хонгилын модон таазны шавардлага хагарч хөндийрөн унах нөхцөл бүрдсэн, хучилт ханын хийц бүтээцэд ан цав үүсэж суусан нь барилгын бат бэх тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж байх тул барилгад үүссэн эвдрэл, гэмтлийг мэргэжлийн байгууллагаар тооцоо хийлгэж, зураг төсөл боловсруулан, засварын ажлыг эрх бүхий барилга угсралтын байгууллагаар гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт¹³ гарчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 8 дугаар 22-ны өдрийн 178 дугаар тогтоолоор Тахир соёот дахь Хорих 429 дүгээр анги буюу сүрьеэ өвчтэй ялтнуудыг тусгаарлан эмчлэх анги байгуулагджээ. Тус анги нь эмнэлгийн байгууллагаар сүрьеэ өвчтэй болох нь тогтоогдсон ялтнуудыг тусгаарлан эмчилдэг улсын хэмжээний ганц хорих анги юм.

Ялтны амьдрах 1, 2, 3 дугаар байр нь нэг давхар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын (хуучнаар) цэргийн ангийн түр байрны зориулалттай ашиглагдаж байсан бөгөөд хуучирч муудсан, дээврээс дусаал гоожиж шавар шохой нурсан, хана туурга нь цуурсан, модон шал нь цөмөрч ховхорсон байдалтай байв. Уг ялтны байруудыг цаашид амьдрах зориулалтаар ашиглах боломжтой эсэх талаар мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гараагүй байна.

Тус хорих ангийн эмнэлгийн барилга нь 2008 онд ашиглалтад орсон 40 өрөө бүхий 50 ортой, олон эмэнд тэсвэртэй сүрьеэг эмчлэх тасаг 10 ортойгоор үйл ажиллагаа явуулж байна. Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/230 дугаар тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журмын 3.3-т “Ялтныг 2.5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байрлуулна...” гэж заасан бөгөөд өрөөнүүдийн талбай харилцан адилгүй, нэг ялтанд дунджаар 2 метр квадрат талбай ногдож байгаа нь дээрх журамд заасан шаардлагыг хангахгүй байна.

Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2002 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 270 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”-ын 3.3-т “Сахилгын байр, тусгаарлах тасалгаа нь бетонон тааз, бетонон буюу тоосгон ханатай, бэхлэгдсэн модон шал, эсхүл бэхлэгдсэн модон ортой, давхар төмөр хаалгатай, онгойлгох хязгаарлагчтай, хяналтын шагайвартай, гадна талдаа цоожтой, цонх, гар нүүр угаах, бие засах газар нь төмөр сараалжин хамгаалалттай, агааржуулах салхивчтай, байрны дулаан хэвийн хэмжээтэй, ердийн гэрэлтүүлэгтэй байна” гэж заасан бөгөөд зарим хорих ангийн сахилгын байрны нөхцөл муу, хүйтэн, чийг

¹³Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 07-339/1526 дугаар дүгнэлт.

ихтэй байгаа нь сахилгын хорих байранд хоригдсон ялтнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж хууч өвчин сэдрэх, хаван гүйх, бөөр өвдөх зэрэг өвчнөөр өвчилж болзошгүй нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.


Жишээлбэл Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Хорих 409 дүгээр ангийн сахилгын байр нь шалган нэвтрүүлэх байрны зоорийн хэсэгт байрладаг бөгөөд нийт 3 өрөөтэйгээс нэг өрөө нь цонхгүй, өрөөнүүд хүйтэн, орчин нөхцөл муу, ялтнууд ундааны саванд бие зассан байсан нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байв. Өрөөнүүдийн талбайн хэмжээ болон чийгшилт, дулааныг багажаар хэмжихэд талбайн хэмжээ дунджаар 2,1 метр квадрат, 16 хэмийн дулаантай байсан нь Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2002 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 270 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”-ын 3.3-т заасан шаардлагыг хангахгүй байна.

Тохиолдол:

...Би хорих ангид ирээд нэг жил гаруй болж байгаа бөгөөд гар утас хэрэглэсэн зөрчил гаргаж сахилгын хорих байранд 30 хоног хоригдох сахилгын шийтгэлээр шийтгүүлээд 10 хонож байна. Энэ ангийн сахилгын байрны нөхцөл муу, хүйтэн, чийг ихтэй байна. Мөн цагаар бие засдаг буюу өдөрт 3 удаа л бие засдаг...

(Хяналт шалгалтын үед ялтан Б-тэй хийсэн ярилцлагаас)

Санал асуулгад нийт 900 ялтан оролцсоноос Хорих ангийн ялтны байрны орчин нөхцөл ямар вэ? гэсэн асуултад нийт 790 ялтан хариулснаас 296 ялтан буюу 32,8 хувь нь сайн, 362 ялтан буюу 40,2 хувь нь дунд, 132 ялтан буюу 14,6 хувь нь муу гэж тус тус хариулсан байна. Үүнээс үзэхэд 494 ялтан буюу 54,8 хувь нь хорих ангийн ялтны байрны орчин нөхцөлийн талаар хангалтгүй үнэлгээ өгчээ.



1.1.2 Тахир соёот дахь Хорих 405 дугаар анги буюу Гяндан

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх асуудал хариуцсан тусгай илтгэгч Манфрэд Новак Монгол Улсын Засгийн газрын урилгаар манай улсад ажиллах хугацаандаа 2005 оны 6 дугаар сарын 8-ны өдөр тус хорих ангийн нөхцөл байдалтай танилцаж “... ялтныг гадагш гаргахдаа гарыг нь гавладаг бөгөөд эргэлтийн үед мөн адил гавлаж дөнгөлдөг байна...” гээд Монгол Улсын Засгийн газарт 2005 онд өгсөн зөвлөмжийн L хэсэгт “Удаан хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн ялтанд хэрэглэж байгаа одоогийн онцгой дэглэмийг эцэс

болгож, эрх чөлөөгөө хасуулсан этгээдийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлд заасан засан хүмүүжүүлэн, дахин нийгэмшүүлэх зорилготой нийцүүлэн хорьж байх явдлыг хангах” гэж зөвлөжээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.11 дэх хэсэгт “Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа онц хүнд гэмт хэрэгт арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно”, мөн хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт “...Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино” гэж тус тус заасан нь хорих ялыг гянданд эдлүүлэх үндэслэлийг тогтоожээ.

Монгол Улсын Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/230 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан Хорих ангийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.6.1-т “хорих өрөө нь ялтанд хяналт тавих боломжтой торон болон төмөр хаалгатай, хаалга нь хязгаарлагчтай, хагас /45 градус/ онгойхоор зохицуулагдсан байхаас гадна байнгын цоожтой байх” 4.6.2-т “нэг өрөөнд 2-оос илүүгүй ялтныг хорих ба шаардлагатай гэж үзвэл прокурортой зөвшилцөн ганцаарчлан байрлуулах” гэж заасан байна.

Хорих 405 дугаар анги буюу гяндангийн байр нь 3 давхар, 73 хорих өрөөтэй, өрөө тус бүр хяналтын камерт холбогдсон бөгөөд хяналт шалгалтын үеэр 82 ялтан ял эдэлж байв.

Гяндан нь ялын төрөл үү, хорих ялыг эдлүүлэх хорих ангийн дэглэм үү гэдгийг Эрүүгийн хуульд тодорхой заагаагүй бөгөөд судлаачдын дунд ихээхэн маргаан гардаг юм. Учир нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.11 дэх хэсэгт гяндан нь хорих ангийн дэглэм байж болохоор, мөн хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт “ ... гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино.” гэж зааснаас үзэхэд ялын төрөл мэт боловч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 46 дугаар зүйлийн 46.1.1-46.1.7 дахь хэсгүүдэд заасан ялын төрөлд гянданд хорих гэж тусгагдаагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэгт “Гяндангийн ялтныг тусгай төхөөрөмжлөгдсөн газарт, зохих хяналт хамгаалалтын дор **өдөрт нэг цагаас доошгүй хугацаатай** салхилуулах ба журам зөрчвөл салхилуулахыг даруй зогсооно.” гэж заасан бөгөөд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тушаалын хавсралт “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”-ын дагуу хорих ангийн ажилтнуудын амралтын өдөр буюу хагас, бүтэн сайн өдрүүдэд ялтныг салхилуулдаггүй байна. Иймээс дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тушаалын хавсралт “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”-ын 19.7-д “ялтныг салхилуулах хугацаанд бусад хөдөлгөөнийг түр зогсоож ээлжийн бүрэлдэхүүн, төлөөлөгчид бүрэн байлцаж хяналт тавина.” гэснийг өөрчлөх шаардлагатай юм.

Дэглэм болон хорих ялын алинаас нь ч харсан тус хорих ангид ял эдэлж байгаа гэдэг утгаараа бусад хорих ангийн ялтнуудтай адил жам ёсны эдлэх эрхийг нь шүүх хязгаарладаггүй билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар гяндангийн ялтны удаан хугацааны уулзалт авах эрхийг хассан нь олон улсын гэрээ, конвенцод нийцээгүй тул удаан хугацааны уулзалт хийх эрхийг хангах шаардлагатай юм. Учир нь гянданд ял эдэлж байгаа ялтнуудын дунд цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан ялтнуудаас гадна хорих ялынхаа тодорхой хэсгийг гянданд эдлэхээр шийтгүүлсэн, мөн бусад хорих ангиас сахилгын шийтгэлээр дэглэм дээшилж ирсэн ялтнууд байгааг анхаарах нь зүйтэй байна.

Монгол Улс цаазаар авах ялыг халахад чиглэсэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт II протокол¹⁴ 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө цаазаар авах ялыг халах үүргийг хүлээсэн билээ. Тиймээс жил тутам гяндангийн ялтны тоо нэмэгдсэнээр гяндангийн хорих өрөөнүүд хүрэлцэхгүй байх хүнд нөхцөл байдалд хүрч болзошгүй байна.

Комисс Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэлдээ “Гяндан” гэх нэр томъёо, ял эдлүүлэхтэй холбоотой журам, эрх зүйн зохицуулалтыг нэг мөр болгох талаар тусгасан боловч одоог хүртэл энэ асуудал шийдвэрлэгдээгүй байна.

1.1.3 Эмнэлгийн тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх


Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Тогтоол гүйцэтгэх газрын харьяа Нэгдсэн эмнэлэг нэг, сүрьеэ өвчтэй ялтнуудыг тусгаарлан эмчлэх хорих анги нэг ажиллаж байгаагаас гадна хорих анги тус бүрт ялтнуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгүүд ажиллаж байна.

Хорихын Нэгдсэн эмнэлэг буюу Хорих 401 дүгээр анги нь нийт төвлөрсөн хорих ангиудад ял эдэлж байгаа ялтны эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, үзлэг оношлогоо хийх, шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчлэх, мэс засал хийх, системийн бусад эмнэлгийн салбарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн үүрэгтэй ажиллаж байна. Тус Нэгдсэн эмнэлэг 120 ор бүхий дотор, мэдрэл, мэс засал, онош зүйн 4 тасагтай, сувилахуйн алба, уламжлалт эмчилгээ, хүлээн авах, яаралтай тусламж, эмийн сан, ариутгал гэсэн нэгж хэсгүүдтэй, 22 их эмч, 23 сувилагч-дунд мэргэжилтэн, 7 асрагч нийт 52 албан хаагчтай 2 дугаар шатлалын эмнэлгийн статустай үйл ажиллагаа явуулж байна.


Тус эмнэлэгт 2014 онд 2888 ялтан, 2015 онд 2933 ялтан хэвтэн эмчлүүлжээ¹⁵.

¹⁴Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протокол.


¹⁵Комисст Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Тогтоол гүйцэтгэх газрын харьяа Нэгдсэн эмнэлгээс 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл. 2016 он.



Хэвтэн эмчлүүлсэн ялтнуудын өвчлөлийн судалгаанаас үзэхэд хоол боловсруулах эрхтэн систем, бөөр шээс ялгаруулах эрхтэн систем, зүрх судасны өвчин, мэдрэлийн тогтолцооны эмгэг өвчин дийлэнх хувийг эзэлж байна.



Нэгдсэн эмнэлгийн эмч нарын хяналтын комиссын хурлаар 2014 онд хүнд өвчний улмаас хугацаанаас өмнө ялаас чөлөөлүүлэх тухай 23 ялтны материалыг прокурорын байгууллагад хүргүүлснээс 17 ялтныг, 2015 онд 33 ялтны материалыг прокурорын байгууллагад хүргүүлснээс 30 ялтныг шүүхээс тус тус хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн байна.



Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ялтнуудаас 3 дугаар шатлалын эмнэлэгт давхардсан тоогоор 2014 онд 352 ялтан үзүүлснээс 34 ялтан хэвтэн эмчлүүлсэн, 91 ялтны хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг сунгуулсан, 66 ялтан нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, зөвлөгөө авсан, 161 ялтан холбогдох шинжилгээнд хамрагдсан бол 2015 онд 328 ялтан үзүүлснээс 150 ялтан холбогдох шинжилгээнд хамрагдсан, 119 ялтан нарийн мэргэжлийн эмчид үзүүлж, зөвлөгөө авсан, 31 ялтны хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг сунгуулсан, 28 ялтан хэвтэн эмчлүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагджээ¹⁶.

Тохиолдол:

... Би хорихын Нэгдсэн эмнэлэгт 5-6 удаа хэвтэн эмчлүүлсэн боловч сайжрах нь бүү хэл улам дордож өдөрт 1-2 удаа ухаан алдаж, татаж унадаг болсон. Мөн 2 тэмсэгээр өвдөж шээс муу гардаг, хорихын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч болон эмчилгээ эрхэлсэн орлогч эмч нар миний өвчнийг үл тоож өвчнөөр минь намайг доромжилдог ..

(Комисст ирүүлсэн ялтан С-ийн гомдлоос)

Эмнэлгийн өрөөний хүрэлцээ дутмаг учир шүдний кабинет болон лабораторийг тусгаарлаж 3 блок болгон эмчийн өрөө, эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, тусламж, үйлчилгээ үзүүлэх өрөө болгон ашиглаж байна. Мөн Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа CS 11-0235:2013 стандартын 10.17.1-д “Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх тасаг, нэгжтэй байна” гэж заасан боловч хяналт шалгалтын үед эмнэлэгт тусгайлсан яаралтай тусламжийн нэгжгүй, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг хамт байрлаж байна.

Тахир соёот дахь жирийн дэглэмтэй Хорих 429 дүгээр анги нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа хорих ангиудын ялтны сүрьеэ өвчнийг оношлох, урьдчилан сэргийлэх, эмчилж сувилах, диспансерийн хяналт тавих ажлыг цогцоор нь шийдэх зорилгоор чанга дэглэмтэй хорих ангийн

¹⁶Комисст Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Тогтоол гүйцэтгэх газрын харьяа Нэгдсэн эмнэлгээс 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл. 2016 он.

статустай байгуулагдсан боловч тус эмнэлэгт эерэг, сөрөг хоёр тасагт жирийн, чанга, онцгой дэглэмийн ялтнуудыг нэг дор байрлуулан эмчилж байна.

Тус эмнэлэг нь сүрьеэгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг учир I, II дугаар шатлалын эмнэлгийн алинд ч харьяалагддаггүй бөгөөд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын баталсан 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/187 дугаар тушаалаар тусгай мэргэжлийн сүрьеэгийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны CS 11-0236:2013 стандартыг баталжээ.

Тогтоол гүйцэтгэх газрын Нэгдсэн эмнэлэг нь нийт ялтнуудад шинжилгээ хийж, сүрьеэ өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд Тогтоол гүйцэтгэх газрын даргын шийдвэрээр тус ангид шилжүүлэн эмчилж байна. Тус хорих ангид 2014 онд 78 ялтан, 2015 онд 126 ялтан, 2016 оны 3 дугаар сарын байдлаар 41 ялтан сүрьеэ өвчний оноштойгоор эмчилгээ хийлгэжээ¹⁷.

Эмнэлэгт хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжүүд нь хуучирч эвдэрсэн тул шинэчлэх асуудлыг даруй шийдвэрлэж, зайлшгүй шаардлагатай техник, багаж хэрэгслээр бүрэн хангах, эмчлүүлэгчдийн гудас, хөнжил, цагаан хэрэглэл болон бусад зөөлөн эдлэлийг ариутгадаг дезкамерын асуудлыг даруй шийдвэрлэх, засварлах, эмнэлгийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохих стандарт, дүрэм журмын дагуу хийх, хорих ангийн ялтны байрны орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна.

Тус ангид цусны ерөнхий шинжилгээ, цэрний түрхэцийн шинжилгээ, рифамицинд тэсвэржилтийн шинжилгээнүүдийг хийж, зайлшгүй шаардлагатай биохимийн шинжилгээ, цээжний рентген зургийг Хорих 401 дүгээр ангид, серологийн шинжилгээг Халдварт Өвчин Судлалын Үндэсний төвийн лабораторид зөөвөрлөн хийж байна. Эмнэлгийн удирдлагын танилцуулснаар Глобаль сангийн төслөөр биохимийн аппарат тус эмнэлэгт нийлүүлэгдэхээр болсон байна.

Дэлхийн Зөн, Глобаль сангийн төслөөр ялтнуудад сар бүр 3 сая төгрөгийн гаж нөлөөний эм, өвчтөнүүдийн нэмэгдэл хоолонд сар бүр 1,2 сая төгрөгийн хүнс нийлүүлж байгаа бөгөөд энэхүү төслийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан эмчилгээтэй ялтнуудад нэмэлт хоол, гаж нөлөөний болон элэг хамгаалах, дархлаа сайжруулах эмнүүд нь зайлшгүй шаардлагатай байгаа тул энэхүү зардлыг төсөвт тусгуулах шаардлагатай байна.


Сүрьеэгийн эмнэлгийн эмч, сувилагч нар Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар болон ангийн даргын удирдлага дор Глобаль сангийн дэмжлэгтэй “Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллага, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн Сүрьеэгийн Тандалт судалгааны албатай хамтран ажиллаж, олон эмэнд тэсвэртэй сүрьеэ өвчнийг эмчлэх тасгийг 2006 онд 10 ортойгоор дээрх байгууллагын санхүүжилтээр байгуулж, олон эмэнд тэсвэртэй сүрьеэ өвчтэй ялтнуудыг эмчилж байна.

Тус ангид 2015 оны төсвийн санхүүжилтээр эм, тариа, эмнэлгийн хэрэгсэлд 2,5 сая төгрөг төсөвлөгдсөн, 150 нэр төрлийн эм тариа, эмнэлгийн хэрэгсэл ашиглагдаж байснаас хугацаа дууссан 8 нэр төрлийн 127 ширхэг эм, тариа хэрэглэгдэж байсан нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэгт “Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй,

¹⁷Комисст Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Хорих 429 дүгээр ангиас 2016 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн мэдээлэл.

чанарын баталгаажуулалтгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэхийг хориглоно.” гэснийг зөрчсөн байна.

Тус ангид ял эдэлж буй ялтнуудаас “Эмнэлгийн эм, тарианы хангамж буюу хүртээмж хэр вэ” гэсэн асуултад 26 ялтан буюу 29 хувь нь хангалттай, 27 ялтан буюу 30 хувь нь дунд, 21 ялтан буюу 24 хувь нь муу, 15 ялтан буюу 17 хувь нь мэдэхгүй гэж тус тус хариулжээ. Санал асуулгын дүнгээс үзэхэд 61 хүн буюу 71 хувь нь эмнэлгийн эм, тарианы хангамж буюу хүртээмжийн талаар дунд, муу, мэдэхгүй гэсэн хангалтгүй үнэлгээг өгсөн байна.



Бусад хорих ангиудын хувьд мөн адил эм, тарианы төсөв хангалтгүйн улмаас хугацаа дууссан эм, тариа хэрэглэх нөхцөл байдал үүсч байгаагаас гадна тусгайлсан яаралтай тусламжийн нэгжгүй, яаралтай тусламжийн үйлчилгээнд шаардлагатай байвал зохих тоног төхөөрөмжгүй байгаа нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн технологи - Хорих ангийн эмнэлгийн үйл ажиллагаа” стандартын шаардлагыг хангахгүй байна.

Тохиолдол:

... хорих ангийн эмч үзлэг эмчилгээ хийдэггүй, гар гээд хөөдөг, өвчин гайгүй үед загнадаг, харилцааны соёлгүй, өөрөө эмчил гээд хөөж гаргадаг, эм тарианы хангамж муу, эмч ажлаа хийдэггүй, үл тоосон байдалтай байдаг, эмчилгээ хийдэггүй, эмчийн чадвар муу, ямар ч боломжгүй, эмнэлгийн үйлчилгээ муу, эмнэлгийн тоног төхөөрөмж хангалтгүй байдаг ...

(Ялтнуудтай ганцаарчлан уулзсан ярилцлагаас)


Нийт хяналт шалгалтад хамрагдсан хорих ангиудад ял эдэлж буй ялтнуудаас “Та өвчилсөн тохиолдолд эмнэлгийн тусламж авч чаддаг уу” гэсэн асуултад 172 ялтан буюу 19.1 хувь эмнэлгийн тусламж, үйлчилгээ авдаг, 296 ялтан буюу 32.8 хувь заримдаа авдаг, 220 ялтан буюу 24.4 хувь нь авдаггүй гэж тус тус хариулжээ. Үүнээс үзэхэд 516 ялтан буюу 57,2 хувь нь хорих ангиудын эмнэлгийн тусламж, үйлчилгээг хангалтгүй гэж үнэлжээ.




1.1.4 Зөрчил ба сахилгын шийтгэл

Нийт хорих ангид ял эдэлж буй ялтнуудын гаргасан зөрчлийн судалгаанаас үзэхэд бусадтай маргалдах, архи согтууруулах ундаа хэрэглэх, мөрийтэй тоглоом тоглох, албан хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, хориотой эд зүйл хадгалах, хэрэглэх буюу гар утас хэрэглэх зөрчлийг гаргасны дийлэнх хувийг хорих ангийн амьдралын бүсэд гар утас хэрэглэсэн зөрчил эзэлж байна.

Тухайлбал 2014 онд 1298 ялтан, 2015 онд 717 ялтан тус тус гар утас хэрэглэсэн гэх үндэслэлээр сахилгын шийтгэл хүлээсэн байна¹⁸.



Гар утас хэрэглэсэн зөрчлийг хорих анги тус бүрээр нь авч үзвэл:



Ялтны ар гэрээс эргэлт уулзалтаар ирэхдээ нууцаар авчрах, ажилтан, албан хаагчдаар дамжуулах байдлаар ялтны амьдралын бүсэд гар утсыг оруулдаг бөгөөд албан хаагчид тухайн гар утсыг үзлэг, нэгжлэг, бусад шалгалтаар илрүүлэн хураан авч, ялтнуудад буцаан худалдах явдал гарч байна. Энэ нь хорих ангийн дотоод хяналт сул, буруутай албан хаагчдад хариуцлага тооцдоггүй, үзлэг нэгжлэгийг дутуу хийдгээс үүдэлтэй юм.

¹⁸Комисст Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас ирүүлсэн мэдээлэл. 2016 он.

Тохиолдол:

... Ялтан О-ийн ээж нь эргэлт уулзалтаар ирэх бүртээ авчирсан гар утсаа ногоон цайны доторхийг нүхэлж хийгээд түүнийгээ ялтны амьдралын бүс рүү оруулж, ялтнуудад зарж байсныг ангийн дотоод хяналт шалгалтаар илрүүлж хууль бус үйлдлийг таслан зогсоосон.

(Хяналт шалгалтад хамрагдсан хорих ангийн мэдээллээс)

Нийт хорих ангийн дарга нарын тушаалаар зөрчил гаргасан ялтнуудад ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэл ногдуулах явдал түгээмэл байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас батлан гаргасан Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц¹⁹-ийн 2.1-т "...албадан ба заавал хийлгэх хөдөлмөр гэдэг нэр томъёо нь ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж аливаа иргэнээс өөрөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил үйлчилгээг хэлнэ", Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц²⁰-д "Улс бүр албадан ажил хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглож, ... хүмүүжлийн арга хэрэгсэл болгох эсхүл улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны эсрэг чиглэсэн улс төрийн үзэл бодлоо илэрхийлсний төлөө ногдуулах шийтгэл болгох, эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор ажиллах хүчийг дайчлах, ашиглах арга хэлбэр болгох, хөдөлмөрийн сахилга батыг сахиулах арга хэрэгсэл болгох, арьс өнгө, нийгмийн байдал, яс үндэс, шашин шүтлэгээр алагчлах арга хэрэгсэл болгох зорилгоор ашиглахыг таслан зогсоох" тухай заасан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1.1 дэх хэсэгт "ээлжийн бус ажил хийлгэх" гэж заасан нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалтыг зөрчиж байна.

Комиссоос Хууль зүйн яаманд Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах талаар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээний заалтыг баримтлан олон улсын гэрээ конвенцтой зөрчилдөж буй заалтыг хэрэглэхгүй байхыг зөвлөж байсан бөгөөд энэ нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас өргөн барьсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд тусгалаа олсон байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.6 дахь хэсэгт "Жилд хоёроос дээш удаа сахилгын шийтгэл хүлээсэн ялтан дахин ноцтой зөрчил гаргавал хорих ял эдлүүлэх дэглэмийг чангаруулах тухай саналыг хорих ангийн дарга прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ." гэж заажээ.

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас ирүүлсэн судалгаанаас үзэхэд **2014 онд 2048 ялтанд, 2014 онд 1400 ялтанд** сахилгын шийтгэл оногдуулсан байх бөгөөд 2014 онд ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэлийг 1001 ялтанд, сахилгын байранд 30 хүртэл хоног хорих арга хэмжээг 591 ялтанд, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх арга хэмжээг 168 ялтанд, тухайн сар,

¹⁹Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас 1930 онд батлан гаргасан Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орж, соёрхон баталсан.

²⁰Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас 1930 онд батлан гаргасан Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орж, соёрхон баталсан.

улирал, жилд олгосон шагналын хоног хасах арга хэмжээг 288 ялтанд, 2015 онд ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэлийг 550 ялтанд, сахилгын байранд 30 хүртэл хоног хорих арга хэмжээг 485 ялтанд, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх арга хэмжээг 132 ялтанд, тухайн сар, улирал, жилд олгосон шагналын хоног хасах арга хэмжээг 233 ялтанд тус тус ногдуулсан байна²¹.



Жишээлбэл зөвхөн нэг хорих ангийн хувьд сахилгын шийтгэл оногдуулсан байдлыг дараах тоон үзүүлэлтээс харж болно.



Судалгаанаас үзэхэд гарч байгаа зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргасан албан хаагчдад тооцох хариуцлагын механизмыг сайжруулах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжийн талаарх албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.1.5 Ялтны хөдөлмөр эрхлэлт ба цалин хөлс

Ялтнуудыг хөдөлмөрлүүлэх нь тэдний засрал хүмүүжилд эерэгээр нөлөөлөх, суллагдсаныхаа дараа шударгаар хөдөлмөрлөх, нийгэмд өөрийн байр сууриа олох, амьдрах хүсэл эрмэлзэл, зорилготой болох, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, ур чадвараа нэмэгдүүлэх, мэдлэг туршлага олж авах,

²¹Комисст Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас ирүүлсэн судалгаа. 2016 он.

хөдөлмөрийнхөө хөлсөөр бусдад учруулсан гэм хорын хохирлоо барагдуулах, цалин хөлсөө ар гэртээ шилжүүлэх, хуримтлалтай болох боломжийг бүрдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

Манай улсад ялтны хөдөлмөр эрхлэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүгийн хууль, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Барилгын салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай”, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/232 дугаар тушаалаар баталсан “Ялтан ажиллуулах тухай” журам, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/32 дугаар тушаалаар баталсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”-аар тус тус зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх хэсэгт “Ялтныг албадан хөдөлмөрлүүлж эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох” гэж заасан нь “Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц”-ийн агуулгатай нийцэхгүй байна. Энэхүү конвенцийг соёрхон баталсан гишүүн улс бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг аль болох богино хугацаанд арилгах үүрэг хүлээж байгаа бөгөөд албадан хөдөлмөрийг устгахтай холбогдуулан шилжилтийн үед зөвхөн нийгмийн зорилгоор онцгой арга хэмжээ болгон конвенцод тусгайлан заасан нөхцөл, баталгааг хангасан тохиолдолд хэрэглэж болох юм. Тодруулбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4-т “албадан хөдөлмөр” гэсэн нэр томъёог шууд утгаар хэрэглэж, хуулиар зөвшөөрсөн нь олон улсын гэрээний зорилго агуулгатай зөрчилдөж байна²².

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/14 дугаар тушаалаар баталсан “Төлбөртэй ялтны бүртгэл хөтлөх, төлбөр төлөлтөд хяналт тавих журам”-ын дагуу 2015 онд нийт хорих ангид ял эдэлж буй 898 ялтны хөдөлмөрийн хөлснөөс 124,6 сая төгрөгийг гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлжээ²³.

Ялтнуудын хувьд хорих ангийн аж ахуйн үйлчилгээ, үйлдвэрлэлийн бүсэд ажиллахаас гадна аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр нүүрсний уурхай, хэвлэх үйлдвэр, оёдлын үйлдвэр, тоосгоны үйлдвэр, модон эдлэл, вакум цонхны болон хөнгөн блокны үйлдвэрт ажиллах буюу хүнсний ногоо тарих, замаск, шохой, чулуу бутлах, гар урлал хийх зэрэг ажлуудыг хийж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.4 дэх хэсэгт “Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно.” гэж заасан байна. Гэтэл тус хуулийн 120 дугаар зүйлийн 120.6 дахь хэсэгт “чанга, онцгой дэглэмд ял эдэлж байгаа ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулах”-аар хуульчилснаар чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг

²²Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл. 50-61 дүгээр хуудас. 2012 он.

²³Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 5-477 дугаар албан бичиг.

хөдөлмөр эрхлүүлэх боломж бололцоо хомс, үйлдвэрлэл эрхэлдэггүй чанга дэглэмтэй хорих ангийн ялтны хувьд хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагдмал байна.

Жишээлбэл Хорих 407 дугаар ангийн хувьд ялтны ажлын дадлага, сонирхлыг харгалзан ажлын байраар хангахад анхаарч жирийн, чанга дэглэмд оёдол, хэрээсэн хатгамал, гар урлал, зүү ороох, эсгий болон арьсан улавч хийх, аж ахуйн үйлчилгээ, гадны гэрээт байгууллага, ангийн тохижилт үйлчилгээний ажилд нийт ялтны 83 хувийг ажлын байраар хангаж, 225 ялтныг 12 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дагуу ажиллуулж, цалин хөлсийг олгож байгаа нь үр дүнтэй хэдий ч ялтны амьдралын бүсэд ажиллаж буй 50 ялтанд цалин олгохгүй, зөвхөн шагналын хоног тооцож олгож байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Амгалан дахь Хорих 421 дүгээр анги нийт 329 ялтан ял эдэлж байгаагийн 87 ялтан хорих ангийн амьдралын бүсэд, 23 ялтан амьдралын бүсээс гадна хорих ангийн аж ахуй дээр, 100 гаруй ялтан аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр барилга, арьс ширний үйлдвэр, тоосгоны үйлдвэр, жоншны үйлдвэр болон замын ажилд туслах ажилтнаар тус тус ажиллаж байна. Тус хорих ангийн ялтны амьдралын бүсэд 87 ялтан, амьдралын бүсээс гадна аж ахуй дээр 7 ажлын байранд 23 ялтан ажиллаж байх бөгөөд эдгээр ялтнуудад цалин хөлс олгодоггүй, зөвхөн шагналын хоног олгож, цалин хөлсийг дутуу олгодог, цалин хөлсний оронд хүнс, бараа бүтээгдэхүүн өгдөг байна.

Бусад хорих ангиудын хувьд ч аж ахуйн ажил, амьдралын бүсийн цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллаж байгаа ялтнуудад цалин, хөлс олгодоггүй явдал түгээмэл байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1 дэх хэсэгт “ялтанд хийсэн хөдөлмөрийн тоо, чанарт тохирсон хөлс олгоно.” гэж заасныг зөрчиж байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 7 дугаар тогтоолоор нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 192,000 төгрөг, нэг цагт 1142 төгрөг 85 мөнгө байхаар тогтоосны дагуу ялтны ажилласан нэг цагийг 1142,85 төгрөгөөр тооцож, хөдөлмөрийн хөлсийг олгохоор байна. Ялтныг хөлсөөр ажиллуулах тухай аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний дагуу хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлж, уг цалин хөлснөөс хуульд заасан бүх төрлийн төлбөр суутгалыг хийж, үлдэгдлийг ялтны нэрийн дансанд шилжүүлж байна.

Тохиолдол:

... Миний хувьд ажил хөдөлмөр хийгээд хөдөлмөрийн хөлс гэж сард 192.000 төгрөг авах ёстой гэж бодож байсан ч түүнээс бага цалин өгдөг. Уг нь сард 192.000 төгрөгөөр цалинжуулна гэсэн юм. Харин 3 сар ажиллаад 215.000 төгрөгийн цалин авсан. ...Өндөр буянт ХХК-д 3 сар ажилласан. Гэтэл дансанд 126.000 төгрөг байсан. Миний тооцоогоор бол 570.000 гаруй төгрөг байх ёстой юм. Би дэлгүүрээс 120 мянган төгрөгний бараа авсан гэхээр цаана нь 350.000 орчим төгрөг дутаж байгаа юм. Ер нь бол бүх ялтны хувьд ингэж цалингаа дутуу авч байгаа.

(Хяналт шалгалтын үед ялтнуудтай хийсэн ярилцлагаас)

Хөдөлмөр эрхэлж буй ялтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар журмын хэрэгжилтийн талаар хийх ажлын төлөвлөгөөг мөрдөж,

ялтныг ажлын байраар хангах, гэрээгээр ажиллаж байгаа тохиолдолд гэрээт байгууллагаас олгогдсон хөдөлмөрийн багаж зэвсэг, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа, ахуйн хэрэглээний материал олголтын бүртгэл, шинээр ирсэн болон ажлын заалттай ялтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг тогтмол өгч, хөдөлмөр эрхэлж буй ялтнуудад хөдөлмөр хамгааллын хувцас, хортой нөхцөлийн сүү, бусад хэрэгслийг тухай бүр олгох шаардлагатай юм.

Гэтэл ялтнуудыг гэрээний үндсэн дээр ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаагүйн улмаас хөдөлмөр эрхэлж буй ялтнууд үйлдвэрлэлийн осолд орох зэргээр эрүүл мэндээрээ хохирч байна.

Тохиолдол:

Би гэрээний дагуу “Буюн” ХХК-н ноолуурын самнах хэсэгт ажиллаж байсан бөгөөд 2014 оны 12 дугаар 17-ны өдөр үйлдвэрлэлийн осолд орж, зүүн гарын 2,3,4,5 хуруугаа гэмтээж, улмаар 2 хуруугаа тайруулсан. Гэвч одоог хүртэл миний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоогоогүй байна. Ангийн зүгээс хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, нийгмийн халамжид хамруулах асуудлыг хөөцөлдөөгүй.

(Хяналт шалгалтын үеэр ялтан Б-тэй хийсэн ярилцлагаас)

Тохиолдол:

Миний охин ял эдэлж байгаа бөгөөд 2012 онд хорих ангийн хашаанд ажиллаж байхдаа хөлийн шилбээ гэмтээсэн. Үүний дараа 2013 онд барилга дээр ажиллаж байхдаа дахин хөлөө гэмтээсэн юм. Иймээс хорих ангийн удирдлагын зүгээс хөнгөн ажилд хуваарилан ажиллуулж байсан боловч 2015 оны 4 дүгээр сараас ангийн удирдлагууд солигдож, барилга дээр хүнд ажил хийлгэхээр хуваарилсан бөгөөд ажилд гарсангүй гэж шагналын хоног хасах, магадланд орох хугацааг хойшлуулах зэргээр дарамталж байгаад гомдолтой байна.

(Комисст ирүүлсэн иргэн Д-ийн гомдлоос)

1.1.6 Сурч боловсрох эрхийн талаар

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн 77.2-т “Хоригдлыг тухайн орны боловсролын системийн дагуу сургана.”, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7 дахь заалтад “Сурч боловсрох эрхтэй”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2 дахь хэсэгт “Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна.” гэж тус тус заажээ.

Насанд хүрээгүйчүүдийн Хорих 411 дүгээр анги буюу хаалттай сургууль нь бүрэн дунд сургуулийн статустайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2000 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 258 тоот тушаалаар Хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсрол олгох зорилгоор ерөнхий боловсролын 110 дугаар дунд сургууль нэртэйгээр ял эдэлж буй хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгож эхэлсэн байна.

Нийслэлийн боловсролын газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн тушаалаар Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Хан-Уул дүүргийн 110 дугаар дунд сургууль болсон бөгөөд Нийслэлийн боловсролын газраас 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр тус сургуулийн ангиллыг өөрчилж бүрэн дунд сургууль болгож, сургалт явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгожээ. Тус сургууль нь бага, дунд, ахлах гэсэн гурван бүлэгтэй нийт 15 сурагч, 6 багш, 159 ширхэг сурах бичигтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Үндсэн багшаар бага ангийн, монгол хэл, математик, түүх, нийгмийн ухааны багш нар, цагийн багшаар Кристина Нобелийн сангаас 2 багш хичээл зааж байна. Тус сургуульд багшлах хүний нөөц дутмаг байгаагаас нэг багш 1-3 хичээл зааж, зарим хичээлийг мэргэжлийн бус багш зааж байна. Энэ нь Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/305 дугаар тушаалын хавсралтаар Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журмын 1.3-т “Багшлах эрхийг багш мэргэжлийн чиглэл бүрээр олгоно”, мөн журмын 1.5-д “Журмын 2.1, 2.2-т заасан шалгуурыг хангасан багшид ерөнхий боловсролын сургуульд багшлах эрх олгоно.” гэж заасныг зөрчиж байна.

Тохиолдол:

Тус сургуульд монгол хэл, уран зохиолын багш монгол хэл, уран зохиол, монгол бичгийн хичээл заахаас гадна дуу хөгжмийн хичээлийг зааж, математикийн багш математик, геометрийн хичээлээс гадна физикийн хичээл зааж байна. Үндсэн багшаар ажиллаж буй түүх, нийгмийн ухааны багш нь багшлах эрхийн үнэмлэхгүй, тэтгэврийн насны хүн байх бөгөөд сонгон шалгаруулалтын үндсэн дээр багшлах боловсон хүчнийг авч ажиллуулдаггүй. Учир нь сонгон шалгаруулалтад орж тэнцсэн боловч манай сургуульд багшлах хүн олддоггүй.

(Хяналт шалгалтын үед албан хаагчидтай хийсэн ярилцлагаас)

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 351 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтоос үзэхэд сургалтын менежер нь багш мэргэжилтэй, төрийн үйлчилгээний албан хаагч байхаар заасан байна. Гэвч тус сургуулийн сургалтын менежерээр төрийн тусгай албан хаагчийг томилон ажиллуулж байгаа нь дээрх журамд заасан сургалтын менежерийн ажиллах албан тушаалын ангилалд тавигдах шаардлагыг хангахгүй байна.

Сурагчийн хувийн хэрэг нь сурагчдын сурлагын үнэлгээ болон хөгжил, төлөвшлийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг тэмдэглэх сургалтын баримт бичиг бөгөөд хяналт шалгалтын явцад сурагчдын хувийн хэрэгтэй нэг бүрчлэн танилцахад 7 сурагч хувийн хэрэг байхгүй, хувийн хэрэг хөтлөлт дутуу, шилжилт хөдөлгөөний тэмдэглэгээ хийгдээгүй байв. Энэ нь Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 361 дүгээр тушаалын зургадугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн суралцагчийн хувийн хэрэг хөтлөх заавар”-ыг зөрчиж байна.

Иймээс Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжид нийцүүлж, тус сургуулийн сургалтын чанарыг сайжруулах, мэргэжлийн багшийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бусад хорих ангиудын хувьд батлагдсан төлөвлөгөөний дагуу ялтнуудын дунд сургалт зохион байгуулж, бичиг үсэг мэдэхгүй ялтнуудад бичиг үсэг заах, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд тогооч, засал чимэглэл, бетон арматурчин, сантехникийн мэргэжлээр сургаж мэргэжлийн гэрчилгээ олгож байна. Хяналт шалгалтанд хамрагдсан хорих ангиудад нийт бичиг үсэг мэдэхгүй 38 ялтан, иргэний бичиг баримтгүй, бичиг баримтын зөрчилтэй 101 ялтан байв.

Монгол Улсын Хууль Зүйн Сайдын 2014 оны А/230 дугаартай тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журмын 13.1.3-т “Жирийн, чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа ялтан их, дээд сургууль, коллежид өөрийн зардлаар эчнээгээр суралцах эрхтэй”, 13.6-т “Эчнээ сургалтыг зөвхөн хорих ангийн байранд явуулна”, 13.7-д “Ялтныг эчнээгээр суралцуулах асуудлыг тухайн ялтны ар гэр, эсхүл түүний өмгөөлөгч нь суралцуулах сургуулийн захиргаатай урьдчилан тохиролцож, сургалтыг хорих ангийн байрлалд явуулахыг зөвшөөрөн гэрээ байгуулж, элсэлтийн болон төгсөлтийн шалгалт өгөх үеийн харуул хамгаалалтыг хорих ангийн дарга зохион байгуулна.” гэж тус тус заасны дагуу чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж буй 2 ялтан Хөдөө аж, ахуйн их сургуульд эчнээгээр суралцаж байна.

Тохиолдол:

... Миний бие 2007 оноос хойш Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь Техникийн сургуульд Хүнсний технологи-Эрүүл ахуйч мэргэжлээр суралцаж байсан бөгөөд 2012 оны 3 дугаар сарын 13-ны өдөр хэрэгт холбогдох үедээ 5 дугаар курст дипломын ажил бэлтгэж байсан юм. Улмаар тэр сургуульд суралцах журмын дагуу 3 жил дараалан чөлөө авсан бөгөөд одоо чөлөөний хугацаа нь дуусч байгаа тул цаашид үргэлжлүүлэн суралцаж, сургуулиа төгсөх боломжоор хангаж өгнө үү ... ирүүлсэн.

(Комисст ирүүлсэн ялтан Б-ийн гомдлоос)

1.1.7 Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1949 онд батлан гаргасан Женевийн конвенцийн 3 дугаар зүйлийн “а” хэсэгт “амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх үйлдлийг хэзээ ч, хаана ч хориглоно.”, “Хэнийг ч, хэзээ ч, ямар ч нөхцөлд эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхгүй.” хэмээн Хүний эрхийн түгээмэл тунхаглал²⁴-ын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²⁵-ын 7 дугаар зүйлд заасныг харгалзан, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталсан Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалын дагуу 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийг батлан гаргасан байна.

²⁴Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан бөгөөд энэ өдрийг дэлхий дахинаа “Олон улсын хүний эрхийн өдөр” хэмээн тэмдэглэн өнгөрүүлдэг билээ.


²⁵Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

Энэхүү конвенцод Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр, тус конвенцийн нэмэлт протоколд 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр тус тус нэгдэн орж, соёрхон баталсан билээ. Ингэснээр Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын өмнө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтийг таслан зогсоох, эрүү шүүлт тулгасан хэнд боловч эрүүгийн хариуцлага тооцож байх үүргийг хүлээж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж ... болохгүй.” гэж эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулсан бөгөөд Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлох, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглосон билээ.


Сүүлийн жилүүдэд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа хорих анги, байгууллагууд нөхцөлийн эрүү шүүлтийг таслан зогсоох үүднээс ялтны байрыг засварлах, шинээр барих, олон улсын стандартыг өөрийн байгууллагад нэвтрүүлэх талаар нилээд ажлыг үе шаттайгаар хийж ирсний үр дүнд эрүү шүүлтийн зарим хэлбэр буурсан үзүүлэлттэй байна.

Хорих ангийн албан хаагчдын зүгээс ялтнуудтай зүй бус харьцах, хэл амаар доромжлох, дарамт шахалт үзүүлэх, зодох зэрэг зүй бус харьцаа байсаар байна. Санал асуулгад 900 ялтан оролцсоноос “Хорих ангийн ажилтан албан хаагч тантай хүнлэг бус, нэр төрийг тань доромжилж харьцаж байсан уу” гэсэн асуултад 112 ялтан тийм, 407 ялтан үгүй, 15 ялтан заримдаа гэж тус тус хариулсан байна.



Тохиолдол:
...Хорих ангийн албан хаагч нар биднийг хэл амаар байнга доромжилдог, ялтнуудтай ялгамжтай харьцдаг, мөн өөдөөс тайлбар тавьсан учир чамд зөрчлийн акт бичнэ хэмээн заналхийлдэг, дэглэм дээшлүүлнэ гэж сүрдүүлдэг, зүй бус харьцдаг..
 (Хяналт шалгалтын үед ялтнуудтай хийсэн ярилцлагаас)

“Та хорих ангийн ажилтанд зодуулж, түүний улмаас гэмтэл авч байсан уу” гэсэн асуултад 80 ялтан тийм, 602 ялтан үгүй хариулсан байна.



Комисст 2015 оны байдлаар ялтнуудаас “... хорих анги болон цагдан хорих байрны албан хаагчид, төлөөлөгч зүй бусаар харьцаж, хэл үгээр доромжилсон, зодсон, дарамт, шахалт үзүүлсэн” тухай нийт 43 гомдол ирүүлжээ.



Тохиолдол:

... Би өөрийн хүсэлтээр “Буян холдинг” ХХК-д ажиллаж байгаад ялтан “З”-д өшиглүүлж биедээ гэмтэл авсан учир эмчид үзүүлж байсан бөгөөд 2015 оны 1 дүгээр сарын 20-ны үед шалгалтаар ирсэн хяналтын прокурорт гомдол гаргасан юм. Тэгтэл хошууч “А” ахлагч “Б” нар намайг ээлжийн даргын өрөөнд дуудаж прокурорт гомдол гаргалаа гэж цахилгаан бороохойгоор цохиж зодсонд гомдолтой байна ...

(Комисст ирүүлсэн ялтан Н- ийн гомдлоос)

1.1.8 Эргэлт уулзалт авах эрхийн талаар

Эргэлт, уулзалт бол нэг талаасаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хөндлөнгийн хяналт гэж үздэг бөгөөд ялтнуудын хувьд түр болон удаан хугацааны эргэлт, уулзалт авах эрх нь тэдэнд эхнэр, нөхөр, хүүхэд, гэр бүлийн

бусад гишүүд, төрөл, садангийн хүмүүстэйгээ уулзах боломжийг бүрдүүлж байдгаараа онцлог бөгөөд энэ эрхийг хэт их болон бүрмөсөн хязгаарлах нь тухайн этгээдтэй хүн ёсноос гадуур хүнлэг бус харьцаж буйн илрэл юм. Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тогтоосон эргэлт, уулзалтын хязгаарлалт нь хэт хатуу байдаг бөгөөд гянданд хоригдож буй ялтны хувьд удаан хугацааны эргэлтийг бүрмөсөн хязгаарласан нь олон улсын хэмжээнд хүний эрхийн зөрчилд тооцогдож байна. Манай улсын хувьд ялтнууд ял эдэлж буй дэглэмээсээ шалтгаалан эргэлт уулзалт авах эрхээ ялгамжтай байдлаар эдэлж байна.

Жишээлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоо хязгаарлахгүй, жилд 8 удаа удаан хугацааны уулзалт авдаг бөгөөд чанга дэглэмтэй хорих ангийн ялтан 2 сард 1 удаа түр, 3 сард 1 удаа удаан хугацааны уулзалт хийж, сард 1 удаа илгээмж авч байна. Мөн онцгой дэглэмтэй хорих ангийн ялтан жилд 3 удаа түр, 2 удаа удаан хугацааны уулзалт хийж, сард 2 удаа захидал явуулах, жилд 3 удаа илгээмж авдаг бөгөөд гяндангийн ялтан жилд 2 удаа түр уулзалт хийж сард 1 удаа захидал явуулах, удаан хугацааны уулзалт хийх боломжгүй байна. Ялтнуудыг хорих ангийн дэглэмээс нь хамаарч эргэлт, уулзалт авах эрхийг нь хуулиар ялгамжтай тогтоосон нь тэдний гадаад орчинтой харилцах эрхийг зөрчиж байгаа нэг хэлбэр юм.

Комисоос хийсэн хяналт шалгалт, судалгааны дүнг дүнгээс үзэхэд ялтны Монгол Улсын нэгдэн орсон болон улсын гэрээ конвенц болон дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан эрхийг хангах талаар дараах саналыг гаргаж байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад цол нэмэх, тушаал дэвшүүлэхэд тавигддаг шаардлагад “хүний эрхийн зөрчил гаргаагүй байх” гэсэн үзүүлэлт нэмж оруулах;
- Ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох асуудлыг Монгол Улсын нэгдэн орсон Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцод нийцүүлэн Хөдөлмөрийн асуудал болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмаар зохицуулж, ялтнуудад хийсэн ажил хөдөлмөрт нь тохирсон цалин хөлсийг ялгаваргүй олгох;
- Хорих ангийн байршил, дэглэмээс үл хамаарч ялтны эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах үүднээс хорих ангийн эмнэлгийг мэргэшсэн хүний нөөц, хүрэлцэхүйц багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм, тариагаар хангах, стандартад нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

1.2 Тодорхой хүрээнд эрх нь хязгаарлагдаж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилт

Хүний эрх, тэр дундаа эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн эдлэх ёстой эрхийг баталгаажуулж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан олон улсын гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орсон боловч эдгээр баримт бичгүүд тэр бүр хэрэгжиж чадахгүй байна.

Комисс 2015 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчид, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлэгчид, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн харьяа Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байраар үйлчлүүлж буй иргэд болон насанд хүрээгүй хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтэд тус тус хяналт шалгалт, судалгаа хийлээ.

1.2.1 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчдын эрхийн хэрэгжилт

Комисс сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрхээ эдлэх боломжийг нь нэмэгдүүлэх үүднээс 2007 оноос хойш Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчдын эрхийн хэрэгжилтэд удаа дараа хяналт шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээг авч ирсэн билээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1991 оны 46/119 дугаар тогтоолоор баталсан “Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хамгаалах, уг өвчний эмчилгээ, үйлчилгээг сайжруулахад баримтлах зарчмууд”-д “Сэтгэцийн эмгэгтэй хүн” гэж сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг авч байгаа, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад хэвтсэн бүх хүнийг хэлнэ” гээд эдгээр хүмүүсийн үндсэн эрх чөлөө, эдлэх эрхүүдийг тодорхойлж өгчээ. Энэхүү зарчмуудад зааснаар сэтгэцийн эмгэгтэй хүмүүс хүн ёсоор, нэр төрөө хүндэтгүүлэн харьцах, хамгийн дээд зэргийн эмчилгээ, үйлчилгээг хүртэх эрхтэй. Түүнчлэн эдгээр хүмүүс иргэний, улс төрийн эрхээ бусдын адил эдэлж, ямар нэгэн ялгаварлан гадуурхалтаас ангид байж, эдийн засгийн, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөг, бие махбодын хүчирхийлэл, хүнлэг бус хэрцгий харьцаанаас хамгаалуулах эрхтэй болохыг баталгаажуулсан юм.

Монгол Улсын нэгдэн орсон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц²⁶-ийн 1 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсоны зэрэгцээ “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан, жендэрийн онцлогийг харгалзсан эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээг авна” гэж улс орнуудад үүрэг болгосон билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр дундаа сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр арга хэмжээ авч, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдний эрхээ эдлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь төрийн үүрэг юм.

²⁶Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид Монгол Улс 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр нэгдэн орж, соёрхон баталсан.

Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага албан ёсоор 1929 онд “Хий судлалын больниц” нэртэй байгуулагдаж, 20 ор, 1 эмчтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Улмаар уг эмнэлгийг 1983 онд Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эмгэг-наркологиин төв, сэтгэцийн клиникийн эмнэлэг болгон өөрчилснийг Эрүүл мэндийн сайдын 2006 оны 331 дүгээр тушаалаар татан буулгаж, Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг байгуулжээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 87 жилийн түүхтэй бөгөөд одоогийн байдлаар 83,000 м² талбай бүхий газарт дөрвөн блок барилгад поликлиник буюу эмнэл зүйн тусламж үйлчилгээ, төрөлжсөн тусламж үйлчилгээ, клиник буюу хэвтүүлэн эмчлэх Сэтгэцийн эмгэг судлалын I-VI клиник, Асрамжийн клиник, Хүүхэд өсвөр үеийн клиник, Донтох эмгэг судлалын клиник, Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник гэсэн чиглэлээр хэвтэн эмчлүүлэх нийт 520 ортой (байнгын хэвтэн эмчлүүлэх 500 ор, өдрийн сэргээн засах эмчилгээний 20 ор) 83 их эмч, 121 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, 126 асрагч нийт 497 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт “Магадлан тогтоох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2013 оны 161 дүгээр тушаалаар Магадлан тогтоох комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Эмнэлэгт албадан эмчлүүлсэн, нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүний сэтгэцийн байдал нь албадан эмчлүүлэх заалттай тохирч байгаа эсэхийг түүнийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 72 цагийн дотор тусгай комисс магадлан тогтооно.” гэж заасны дагуу тус төвийн Магадлан тогтоох комисс нь 2015 онд 5243 эмчлүүлэгчид өвчний түүх нээж, “Стационарт эмчлүүлэгч хэвтүүлэх заалт”-ын дагуу 37 эмчлүүлэгчид албадан эмчлэх тухай сэтгэцийн байдлыг тодорхойлсон дүгнэлт гаргажээ.

Шүүхээс сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 18 иргэнийг (2013 онд 4, 2014 онд 6, 2015 онд 8) эрх зүйн чадамжгүйд тооцож, шүүх сэтгэцийн эмгэг судлалын дүгнэлт гаргасан байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 22.356 сэтгэцийн эмгэгтэй хүн бүртгэлтэй байгаагийн 14.586 нь сэтгэцийн архаг эмгэгтэй байна. Үүнээс орон нутагт буюу 21 аймагт 10.445, нийслэлд 4.141 хүн байна²⁷.

Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 190/91 дүгээр хамтарсан тушаалаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хяналтад байсан “Оюуны хомсдол” эмгэгтэй 2846 хүнийг дүүрэг болон өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлжээ.

1.2.1.1 Асрамжийн клиник

Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан 2003 оны “Бүтцийн өөрчлөлтийн тухай” 94/158 дугаар

²⁷Комисст Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр statistic@ncmh.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн судалгаа, мэдээлэл.

тушаал, захирамжийн дагуу Төв аймгийн Баян сумын Мааньт дахь “Сэтгэцийн өвчтөний хөдөлмөр эмчилгээ, асрамжийн газар”-ыг татан буулгаж, уг асрамжийн газарт байсан сэтгэцийн эмгэгтэй 174 байнгын асруулагчийг Сэтгэцийн клиникийн эмнэлэгт шилжүүлжээ. Түүнээс хойш тус төв сэтгэцийн эмгэгтэй хүмүүст эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхээс гадна харж хандах, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг асрамжлах үйл ажиллагааг давхар явуулж байна.

Комисс 2007, 2011, 2016 онд тус төвд эмчлүүлж байгаа болон байнгын асруулагч сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд тусгай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийсэн бөгөөд тус төвийн үйл ажиллагааны нөхцөл байдал, эмчлүүлэгчдийн эрхийн хэрэгжилт, сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан улсын асрамжийн газар байгуулах санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд жил бүр өргөн барьдаг Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2007 оны 6 дахь илтгэл²⁸, 2012 оны 11 дэх илтгэл²⁹, 2013 оны 12 дахь илтгэл³⁰, 2014 оны 13 дахь илтгэл³¹-д тус тус тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний 2 дахь хөтөлбөрийг (2010-2019 он) хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1.6-д “2011-2012 онд эрх зүйн чадамжгүй, асран хамгаалагч шаардлагатай боловч асран хамгаалагчгүй сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдэд зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх”-ээр, мөн Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 154.4-т “Сэтгэцийн өвчтэй оюуны хомсдолтой, хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай асрамжийн газрыг бий болгоно” гэж хууль тогтоомж, тушаал, шийдвэрээр сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан төрөлжсөн асрамжийн газар байгуулах ажлыг Монгол Улсын Эрүүл мэнд Спортын яам болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын яам хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн боловч өнөөдрийг хүртэл хийгдээгүй байна³².

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь хэсэгт “сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн хүртээмжийг сайжруулах, орон гэргүй асран халамжлах хүнгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд зориулсан асрамжийн газрыг аймаг, дүүрэгт байгуулах”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь хэсэгт “... сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн тусламж үйлчилгээ гэсэн төрөлтэй байна” гэсэн хуулийн заалт хэрэгжихгүй байна.

Тус төвд 2016 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 124 байнгын асруулагч (21 жил 1; 18 жил 1; 13 жил 12; 1-12 жил 110) байгаагийн (эрэгтэй 62, эмэгтэй 62), 17-65 насны 115; насанд хүрээгүй, давхар хөгжлийн бэрхшээлтэй 11-16 насны 9 асруулагч байна³³. Үүнээс насанд хүрсэн 79, хүүхэд 9 нийт 88 асруулагч асрамжийн клиникийн байранд, 36 асруулагч гэр асрамжид амьдарч байна.

²⁸Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2007 оны 66 хуудас. 2008 он.

²⁹Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл, 92-97хуудас. 2012 он.

³⁰Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл. 114-116 хуудас. 2013 он.

³¹Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл, 131-132 хуудас. 2014 он.

³²Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. 131 хуудас. 2014 он.

³³Комисст Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр statistic@ncmh.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн судалгаа, мэдээлэл.

Монгол Улсын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд асрамжийн газрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоогүй хэдий ч сэтгэцийн эмгэгийн хувьд эдгэрэл сайжрал авсан асруулагчдыг нийгмийн дунд амьдрах дадал хэвшилтэй болгох, өөртөө туслах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлийн зохион байгуулалтад оруулах, мөн “Сэтгэцийн эрүүл мэнд” 2 дахь үндэсний хөтөлбөрийн 4.1.4-т “сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчдэд зориулсан сэтгэц нийгмийн нөхөн сэргээх өдрийн тусламж үйлчилгээг аймаг, дүүрэгт “Гэр” төв, кабинет хэлбэрээр зохион байгуулах”-аар заасны дагуу тус төвийн асрамжийн клиникийн харьяа 8 гэрт нийт 36 асруулагч хамтран амьдарч байна.

Асрамжийн клиник буюу байнгын асруулагчдын асрамжийн үйл ажиллагаанд зориулсан тусгайлсан төсөв байдаггүй тул Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн төсвөөс тус клиникт зориулж байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардалд жилд дунджаар 700 орчим сая төгрөг зарцуулдаг байна.

Комисс 2011 онд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран тус төвийн байнгын асруулагч 45 хүнийг иргэний бичиг баримттай болгох ажлыг зохион байгуулж тэдний нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон төрөөс үзүүлж буй үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлсэн юм³⁴.

Хяналт шалгалт, судалгаагаар насанд хүрсэн 4 асруулагч иргэний үнэмлэхгүй, 9 байнгын асруулагч хүүхэд төрсний гэрчилгээгүй байх бөгөөд 2011 оноос хойш бичиг баримтын зөрчилтэй асруулагчдыг иргэний бүртгэлд хамруулах, бичиг баримтжуулах ажил огт хийгдээгүй нь тэдний төрөөс үзүүлж буй тусламж дэмжлэг, халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжийг хязгаарлаж байна.

Мөн 124 асруулагчаас 81 нь хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон бол 42 асруулагч гэрийн хаяг тодорхойгүй, овог, нэрийн зөрчилтэй, бичиг баримтгүйн улмаас хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгоогүй байна.

Тохиолдол:

Асруулж буй хүүхдүүдийн ар гэрийхэн хүүхдийнхээ бичиг баримтаар төрөөс олгож буй хүүхдийн мөнгийг авч ашигладаг байж магадгүй. Манай байгууллагын зүгээс хүүхдийн мөнгийг өөрт нь олгуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй.

(Хяналт шалгалтын үеэр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажилтнуудтай хийсэн бүлгийн ярилцлагаас)

Хүн бүр яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, язгуур угсаа, бусад ялгааг эс харгалзан хүний эрх, эрх чөлөөг алагчлалгүйгээр эдлэх нь хүний эрхийн үндсэн зарчим мөн. Энэхүү эрх, эрх чөлөө нь Хүний эрхийн түгээмэл

³⁴Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл.92-97 хуудас.2012 он.

тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн талаарх бусад гэрээ, конвенцоор баталгаажсан байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25.1-д “хүн бүр хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг тохиолдолд төрөөс эд мөнгөний тусламж авах эрхтэй”, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдлаар ... ялгаварлан гадуурхаж үл болно”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д “Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй.” гэж тус тус заажээ.

Гэвч иргэний бичиг баримтгүй байнгын асруулагчдын хувьд төрөөс олгож буй нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, төрийн үйлчилгээнд бүрэн хамрагдахгүй байгаа нь олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан эрхээ эдэлж чадахгүй байгаагийн илрэл юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн суурь гэрээнүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг тусгасан анхны баримт бичиг нь Хүүхдийн эрхийн тухай (1989) конвенц юм. Тус конвенцийн 23 дугаар зүйлд “Оролцогч улсууд өөрийнхөө боломжид түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой хүүхдийн нэр төрийг хүндэтгэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд бүрэн дүүрэн, зохистой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой хүүхдийг асран хамгаалахад бололцооныхоо хэрээр туслалцаа үзүүлэх, онцгой анхаарал халамж тавих үүрэгтэй” болохыг заажээ.

Иймд асрамжийн клиникт асруулж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдарч буй орчин нөхцөлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, тэдний хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангахад шаардагдах төсвийг шийдвэрлэх нь зүйтэй юм.

1.2.1.2 Сэтгэцийн эмгэг судлалын клиник

Сэтгэцийн хөнгөн хэлбэрийн эмгэгтэй эмчлүүлэгч Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн поликлиникийн кабинетуудаар нийгмийн нөхөн сэргээх, сэтгэл засал, эмийн эмчилгээг 1-3 сарын хугацаанд эмчийн хяналтан дор хийлгэж, эдгэрэл сайжрал авсан тохиолдолд харъяа аймаг, дүүргийн сэтгэц наркологиын кабинетийн эмчийн хяналтад шилжүүлдэг байна.

Харин 22 хам шинж бүхий сэтгэцийн хурц солиорол, эмгэг илэрсэн эмчлүүлэгчийг тодорхой хугацаагүйгээр эдгэрэл авах хүртэл нь I-VI клиникт хэвтүүлэн эмчилдэг бөгөөд нийт 255 өвчтөнг хүлээн авах боломжтой. Хяналт шалгалтын үеэр 1-22 жилийн хугацаанд хэвтэн эмчлүүлсэн 17-69 насны 285 хүн (1 хүн 37 жил) байв.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2014 оны 233 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар хурц эмгэг өвчтэй хүмүүсийг I-VI клиникт дүүрэг, орон нутгаар нь ангилан хэвтүүлж эмчлэх клиникийн хуваарилалтыг баталсны дагуу 2015 онд нийслэлээс 2475, орон нутгаас 597 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна. Үүнээс эрэгтэй 11, эмэгтэй 6 нийт 17

эмчлүүлэгчийг ар гэрийхэн нь тэдэнтэй харьцах сонирхолгүй, очих өөр газаргүй гэх шалтгаанаар байнга хэвтэн эмчлүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 5392:2013 стандартын 4.2.6-д “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, халдварын эсрэг дэглэмийг мөрдөж сэтгэц мэдрэлийн ба наркологийн эмнэлгийн нэг оронд ногдох талбай буюу нэг үйлчлүүлэгчид ногдох талбайн хэмжээ 6 мкв байх”-аар заасан бөгөөд нэг өрөөнд 3-7 асруулагч амьдарч, нэг асруулагчид 2-4 мкв талбай ногдож байгаа нь дээрх стандартын шаардлагыг хангахгүй байна.

Мөн Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа тусгай мэргэжлийн төв MNS6330-2:2012 стандартын 12.8.4-т “цагаан хэрэглэл нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.” гэж заасан байх боловч тус асрамжийн клиникид асруулагчдын өрөөний тохижилт муу, орны цагаан хэрэгсэл өнгө алдаж, бөөсөрсөн байдалтай байв.

Асрамжийн клиникийн өрөөний талбайн хэмжээг хүснэгтээр харуулбал:

Өрөөний дугаар	Хэвтэн эмчлүүлэх орны тоо	Өрөөний нийт талбайн хэмжээ	1 хүнд ногдох өрөөний стандарт хэмжээ	Нэг хүнд ногдож буй талбайн хэмжээ
№201	6	19 м ²	6м ²	3,1 м ²
№202	7	14,3 м ²	6м ²	2,04 м ²
№204	6	18,3 м ²	6м ²	3,05 м ²
№207	3	19,1 м ²	6м ²	6,3 м ²
№209	4	19,4 м ²	6м ²	4,8 м ²

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх хэсэгт “сэтгэцийн эмгэгтэй хүнийг хоол, хувцас, орон байраар хангах, асран халамжлах үүрэгтэй.”, мөн зүйлийн 11.1.5 дахь хэсэгт “сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмнэлгээс гаргах ... үүрэгтэй.”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно” гэж тус тус заасан боловч Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлж эдгэрэл сайжрал авсан эмчлүүлэгчийг эмнэлгээс гаргахар ар гэрт нь хандахад ирж авдаггүй, эмнэлгийн байгууллага эмчлүүлэгчийг өөрсдийн зардлаар орон нутагт хүргэж өгөхөд хүлээн авахаас татгалздаг байна. Иймээс гэр бүлийн гишүүн, үр хүүхдээ тэжээн тэтгэхээс зайлсхийж буй хүмүүст холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцдог байх шаардлагатай байна.

Тохиолдол:

Өвчтөнийг эмнэлгээс гаргах тухай ар гэрт нь мэдэгдэхэд ирж авдаггүй. Зарим тохиолдолд эмнэлэг зардал гаргаж өвчтөнийг орон нутагт нь хүргэж өгөхөд ар гэрийнхэн нь хүлээж авдаггүй, гэртээ оруулдаггүй. Ийм байдалтайгаар эмнэлэгт урт хугацаагаар хэвтэж байгаа 5-6 хүн байна. Мөн ар гэрийнхэн нь гэртээ байлгахыг хүсээгүйгээс өвчин сэдрээгүй байхад хуурамч дуудлага өгч хэвтүүлэх шалтаг тоочдог. Түргэн тусламжийн 103 дугаарын дуудлагаар 1 эмч, 1 сувилагч дуудлагад

явдаг. Эмч нарын аюулгүй байдлыг хангаж, хамгаалах хэрэгсэл хэрэглэх боломжгүй. Дуудлагаар явахар өвчтөний ар гэрийхэн гарч зугтах, өвчтөн эмч рүү дайрч цохих, нулимаж, доромжлох асуудал их тохиолддог. Цагдаагийн албан хаагчийн тусламжийг авах хуулийн заалттай ч цагдаагийн албан хаагч тэр бүр тусламж үзүүлж чаддаггүй. Иймээс 103 дуудлагаар явахдаа тусгайлан хамгаалагчтай байх шаардлагатай байдаг.

(Хяналт шалгалтын үеэр эмч нартай хийсэн ярилцлагаас)

1.2.1.3 Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник буюу хуулийн тасаг

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүх хэргийг шийдвэрлэх үед сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний нь дараа ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэх”-ээр заажээ.

Тус тасагт шүүхийн шийтгэх тогтоолоор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 23 хүн (эрэгтэй 15, эмэгтэй 8) эмчлэгдэж байгаагийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91 дүгээр зүйл ангиар буюу хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн 21 хүн, мөн хуулийн 145 зүйл ангиар буюу бусдын эд зүйлийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 2 хүн тус тус албадан эмчлэгдэж байна.

Албадан эмчлүүлж буй 23 эмчлүүлэгчээс 5 нь хэрэг хариуцах чадваргүй оюун ухааны хомсдол эмгэгтэй бөгөөд хөнгөн хэлбэрийн хомсдолоос бусад хүндэвтэр, хүнд, гүнзгий хэлбэрийн хомсдол нь эмийн эмчилгээнд огт засрал авдаггүй байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар нийт 12 өвчтөнг (2013 онд 3, 2014 онд 1, 2015 онд 8) сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эдгэрэл сайжрал авсан гэх үндэслэлээр шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээг цуцалжээ. Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд шүүхээс насанд хүрээгүй этгээдийг албадан эмчлэх шийдвэр гараагүй байна³⁵.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан “Албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалтын журам”-ын 2.2-т “Эмнэлгийн цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, хаалга нь онгойлгох хязгаарлагчтай, хянах шагайвартай, байр нь бүрэн гэрэлтүүлэгтэй, гадна орчноос тусгаарлагдсан хашаатай байх бөгөөд дохиоллын болон телекамерын хяналттай байж болно” гэж заажээ.

Эрүүл мэнд, спортын сайдын 2014 оны 180 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар “нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн байдлыг ажиглаж тогтоох зорилгоор хоногийн 24 цагийн турш тасралтгүй хараа хяналтад эмчилгээ, асаргаа, сувилгаа хийхийн тулд тусгаарлах өрөөнд байлгана” гэж заасны дагуу тусгаарлах өрөөг ажиллуулж байна.

Тохиолдол:

³⁵Комисст Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр statistic@ncmh.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн судалгаа, мэдээлэл.

Шүүхийн шийдвэрийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдаж эмчлүүлж байгаа этгээд нь эмнэлгийн стандартад нийцсэн орчин нөхцөл бүхий өрөө тасалгаанд эмчлүүлэх ёстой. Тиймээс хуулийн тасгийн өрөөнүүдийн хаалгыг сараалжин төмрөөр хийх, шагайвар гаргах нь эмнэлгийн нөхцөлд тохирохгүй, өвчтөнг ийм өрөөнд байрлуулж эмчлэх нь эмчилгээний үр дүнд ч сайнаар нөлөөлөхгүй.
(Хяналт шалгалтын үеэр эмч нартай хийсэн ярилцлагаас)

Тус клиникт эмчлүүлэгчид нь шүүхийн шийдвэрээр албадан эмчлүүлж байгаа хэдий ч сэтгэцийн эмгэгийг эмчлэх стандартын дагуу эмчилгээг хийх, эмийн эмчилгээнээс гадна тухтай орчин нөхцөл, зөв харилцаа, эерэг хандлага эмчлүүлэгчийн сэтгэл зүй, эмчилгээний үр дүнд сайнаар нөлөөлдөг байна.

Хяналт шалгалтын дүнгээс үзэхэд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчдын эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах саналыг хүргүүлж байна.

- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Б блок дахь хоол үйлдвэрлэлийн газрыг засварлах, агааржуулалтыг сайжруулах, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж хэвших;
- Өвчтөн түүний ар гэрээс удирдлагад гаргасан өргөдөл, гомдлын бүртгэлийг тусад нь бүртгэж, холбогдох хууль журмын дагуу бүрэн хөтөлж хэвших;
- Хуулийн тасаг болон хурцын тасгийн өвчтөний орны гудас, цагаан хэрэгслийг шинэчлэх, өрөөнүүдийн агааржуулалтыг сайжруулах, хяналтын камерыг засварлах;
- IV дүгээр клиникийн хурцын тасгийн өвчтөнийг ундны ус чөлөөтэй авч хэрэглэж байх боломжоор хангах
- Хүүхэд бүрт төрөөс олгож буй мөнгөн тэтгэмжийг авахад асрамжийн клиникийн байнгын асруулагч хүүхдүүдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;
- Бичиг баримтгүй асруулагчдыг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж, нийгмийн халамжийн тэтгэвэрт хамруулах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хандаж шийдвэрлүүлэх;
- Төрсний гэрчилгээгүй хүүхдүүдийг бичиг баримтжуулах, иргэний бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;
- Асрамжийн клиникийн хүүхдийн өрөөний тохижилтыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлд нь тохирсон тусгай хэрэглэгдэхүүнээр боломжийн хэрээр хангах;
- Хуулийн тасгийн өвчтөний байрлаж буй өрөөний хаалга, цонхыг “Албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалтын журам”-д нийцүүлэн засч сайжруулах арга хэмжээ авах;
- Сэтгэцийн эмгэгтэй асран хамгаалах хүнгүй байнгын байрлаж буй асруулагч нарт зориулсан асрамжийн газрыг нэн даруй байгуулах асуудлыг холбогдох газарт дахин уламжлах;

1.2.2 Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлэгчдийн эрхийн хэрэгжилт

Төв аймгийн Баян суманд байрлах Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах болон мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын үйл ажиллагаа явуулж буй барилга нь 1978 онд ашиглалтад орсон бөгөөд уг барилгад харж хандах хүнгүй сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг асрах үйл ажиллагаа явуулж байсан “Сэтгэцийн өвчтөний хөдөлмөр, эмчилгээ асрамжийн газар”-ыг Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2003 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 94/158 дугаар хамтарсан тушаал, захирамжаар

татан буулгаж, Сэтгэцийн клиникийн эмнэлэгт нэгтгэж, барилгыг нь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяанд шилжүүлжээ³⁶.

Тус газар үйл ажиллагаандаа Согтуурах болон мансуурах донтой өвчтөнийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль (2000), Улсын Ерөнхий Прокурор, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2006 оны 107/А58 тоот хамтарсан тушаалаар баталсан “Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нөхцөл дэглэмийн журам”, Монгол Улсын Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/227 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Баривчлах шийдвэр биелүүлэх журам”, Монгол Улсын Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2002 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 311 дүгээр тушаалаар баталсан “Албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалтын журам”, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах болон мансуурах донтой өвчтөнийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/14 дугаартай тушаалаар баталсан “Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх газрын эмнэлгийн дотоод журам” болон “Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлүүд” 4621:2008 стандарт, “Архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн оношлогоо, эмчилгээ” MNS 5396-2:2004 стандарт, “Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа эрхлэх тусгай мэргэжлийн төв” MNS 6330-2:2012 зэрэг хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь эмнэлэг болон хөдөлмөр хийлгэх нэгжээс бүрдэх бөгөөд түүний албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн байгууллага, албадан хөдөлмөрлүүлэх мэргэжлийн удирдлага болон харуул хамгаалалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тус хэрэгжүүлж байна.

Согтуурах болон мансуурах донтой өвчтөнийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд сум, баг, хорооны Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, цагдаагийн байгууллага, иргэн нийгмийн хэв журмыг зөрчсөн³⁷ этгээдийг согтуурах, мансуурах өвчтэй эсэх талаар дүгнэлт гаргуулахаар эмнэлгийн байгууллагад хүсэлт гаргах бөгөөд³⁸ согтуурах болон мансуурах донтой өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон, нийгмийн хэв журмыг зөрчсөн, сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн буюу эмчлүүлсний дараа согтууруулах ундаа, мансууруулах бодис дахин хэрэглэсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт явуулж албадан эмчлэхээр³⁹ заасан байна.

Тус газарт албадан эмчлэгдсэн өвчтөний судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 2013 онд 685, 2014 онд 381, 2015 онд 550 нийт 1616 өвчтөн эмчлэгдсэнээс 1523 эрэгтэй, 122 эмэгтэй өвчтөн эмчлүүлснээс давтан ирж эмчлүүлж байгаа 544, анх удаа ирж эмчлүүлж байгаа 1075 өвчтөн байна.

³⁶Төрийн өмчийн хорооны 2003 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 351 дүгээр тогтоол.

³⁷Монгол Улсын Дээд Шүүхийн 2007 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар тогтоол.

“Нийгмийн хэв журам зөрчсөн” гэдэгт нийгмийн хэв журмыг зөрчиж, захиргааны арга хэмжээ авагдсан, эсхүл авагдаагүй боловч эрх зүйн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хамааруулна.” гэж заасан байна.

³⁸Согтуурах болон мансуурах донтой өвчтөнийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг. 2000 он.

³⁹Согтуурах болон мансуурах донтой өвчтөнийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг. 2000 он.

Тэдгээрийг насны ангилалаар нь авч үзвэл 20-29 насны 109, 30-39 насны 557, 40-49 насны 658, 50 дээш насны 290 өвчтөн эмчлэгджээ⁴⁰.

Улсын Ерөнхий Прокурор, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2006 оны 107/А58 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нөхцөл дэглэмийн журам”-ын 2.5-д “өвчтөн этгээдийг хүйсээр, эмчилгээний чиглэлээр, биеийн байдлыг харгалзан ангилан байрлуулна.” гэж заасны дагуу хэвтэн эмчлүүлэх 3 байранд өвчтөнүүдийг ангилан байрлуулжээ. Байрны багтаамжийн хувьд 75 өвчтөн хүлээн авах хүчин чадалтай хэдий ч хяналт шалгалтын үеэр эрэгтэй 79, эмэгтэй 9 нийт 88 өвчтөнтэй ачаалал нь хэтэрсэн байдалтай байв.

Мөн Улсын Ерөнхий Прокурор, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2006 оны 107/А58 тоот хамтарсан тушаалаар баталсан Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нөхцөл дэглэмийн журмын 2.4-т “Эмнэлгийн цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, гадна хаалга нь онгойлгох хязгаарлагчтай, өвчтөний өрөө болон эмчилгээний өрөөний хаалга нь гаднаас хянах шагайвартай, байр нь байгалийн, зохиомол гэрэлтүүлэгтэй, салхивчтай, барилга нь гадаад орчноос тусгаарлагдсан хашаатай, тусгаарлах өрөөтэй байх бөгөөд дохиоллын болон телекамерын хяналттай байна.” гэж заасан байна. Гэтэл өвчтөнүүдийн өрөө тус бүртээ хаалгатай боловч онгойлгох хязгаарлагч, шагайваргүй, дохиоллын болон телекамерын хяналтгүй байгаа нь дээрх журмын заалтад нийцэхгүй байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392:2013 стандартын 7-д эрүүл мэндийн байгууллагын угаалга, цэвэрлэгээг хэрхэн хийх талаар нарийвчлан тусгасан байх ба уг стандартын 7.1.2-т “хонгил, сургалтын болон ажилчдын амрах өрөө, агуулах зэрэг хамаарах бөгөөд цэвэрлэгээг угаалгын бодистой ус ашиглан өдөр бүр хийнэ”, 7.1.5-д “өдөр тутмын буюу байнгын цэвэрлэгээг тухайн тасаг, нэгжийн ажил үйлчилгээнээс хамаарч хийнэ. Их цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа хийнэ.”, “их цэвэрлэгээг бүх гадаргуу /хана, тааз, шал/, хаалга, цонх, шат, хаалганы бариул, шугам хоолой, болон тавилга хэрэгсэл, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж буй бүх тоног төхөөрөмжийг хамруулан хийх”, мөн Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/227 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Баривчлах шийдвэр биелүүлэх журам”-ын 7.4.3-т “өглөө боссоны дараа баривчлагдсан этгээдүүдийн хөнжил, гудсыг нэгдсэн журмаар салхинд гаргуулах”-аар тус тус заажээ.

Гэвч өвчтөний 1, 3 дугаар байранд засвар огт хийгээгүй, өрөө нь бохир ариутгал цэвэрлэгээ муу, хувцас хадгалах шүүгээгүй тул өвчтөнүүд орон доогуураа цаасан хайрцагт хувцас, эд зүйлсээ хийсэн, мөн зарим өрөөнд хуучирч эвдэрсэн хувцасны шүүгээ байх боловч тэнд олон өвчтөний хувцас, гутал холилдсон, өвчтөнүүдийн төмөр ор, гудас, хөнжил, цагаан хэрэглэл, ор дэр хуучирч элэгдсэн, бөөсөрсөн, маш бохир, угаалга ариутгал халдваргүйжүүлэлт хийгдээгүйгээс гадна ор, дэрний цагаан хэрэглэлгүй өвчтөнүүд ч цөөнгүй байв.

Харин хэвтэн эмчлүүлэх 2 дугаар байранд 2015 онд 16 сая төгрөгөөр урсгал засвар хийж байрыг бүхэлд нь засч, ариун цэврийн өрөө, угаалтуур,

⁴⁰Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын Согтуурах болон мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт 2016 оны 1 дүгээр сарын 16 ны өдөр хийсэн хяналт шалгалтын материалаас.

хувцас хадгалдаг тусдаа өрөө зэргийг тохижуулан сайжруулсан нь 1, 3 дугаар байрны нөхцөл байдалтай харьцуулахад эмнэлгийн орчин нөхцөлийг тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Тохиолдол:

Би Улаанбаатар хотоос 2015 оны 11 дүгээр сард шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэгдэхээр ирсэн. Одоо галчаар ажиллаж байна. Ирээд 2 сар гаруй хугацаа өнгөрөхөд миний ор, дэрний цагаан хэрэгзэлийг 2 удаа л сольсон.

(Өвчтөнтэй хийсэн ярилцлагаас)

Тус газрын үйл ажиллагаанд 2007 онд Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газраас шалгалт хийж, эмчилгээ оношилгоо, эм, био бэлдмэлийн хяналт, эрүүл ахуйн халдвар судлалын хяналт гэсэн чиглэлээр улсын байцаагчийн дүгнэлт гарч, илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлж байжээ⁴¹. Үүнээс хойш мэргэжлийн хяналтын байгууллага болон эрүүл мэндийн байгууллагаас шалгалт огт хийгдээгүй байна.

Өвчтөнүүдэд олгож буй хоолны илчлэг тодорхойгүй, мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулаагүй, хоолны дээжийг авдаггүй, тэмдэглэл, технологийн карт хөтлөөгүй байгаа нь Эрүүл мэндийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2005 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 188/152 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх журам”-ын 2.10-т “Өвчтэй этгээдийн эмчилгээний хоол болон ердийн хоолны хоногийн илчлэг нь 3400 ккал-оос багагүй байх бөгөөд хоолны илчлэгийг мэргэжлийн байгууллагаар сар бүр тодорхойлуулна.” гэж заасныг зөрчиж байна.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Нийгмийн эрүүл мэндийн төв лабораторийн 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 738 дугаар дүгнэлтээр гүний худгийн ундны усны шинжилгээг хийлгэхэд ус нь зөвшөөрөгдөх хэмжээнд байсан бөгөөд түүнээс хойш дахин шинжилгээ хийлгээгүй байна.

Өвчтөнүүдийг цагийн хуваарийн дагуу халуун усанд оруулдаг байх бөгөөд усны шүршүүр хуучирч эвдэрсэн, цэвэрлэгээ хийгээгүй бохир, хана, таазны шохой нурсан, мөөгөнцөртсөн, чийг ихтэй байв. Мөн нийт өвчтөнүүдийн хувцас, цагаан хэрэглэлийг угаах ахуйн хэрэглээний нэг угаалгын машин нь эвдэрсэн, ариутгал халдваргүйжүүлэлт хийгдээгүй байсан нь өвчтөнүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөр байх тул тэдгээрийг яаралтай засаж сайжруулах шаардлагатай юм.

Тус газарт Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 2007 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс 2017 оны 1 дүгээр сарын 8 -ны өдрийг хүртэлх хугацаанд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх 1470001024 дугаартай тусгай зөвшөөрлийн улсын бүртгэлийн гэрчилгээг олгосон байх бөгөөд амбулатори болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэггүй, зөвхөн хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг үзүүлж байна.

Тэрээр тус газрын эмнэлэг нь 3 их эмч, 1 бага эмч, 9 сувилагч нийт 13 ажилтантай үйл ажиллагааг явуулж байх бөгөөд асрагчийн орон тоо байдаггүй байна.

⁴¹Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2007 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 46/17/11, 440/16, 24/07 дугаартай улсын байцаагчийн дүгнэлт.

Мөн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эм, эмийн хэрэгслийг бүрдүүлсэн боловч эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хангалтгүй байв⁴².

Шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлүүлэхээр ирсэн өвчтөнд их эмч, наркологийн эмч үзлэг хийсний дагуу өвчний түүх нээж, анх удаа ирсэн өвчтөнг 3 сараас 6 сар, давтан ирсэн өвчтөнг 6 сараас 1 жил хүртэлх хугацаанд хордлого, шарталт тайлах, биеийн эсэргүүцэл сайжруулах, шинж тэмдгийн, витамин, архины дур дарах, архинд харшил үүсгэх буюу архи зохихгүй болгох зэрэг эмийн болон сэтгэл заслын эмчилгээг хийдэг байна.

Лабораторид шинжилгээ хийхэд ашиглагдаж байгаа бодис, хэрэглэгдэхүүнээс 8 төрлийн 40 ширхэг бодис, 10 ширхэг 1 удаагийн зүүний хугацаа дууссан байгаа нь Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэгт “Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаажуулалтгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэхийг хориглоно.” гэж заасныг зөрчсөн байна.

Монгол улс 2005 онд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц⁴³, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцод⁴⁴ тус тус нэгдэн орж, соёрхон баталсан билээ.

Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцийн 2.1-т “Энэхүү конвенцод зааснаар “албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр” гэж ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, чингэхдээ уг этгээд нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил буюу үйлчилгээг хэлнэ.” гэж тодорхойлсон бөгөөд мөн конвенцийн 2.2-т “хуулийн дагуу цэргийн шинжтэй ажил гүйцэтгэхтэй холбогдсон аливаа ажил буюу үйлчилгээ, шүүхийн шийдвэрээр ногдуулсан шийтгэлийн үр дүнд аливаа этгээдээр гүйцэтгүүлэх ажил буюу үйлчилгээ, онцгой нөхцөл байдалд гүйцэтгэх ажил, үйлчилгээ, олон нийтийн ашиг тусын тулд иргэний ердийн үүрэг гэж үзэж болох хамтын шинжтэй жижиг үйлчилгээ” зэргийг албадан хөдөлмөрт тооцохгүй гэж заасан байна.

Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцийн 1 дүгээр зүйлд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглож, “улс төрийн нөлөөнд оруулах болон хүмүүжлийн арга хэрэгсэл болгох, эсхүл улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны эсрэг чиглэсэн улс төрийн үзэл бодол буюу оюун санааны үзэл бодолтой байх, түүнийг илэрхийлсний төлөө ногдуулах шийтгэл болгох, эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор ажиллах хүчийг дайчлах, ашиглах арга хэлбэр болгох, хөдөлмөрийн сахилга батыг сахиулах арга хэрэгсэл болгох, ажил хаялтад оролцсонд оногдуулах шийтгэл болгох, арьс өнгө, нийгмийн байдал, яс үндэс, шашин шүтлэгээр алагчлах арга хэрэгсэл болгох” зорилгоор ашиглахыг таслан зогсоохыг конвенцод нэгдэн орсон гишүүн орнуудад үүрэг болгожээ.

⁴²Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа эрхлэх MNS 6330:2012 Монгол Улсын стандартын В хавсралт, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 Монгол Улсын стандарт.

⁴³Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны удирдах зөвлөлөөс 1930 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Женев хотноо зарлан хуралдсан 14 дэх чуулганаар баталсан.

⁴⁴Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны удирдах зөвлөлөөс 1957 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Женев хотноо зарлан хуралдсан 14 дэх чуулганаар баталсан.

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь хэсэгт “гүйцэтгэсэн ажлын хэмжээ, чанарт тохирсон цалин хөлс олгох ба энэ хөлсний хэмжээ нь Засгийн газраас баталсан цалин хөлсний доод хэмжээнээс доошгүй байх.”, мөн зүйлийн 13.6 дахь хэсэгт “Албадан хөдөлмөрлөж байгаа этгээдийн цалин хөлсийг картаар тооцно.” гэж заасан байх боловч өвчтөнүүдийг байгууллагын гадна, доторх орчинг цэвэрлүүлэх, гадна хамгаалалтын хашааны нүүрэн хэсэг болон албаны хашаан доторх замын хажуугийн хайсыг шохойдуулах, барилгын засвар хийлгэх, хүлэмжид өргөст хэмх, улаан лооль тариалах, цэцгийн мандал хийлгэх, будуулах, ногоо тарих, хураах, гал тогоонд туслах, бэлтгэгч, халуун ус ажиллуулах, сумын төвийн зам дагуух цэвэрлэгээ үйлчилгээнд ямар ч цалин, хөлсгүйгээр ажиллуулж байна.

Тус газарт эмчлүүлж буй өвчтөнүүд нь гэм буруугийн улмаас шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүс бус харин согтуурах, мансуурах донтох өвчнөө эмчлүүлж байгаа өвчтөнүүд учраас тэдэнд хуульд заасны дагуу хийсэн ажил хөдөлмөрт нь тохирсон цалин хөлсийг олгохгүй байгаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжийн холбогдох заалтыг зөрчиж байна.

Тохиолдол:

Би архинд донтох өвчнөө эмчлүүлэхээр ирээд нэг сар болж байна. Энэ хугацаанд гал тогоонд бэлтгэгч, байрны цэвэрлэгээ хийх, тохижилтын ажилд туслах зэргээр байгууллагын удирдлагын зүгээс хий гэсэн ажил болгоныг тогтмол хийж байна. Гэвч цалин хөлс гэж огт авдаггүй, цалин өгдөг гэдгийг ч мэдэхгүй, ар гэрээсээ мөнгө авдаг.

(Хяналт шалгалтын үеэр өвчтөн эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

Хяналт шалгалт, судалгааны үр дүнг дүгнэж, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах болон мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлж буй өвчтөнүүдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх, албадан хөдөлмөрөөс ангид байх эрхийг хангах чиглэлээр дараах саналыг гаргаж байна.

- Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн “албадан хөдөлмөр хийлгэх” гэснийг хасч Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцийн заалтад нийцүүлэн, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх газрыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд шилжүүлэх;
- Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын байрны нөхцөл байдлыг сайжруулж, барилгын засвар үйлчилгээг сайжруулахад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх;
- Өвчтөний ерөөнүүдийн хаалгыг Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2006 оны 107/А58 тоот хамтарсан тушаалаар баталсан “Албадан эмчлэх, албадан хөдөлмөр

- хийлгэх газрын нөхцөл дэглэмийн журам"-ын 2.4 дэх хэсэгт заасан шаардлагад нийцүүлж хаалгыг шагайвартай, хязгаарлагчтай болгох;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;
 - Яаралтай тусламжийн эм тарианы хайрцагт байвал зохих бүрдүүлбэрийг бүрэн болгох, хугацаа дууссан эм тариаг цаг тухайд нь устгаж, акт үйлдэх;
 - Өвчтөний 1, 3 дугаар байр болон халуун усны газар, угаалгын өрөөний нөхцөл байдлыг сайжруулж, өвчтөн тус бүрт хувцас, эд зүйл хадгалах шүүгээтэй болгох, өрөөнүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу хийж хэвших;
 - Өвчтөнүүдийн ундны цэвэр усаар хангагдах эрхийг хангаж, унданд хэрэглэгдэж буй гүний худгийн усны шинжилгээг тогтмол хийлгэж байх;
 - Хоолны дээжийг тухай бүр шинжилгээнд хамруулж, Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулж хэвших;

1.2.3 Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн харьяа Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байраар үйлчлүүлж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилт

Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байрыг анх 1996 онд нээж, гэр орноосоо дайжсан, хүчирхийлэлд өртөж гудамжинд гарсан хүүхдүүдийг авчирч эцэг эхэд нь хүлээлгэж өгөх, эсвэл улсын асрамжийн газарт шилжүүлдэг байжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 01 дугаар сарын 11-ний өдрийн “Нийслэлийн цагдаагийн газрын бүтэц, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг батлах тухай” 71 дүгээр тушаалаар Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг шинээр байгуулж, улмаар нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хохирогчийг түр хамгаалалтад авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах чиг үүрэгтэй “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр”-ыг тус хэлтсийн харьяанд байгуулсан байна.

Тус байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой өдөрт дунджаар 50-иас доошгүй мэдээллийг утсаар хүлээн авдаг бөгөөд дүүргийн цагдаагийн хэлтсээс нөхцөл байдлыг шалгаж Түр хамгаалах байранд авах эсэхээ шийддэг байна. Энд үйлчлүүлж буй хохирогчдын 20-30 хувь нь өөрсдөө ирсэн хүмүүс байдаг бол үлдсэн хувийг дүүргийн цагдаагийн хэлтсүүдээс шилжүүлж авчирсан хүмүүс эзэлж байна.

Түр хамгаалах байрны үйл ажиллагаа явуулж буй одоогийн байрны зүүн жигүүрийн барилгыг Богд хааны хатан Дондогдуламын гал тогооны байрны зориулалтаар 1920-иод оны эхэн үед барьсан бөгөөд барилгын зүүн талын гадна хананд тулгаж 18,3 м*13,9 м хэмжээтэй 1 давхар өргөтгөлийн барилгыг 1992 онд барьж ашиглалтад оруулсан байна. Дээрх зүүн жигүүрийн барилгад түр хамгаалах байрны гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэдийг байрлуулах амралтын өрөөнүүд, гал тогооны өрөө, хоолны танхим, агуулах байдаг. Энэ хэсэг нь 2008 онд Нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын

дурсгалын жагсаалтын 5 дугаарт соёлын өвд бүртгэгдсэн⁴⁵ бараг зуугаад жилийн насжилттай маш хуучин барилга юм.

Түр хамгаалах байранд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдөр шалгалт хийж, барилгын төлөв байдалд дүгнэлт гаргасан байна. Дүгнэлтээр⁴⁶ барилгын дээврийн хучлагын хар төмрийн имхэрдлэг задарсан, усанд идэгдэж зэвэрч цоорсноор бороо, цасны ус барилгын адраар нэвчиж, шувуу нурууны модон хучилт, банз зэрэг модон хийц нь ус чийгэнд идэгдэж өгөршин доошоо цүлхийснээс таазны шавардлага хагарсан, ханын шургааг мод өгөршиж ялзарсан, хөрсний овойлт, гэсэлт зэрэг хөрс эзэлхүүнээ өөрчлөх хэв гажилтын нөлөөгөөр барилгын сууринд ан цав гарч эвдэрснээс үүдэн гадна, дотор хана сууж хөндлөн болон дагуу чиглэлд ан цав үүсч хагарсан байна гэжээ. Мөн дээрх нөхцөл байдал нь Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “барилга байгууламж нь хүн ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байна.” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул тус барилгад бүрэн хэмжээний их засвар хийх шаардлагатай гэсэн дүгнэлтийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас Нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлсэн боловч одоог хүртэл бүрэн хэмжээний их засварын ажил хийгдээгүй байна.

Түр хамгаалах байрыг анх байгуулахад Хууль зүйн яамны санхүүжилтээр 2013 оны 11 дүгээр сард 42 сая төгрөг төсөвлөн өрөөнүүдийн дотор талын засвар, өрөөний тохижилтыг хийсэн бөгөөд 2015 онд дээврийн засварт 3,2 сая төгрөг, Хууль зүйн яамны санхүүжилтээр ариун цэврийн өрөөний засварт 13 сая төгрөгийн төсвийг тус тус зарцуулж⁴⁷ урсгал засварын ажил хийсэн боловч ямар ч үр дүнгүй болдог байна. Уг барилгыг Нийслэлийн төсвийн санхүүжилтээр 2013 онд шинээр барих барилга байгууламжийн жагсаалтад⁴⁸ оруулан, 2014 онд Улаанбаатар хотын Цагдаагийн газраас шинээр барих барилгын ажлын төсөвт өртгийг 2 166 890 052 (хоёр тэрбум нэг зуун жаран зургаан сая найман зуун ерэн мянга тавин хоёр) төгрөг байхаар тооцоолсон байна⁴⁹.

Хяналт шалгалтын үед тус байрны төв хаалга, ажилтны өрөөний дээд хэсэгт чийгтдэг, албан хаагчид байрладаг барилгын зүүн талын хэсэг маш хүйтэн, дээврээс нь дусаал гоожиж муудсан, ажилтнуудын ажлын өрөө буюу жижүүрийн өрөөний таазнаас ус гоождог, ус гоождог хэсгийн чанх дор цахилгааны утас татсан, ажилтнуудын болон үйлчлүүлэгчдийн ариун цэврийн өрөөнүүд шаардлага хангахгүй, бохир нь хальдаг, ундны ус зэвтэй гардаг зэрэг нөхцөл байдалтай байв.

Эдгээр нөхцөл байдал нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүн бүр хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах...”, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “...хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах...”, Эдийн засаг, нийгэм,

⁴⁵Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт.

⁴⁶Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2011 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 07-339/2015 дугаартай дүгнэлт.

⁴⁷Комисст Улаанбаатар хотын Цагдаагийн газраас 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

⁴⁸Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжих шинээр барих барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто замын зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын зургийн даалгавар боловсруулах байгууллагын жагсаалт.

⁴⁹Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхэд хамгаалах, хаяг тогтоох төвийн барилгын ажлын төсөвт өртөг. Монгол улсын мэргэшсэн төсөвчин А.Эрдэнэбаатар, төсөвчин Х.Болор-Од. 2014 он.

соёлын эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 12.2.b-д “...орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах...” Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” зэрэг ажилтнуудын үндсэн эрх, түр хамгаалах байраар үйлчлүүлэгчийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна.

Тохиолдол:

Ажилтнуудын ажлын өрөөний нөхцөл хүнд, өвөлдөө маш хүйтэн, зундаа борооны ус шууд орж ирдэг. Жижүүрийн өрөө хүйтэн учраас тень залгаж халааж байна. Цонхоор салхи сийгдэг. Хана, тааз, өрөө тасалгаа мөөгөнцөртсөн. Ажилтнуудын бие засах өрөө бохир. Амьдралын боломж гайгүй зарим үйлчлүүлэгч манай өрөөнүүдийг голдог. Манай албан хаагчдын дийлэнх нь эмэгтэй. Гэтэл ажлын орчин нөхцөл тааруу. Тухайлбал, ариун цэврийн өрөөний зохион байгуулалт муу, бохирын үнэр байнга үнэртдэг зэргийг дурдаж болно. Ажилчдын төдийгүй, хохирогчдын хэрэглэж байгаа ундны уснаас зэв гардаг учраас бид өөрсдөө уух усаа худалдаж авдаг. Үндсэндээ байр өөрөө их хуучных учраас шинээр байр барих хэрэгтэй байна.”

(Хяналт шалгалтын үеэр ажилтнуудтай хийсэн ярилцлагаас)

Түр хамгаалах байр нь нийт 8 өрөөтэй байх бөгөөд тус бүр нь 2 ортой 1-3 дугаар өрөө нь гэр бүлийн, 6 ортой 4 дүгээр өрөөнд охидын, 6 ортой 5 дугаар өрөөнд хөвгүүдийн, тус бүр нь 4 ортой 6-8 дугаар өрөөг нийтийн зориулалтаар ашиглаж байна.

“Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандартын 7.10-т “Барилгын цонх, хаалга бүрэн ажиллагаатай, түгжээтэй, хөшигтэй байх”, мөн тус стандартын 7.5-т “нэг хүнд ноогдох унтлагын өрөөний талбайн хэмжээ 5 метр квадратаас доошгүй байх”-аар тус тус заасан боловч хяналт шалгалтаар Түр хамгаалах байрны өрөөнүүдийн хаалга дотроосоо түгжээгүй, гадна талаас нь түлхүүрээр түгжих боломжтой, өрөө бүр нэг цонхтой, цонхны түгжээ бүрэн ажиллагаагүй, нэг бариул дамжуулан хэрэглэдэг, нэг хүнд ногдох талбайн хэмжээ 1,6-4,8 метр квадрат байгаа нь дээрх стандартын шаардлагыг хангахгүй байна.

Монгол Улсын Дэд бүтцийн яамнаас 2002 онд баталсан “Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД 21-01-02” Монгол Улсын барилгын норм ба дүрмийн 6.12-т 2-оос доошгүй аврах гарцтай байх өрөө, тасалгааг зааж өгсөн бөгөөд үүнд нэг дор 10-аас дээш хүн байх зориулалттай Ф1.1 (сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ахмадуудын асрамжийн болон тахир дутуу иргэдийн тусгай зориулалттай байр, эмнэлэг, сургуулийн хүүхдийн дотуур байр, хүүхдийн байгууллага) ангийн өрөө, тасалгаа мөн нэг дор 50-аас дээш хүн байх зориулалттай өрөө, тасалгаа гэж тусгажээ. Тус байр нь 24 албан хаагчтай, нэг дор 30 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд 2015 он дуустал хүлээн авсан нийт үйлчлүүлэгчийн 61 хувь нь хүүхэд байна. Гэтэл бүх цонх төмөр торон хаалттай, онцгой байдлын үед аврах ганц гарц нь зөвхөн төв хаалга байгаа нь дээрх норм, дүрэмд заасан шаардлагыг хангахгүй байна. Энэ нь газар хөдлөлт, гал түймэр зэрэг гамшиг тохиолдсон үед ажилтан болон үйлчлүүлэгчдийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц нөхцөл байдлыг үүсгэж байна.

Мөн харуул хамгаалалтын дохиоллын сүлжээний тоног төхөөрөмжгүй, байрны дотор талдаа хяналтын 9 камертай, гадна талдаа 2 камертай боловч

2016 оны 1 дүгээр сарын 19-ний байдлаар камерын бичлэг нь хадгалагдаагүй байсан тул үүнийг даруй шийдвэрлэж ажилтан болон үйлчлүүлэгчдийн аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх ёстой юм.

Тохиолдол:

“Бид манайхаар үйлчлүүлж байгаа хохирогчдод 2-3 цагийн зайтай ээлжээр хяналт тавьж ажилладаг. Харин камерын бичлэг хадгалагдахгүй байгаа. Хард диск дүүрсэн учраас нэмж бичлэг хадгалахгүй байгаа. Мэргэжилтнүүд ирж үзээд компьютерыг сайжруулахаас өөр аргагүй гэсэн. Одоогоор Pentium IV компьютер дээр камерын хяналт хийж байна.

(Хяналт шалгалтын үеэр ажилтнуудтай хийсэн ярилцлагаас)

Тус байранд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 онд шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох, илрүүлэх, хохирогчийг түр хамгаалалтад авах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код 326 журмыг удирдлага болгон ажилладаг бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль (1992), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004), Гэр бүлийн тухай хууль (1999), Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль (1996), Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1997), Цагдаагийн албаны тухай хууль (2013), Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013) болон “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандарт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2009 оны 128/188 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтран баталсан “Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай” 2009 оны 308/189/129 дугаар заавар, бусад холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгуулагдсан цагаас хойш 2015 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 540 хүн Түр хамгаалах байраар үйлчүүлснээс 6 хувийг төөрсөн байдалтай олдож ирсэн 31 хүүхэд, 15 хувийг тэнэсэн байдалтай ирсэн 80 хүүхэд, 79 хувийг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 429 хүн тус тус эзэлж байна⁵⁰. Нийт үйлчлүүлэгчийг хүйсийн байдлаар авч үзвэл 4 хүн буюу 1 хувь нь насанд хүрсэн эрэгтэй, 183 хүн буюу 32 хувь нь насанд хүрсэн эмэгтэй, 173 хүн буюу 36 хувь нь эрэгтэй хүүхэд, 190 хүн буюу 31 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Түр хамгаалах байраар үйлчлүүлэхээр ирсэн нийт хүүхдийн 61 хувь буюу 344 хүүхэд нь эцэг эх, асран хамгаалагчаа дагаж ирсэн байна.


Төөрсөн болон тэнэсэн байдалтай ирсэн хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх бөгөөд эцэг эх, асран хамгаалагч нь тогтоогдохгүй байгаа хүүхдийг дүүргүүдийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв рүү шилжүүлэх арга хэмжээ авдаг байна. Дээрх хүүхдүүд ихэвчлэн шөнийн цагаар ирдэг бөгөөд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нь тэр даруй тогтоогдохгүй бол түр хамгаалах байранд хонуулах шаардлага гардаг ажээ.

⁵⁰Комисс 2016 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Түр хамгаалах байранд хийсэн хяналт шалгалтын хийх үед тус илтгэх хуудас.


Түр хамгаалах байранд 2015 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас давтан ирсэн 10 гэр бүлийн 25 (насанд хүрсэн эмэгтэй 10, эрэгтэй хүүхэд 4, эмэгтэй хүүхэд 11) үйлчлүүлэгч байна. Үүнээс 2 удаа ирсэн 8 үйлчлүүлэгч, 3 удаа ирсэн 1 үйлчлүүлэгч, 4 удаа ирсэн 1 үйлчлүүлэгч байна.

Давтан ирсэн 25 иргэнийг насны ангиллаар нь авч үзвэл 0-3 насны 6 хүүхэд, 4-9 насны 7 хүүхэд, 10-15 насны 2 хүүхэд, 20-25 насны 1 хүн, 26-30 насны 4 хүн, 31-36 насны 4 хүн, 42-46 насны 1 хүн байна.

Түр хамгаалах байранд давтан ирсэн үйлчлүүлэгчийг Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв, дүүргүүдийн хорооны хамтарсан баг, Ариун үйлс төрийн бус байгууллага, ар гэр асран хамгаалагчид, дүүргүүдийн хүүхэд гэр бүл хөгжлийн төвүүдэд тус тус хүлээлгэн өгдөг ба эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд анхан шатны тусламжийг үзүүлж, холбогдох эмнэлгийн байгууллага руу шилжүүлдэг байна.



Түр хамгаалах байр нь анх Нийслэлийн цагдаагийн газрын хүүхэд хамгаалах, хаяг тогтоох байр нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан учраас гэр орноосоо дайжсан, гудамжинд гарсан, төөрсөн хүүхдүүд, иргэд одоо ч тус байгууллагад хандаж ирдэг байна.



Түр хамгаалах байранд мөрддөг Цагдаагийн Ерөнхий Газрын даргын баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай код 326 журмын 3 дугаар

хэсэгт “Түр хамгаалах байр гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний хүүхдийг цагдаагийн хамгаалалтад 30 хүртэл хоногийн хугацаагаар түр байрлуулж, түүнд туслалцаа үйлчилгээ үзүүлэх газрыг хэлнэ” гэж тодорхойлжээ. Гэвч дээрх тоо баримтаас үзэхэд нийт хүлээн авсан иргэдийн 21 хувь нь түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх харьяалалд үл хамаарах хүмүүс байгаа нь цаашид түр хамгаалах байрны ачаалал нэмэгдэх тохиолдолд зорилтот бүлэгтээ хүрч ажиллах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний хүүхдийг хамгаалах үндсэн үйл ажиллагаанд хүндрэл учруулах боломжтой юм.

Хяналт шалгалт, судалгааны үр дүнг дүгнэж, түр хамгаалах байраар үйлчлүүлж буй иргэд болон тус байгууллагын ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөдөлмөрийн аятай нөхцөөр хангуулах эрхийг хангах чиглэлээр дараах саналыг гаргаж байна.

- Түр хамгаалах байрны нөхцөлийг зохих стандартын шаардлагад нийцүүлэн даруй шинэчлэх;
- Камерын хяналтын хэвийн ажиллагааг хангах, дүрс бичлэгийг хадгалах техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх;
- Ундны усны чанарыг мэргэжлийн хяналтын байгууллагаар шалгуулж дүгнэлт гаргуулах;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЦАГДАН ХОРИГДОЖ БУЙ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.

(Хүний эрхийн Түгээмэл тунхаглал 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй.

...өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах;

...хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

...өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах буюу байцаалгуулах, эсрэг гэрчтэй адил нөхцлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах болон шалгуулах;

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн (b), (d), (e))

Баривчлах, цагдан хорих арга хэмжээ нь хүний халдашгүй, эрх чөлөөтэй байх үндсэн эрхийг хөнддөг тул гэмт хэрэгт холбогдсон хүн бүр өөрийгөө өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхтэй болохыг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээ, зарчмаар тодорхойлсон болно.

“Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд⁵¹”-д өмгөөлөгчдийг шүүн таслах ажиллагааны гол хөдөлгөгч хүч болохыг тодорхойлсон юм. Тус зарчмуудын 1-д заасны дагуу “Хүн бүр өөрийн эрхийг хамгаалахын тулд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд тусламж авахаар аль ч хуульчид хандах эрхтэй” байна.

Тус зарчмуудын 13 дугаарт заасны дагуу өмгөөлөгч нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулах замаар тодорхой үүрэг, хариуцлага хүлээхийн зэрэгцээ өөрийн үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, үндэсний төдийгүй олон улсын эрх зүйгээр тогтоосон хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хуульчийн мэргэжлийн ёс суртахууны

⁵¹ Куба Улсын Гавана хотноо 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх” Нэгдсэн Үндэстний Байгууллагын VIII их хурлаас баталсан

дагуу хараат бусаар, өөрийн итгэл үнэмшлийн дагуу үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...”, Тавин тавдугаар зүйлийн 1 дэх заалт “Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэж хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс сүүлийн 3 жилийн байдлаар нийт 2036 гомдол хүлээн авч ажиллагаа хийснээс шүүхийн өмнөх шатанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр татагдан цагдан хоригдож буй хүмүүсийн өмгөөлөгч авах эрх, хэргийнхээ талаар хангалттай хууль зүйн туслалцаа авах эрх зөрчигдөж байгаа тухай 286 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2013-2015 онд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрх, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжоор хангах асуудлаар Монгол Улсын Засгийн газар болон хууль хяналтын байгууллагад нэг шаардлага⁵², долоон зөвлөмж⁵³ хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан байна.

Комисс Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2001, 2009, 2010 оны илтгэлдээ өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийн талаар тусгаж, холбогдох санал, зөвлөмжийг өгсөн байна.

Эдгээр санал, зөвлөмжид энэхүү эрхийн хэрэгжилтийг хангуулах, үндэсний хууль тогтоомжийн заалтыг олон улсын хэм хэмжээ, стандарт, шаардлагад нийцүүлэх, ялангуяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дахь өмгөөлөгчийн оролцооны талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, өмгөөлөгчийн эрх үүргийг нэмэгдүүлэх, өмгөөлөгч өөрөө нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх эрх хэмжээтэй болгох боломжийг судлан хэрэгжүүлэх, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг, улсын төсвөөс санхүүждэг өмгөөлөгч бий болгож ажиллуулах журмыг судалж хэрэгжүүлэх, хөдөө орон нутаг дахь өмгөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх, өмгөөлөгчөө сонгох эрхийг байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдод олгох, өмгөөлөгчдийн ёс зүйн асуудалд анхаарах зэрэг асуудлыг тус тус тусгасан байна.

Өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар тусгасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2009 оны илтгэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд 2010 онд 13 дугаар тогтоолыг баталж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн сэжигтэн, яллагдагчийг баривчлах заалт болон өмгөөлөгчийн оролцооны талаарх дотоодын бусад хууль тогтоомжийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хүний эрхийн нийтлэг зарчимд нийцүүлэх чиглэлээр санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан юм.

⁵²Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.

⁵³Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.


Улсын Их Хурлаас 2012 онд Хуульчийн эрх зүйн байдлын тухай, 2013 онд Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийг тус тус баталснаар өмгөөлөгчдийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт тогтолцооны хувьд олон шинэтгэл өөрчлөлтийг хийж, ингэхдээ төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах бие даасан бүтцийг Хууль зүйн яамны харьяанд байгуулсан нь хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл хэрэгт гаргасан ахиц дэвшил боллоо.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцооны талаарх хуулийн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хүний эрхийн нийтлэг зарчимд нийцүүлэх, ялангуяа өмгөөлөгчөө сонгох эрхийг байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдод баталгаатай эдлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.


Комисс 2015 онд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгчөөс үзүүлж буй хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг судалж, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойллоо.

Судалгааны хүрээнд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги, Дархан-Уул аймаг болон Орхон аймаг дахь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албаны Цагдан хорих байранд цагдан хоригдож буй сэжигтэн яллагдагч, шүүгдэгчээс санал асуулга авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд болон Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгчидтэй уулзалт хэлэлцүүлэг хийж, тэдний гаргасан саналыг энэхүү илтгэлд тусгав.

Судалгаанд цагдан хоригдож буй 691 сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцсон бөгөөд тэдгээрийг хүйсийн болон насны байдлаар нь ангилбал 559 буюу 80,8 хувь нь эрэгтэй, 56 буюу 8.2 хувь нь эмэгтэйчүүд байв.



Цагдан хоригдож буй хугацааг асуухад 691 оролцогчоос 90 нь хариулаагүй бөгөөд 601 нь дараах байдлаар хариулсан байна.



Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорьж мөрдөх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамаарч харилцан адилгүй хуульчилсан бөгөөд мөн хуулийн 69, 366 дугаар зүйлүүдэд тус тус заасан цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журам болон насанд хүрээгүй этгээдийг баривчлах ба цагдан хорих үндэслэл журмын дагуу энэхүү арга хэмжээг хэрэгжүүлдэг болно.

Сэжигтнийг хойшлуулшгүй ажиллагаагаар 72 цаг хүртэл хугацаагаар баривчлах, мөн 14 хоногийн хугацаанд багтаан цагдан хорьж мөрдөх бөгөөд үүнд баривчлагдсан хоногийг оруулан тооцно. Харин яллагдагчийг хорьж мөрдөх үндсэн хугацаа 2 сар хүртэл байдаг бөгөөд энэ хугацаанд сэжигтнээр цагдан хоригдсон хоногийг мөн оруулан тооцдог.

Нийт цагдан хорьж мөрдөх хугацаа нь хүндэвтэр гэмт хэрэгт 4 сар, хүнд гэмт хэрэгт 12 сар, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй. Харин зарим гэмт хэргийн яллагдагчийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3-т заасан хугацаанаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх уг хугацааг 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгадаг болно⁵⁴.

Цагдан хорьж мөрдөх хугацааг сунгахдаа мөрдөн байцаагч тогтоол үйлдэж хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлнэ. Шүүгч 72 цагийн дотор захирамж гаргах бөгөөд хэргийн ээдрээ, төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорьж, мөрдөх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл цагдан хорих хугацааг тухай бүр 30 хүртэл хоногоор сунгадаг байна.

Үүнээс үзэхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар цагдан хорьж мөрдөх нийт хугацаа 30 сар байх боломжтой байна. Харин Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 366 дугаар зүйлийн 366.4-т зааснаар насанд хүрээгүй этгээдийг цагдан хорьж мөрдөх үндсэн хугацаа 1 сар байх бөгөөд цагдан хорьж мөрдөх нийт хугацаа хүндэвтэр гэмт хэрэгт 2 сар, хүнд гэмт хэрэгт 4 сар, онц хүнд гэмт хэрэгт 8 сараас хэтэрч болохгүй юм.

Цагдан хорьж мөрдөх нийт хоногт хойшлуулшгүй ажиллагаагаар баривчлагдсан болон сэжигтэн, яллагдагчаар цагдан хоригдсон хугацаа, нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнөх цагдан хоригдсон хугацаа, шүүхээс нэмж мөрдөн байцаалгахаар буцаасан хэргийн яллагдагчийг цаашид цагдан хорих хугацааг тус тус оруулан тооцно.

⁵⁴ Эрүүгийн хуулийн 81.2, 84, 91.2, 145.4, 177.2, 302 дугаар зүйл.

Харин цагдан хоригдож байсан этгээд шүүхийн шийтгэх тогтоолоор тодорхой хугацаанд ял эдэлсэн, шийтгэх тогтоол нь хүчингүй болсон хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан бол ял эдэлж байсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцохгүй байна.

Цагдан хорьж мөрдөх хугацаа дууссан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүгчид танилцуулж таслан сэргийлэх арга хэмжээг нэн даруй өөрчлүүлэх, хүчингүй болгуулах үүргээ биелүүлээгүйн улмаас хүний эрх зөрчигдөж байна.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дуусч байгаа тохиолдолд заавал шийдвэрлэх, хорьж мөрдөх хугацааг сунгахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.9 дэх хэсэгт заасан журмын дагуу ерөнхий шүүгчийн захирамжаар шийдвэрлэх ёстой. Гэтэл практикт яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш таслан сэргийлэх арга хэмжээг тухай бүр шийдвэрлэдэггүйн улмаас шүүгдэгч хууль бусаар цагдан хоригдож байна⁵⁵.

Тохиолдол:

...Миний бие цагдан хорих төвд 5 сар хоригдож байна. Энэ хугацаанд цагдан хорионы хугацаа дуусах өдөр амралтын өдөр таарсан тул батлан даалт гэж авч гараад эрүүлжүүлэх байранд хонуулаад буцаагаад цагдан хорьсон...

(Цагдан хорих 461 дүгээр ангид цагдан хоригдож буй иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн судалгаа, хяналт шалгалт, Комисст ирүүлсэн гомдлоос дүгнэж үзэхэд цагдан хоригдож буй яллагдагч, шүүгдэгчийг шүүхийн шатанд удаан хугацаагаар хорьдог, уг хоригдсон хугацааг Монгол Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгчийн албан бичгийг⁵⁶ үндэслэн цагдан хоригдсон хугацаанд оруулан тооцохгүй байна. Энэ нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжийг ноцтой зөрчиж байна.

Тохиолдол

Гомдол гаргагч яллагдагч Б нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 40 сар буюу хуульд заасан хугацаанаас 10 сар илүү цагдан хоригдсон тухай, С нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт нийт 13 сар 14 хоног цагдан хорьж хуульд заасан хугацаанаас 44 хоног илүү хоригдсон тухай, З нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэгт заасан 13 сар 1 хоног цагдан хорьж хуульд заасан хугацаанаас 31 хоног тус тус илүү хоригджээ.

Гомдол гаргагч, яллагдагч Ө нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 2014 оны 8 дугаар сарын 19-ны өдрөөс 2015 оны 12 дугаар

⁵⁵ Комиссоос 2015 онд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих 0461 дүгээр ангид хийсэн хяналт шалгалтын тайлангаас

⁵⁶ Монгол Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгчийн 2014 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны нийт ерөнхий шүүгч нарт хүргүүлсэн 2/1304 дугаартай “Яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих хугацааны тухай” албан бичиг.

сарын 14-ний өдөр хүртэл нийт 716 хоног цагдан хоригдож байгаа бөгөөд энэ хугацаанд Ө нь эрүүгийн хэргийн анхан шатны ... дугаар шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад 2 удаа буцсан байх бөгөөд шүүгдээгчээр 166 хоног цагдан хоригдсон байна...

(Цагдан хорих 461 дүгээр ангид цагдан хоригдож буй иргэн Б, С, З, Ө нарын Комисст ирүүлсэн гомдлоос)

2.1. Аливаа этгээдийг баривчлах үед өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх эрхтэй болох, түүнчлэн баривчилсан талаар шүүхэд гомдол гаргах эрхийг тайлбарласан байдал

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд зааснаар баривчлагдсан хүмүүст эрхийг нь сануулах, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэхийг тайлбарлаж өгөхийг шаарддаг. Энэхүү шаардлагад гуравдагч этгээдэд мэдээлэх, хууль зүйн туслалцаа авах, эрүүл мэндийн тусламж авах, цагдан хорих арга хэмжээ хууль ёсны эсэх талаар гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, зүй бус харьцаа, орчин нөхцөлийн эсрэг гомдол гаргах, эрхээ сэргээлгэх зэрэг асуудал багтана⁵⁷.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1-д “Хүн бүр чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй”, мөн зүйлийн 2-т “Баривчлагдсан шалтгааныг хүн бүрт баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ” гэж тус тус заажээ.

“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд⁵⁸”-ын 10 дугаарт “Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтгааныг баривчлах үед мэдээлж аливаа сонсгосон ялыг түүнд нэн даруй мэдэгдэх ёстой”, 11 дүгээр зарчмын 2-т “Саатуулах тухай аливаа тогтоол түүнчлэн саатуулсан шалтгааны тухай аливаа тодорхой мэдээллийг саатуулагдсан этгээдэд, хэрэв өмгөөлөгч байгаа бол мөн түүнд нэн даруй өгөх ёстой” гэж тус тус заасан болно.

Мөн баривчилсан шалтгаан, тухайн этгээдийн баривчилсан цаг, түүнийг саатуулах газарт хүргэсэн цаг, түүнчлэн анх удаа шүүхэд буюу бусад байгууллагад хүргэгдсэн цаг, хууль хэрэгжүүлэх байгууллагын зохих албан тушаалтнуудын овог, нэр хорих газартай холбогдолтой тодорхой мэдээлэл зэргийг зохих ёсоор тэмдэглэлд бичиж, энэхүү хуульд заасан хэлбэрээр бичигдсэн тийм тэмдэглэлийг саатуулагдсан этгээдэд, өмгөөлөгчтэй бол түүнд танилцуулах шаардлагатай болохыг уг зарчимд тодорхойлсон болно⁵⁹.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчлах бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн

⁵⁷ Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2 дугаар Ерөнхий тайлбар, 13 дугаар зүйл.

⁵⁸ Куба Улсын Гавана хотноо 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх” Нэгдсэн Үндэстний Байгууллагын VIII их хурлаас баталсан


⁵⁹ “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 12 дугаар зарчим

байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж, прокурорт танилцуулах, прокурор нь шүүхэд танилцуулж шийдвэрлүүлэх бөгөөд гагцхүү хойшлуулшгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж, 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлэх ёстой.

Шүүгч тогтоолыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор шаардлагатай гэж үзвэл өмгөөлөгч, прокурорыг байлцуулан сэжигтнийг баривчлах эсэх асуудлыг шийдвэрлэж нэн даруй захирамж гаргана. Харин гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт байхгүй, баривчлагдсан этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлгүй, сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримтгүйгээр зөрчиж баривчилсан бол шүүгч захирамж гарган сэжигтнийг суллана.


Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д “Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна”, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт “Тогтоол, захирамжийг сэжигтэнд танилцуулах ба түүнд энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх, түүний дотор өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхтэй болохыг нь тайлбарлаж өгөх ба энэ тухай тэмдэглэлд тусгана” гэж тус тус заажээ.

Судалгаагаар өмгөөлөгчтэй 529 хоригдогчдын 294 буюу 55 хувьд нь баривлагдах үед өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулж, 205 буюу 38 хувьд нь сануулаагүй байна.



Өмгөөлөгчгүй 108 хоригдогчийн 3 хариулаагүй бол 105 нь уг асуултад дараах байдлаар хариулсан байна.

Өмгөөлөгчгүй хоригдогчдод өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулсан эсэх




Үүнээс үзэхэд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь танилцуулж, сануулахгүй байгаагаас тэд хууль зүйн туслалцааг бүрэн авч чадахгүйд хүрч байна.

2.2.Цагдан хорих тухай шийдвэрийг танилцуулж буй байдал


Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.7 дахь хэсэгт “Цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ” гэж заажээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу сэжигтэн өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоол, яллагдагч нь яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой тус тус танилцах эрхтэй⁶⁰.

Судалгааны дүнгээс үзвэл хоригдогчдод цагдан хорих тухай шүүгчийн захирамж танилцуулж байгаа нь харилцан адилгүй байна.



⁶⁰ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.2, 36 дугаар зүйлийн 36.2.3


Цагдан хорих тухай шийдвэртэй танилцсан хоригдогчдоос уг шийдвэрийг ямар албан тушаалтан танилцуулж байгааг тодруулахад дараах байдлаар хариулсан байна.




2.3. Өмгөөлөгчөө сонгох эрхийг хангасан байдал

Гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүн бүр өөрийн сонгож авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, эсхүл шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс шүүхээс өмгөөлөгч оролцуулах арга хэмжээ авах бөгөөд хэрэв тухайн хүн төлбөрийн чадваргүй бол түүнд төр хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үүрэгтэй.

Судалгаанд оролцсон өмгөөлөгчтэй хоригдогчдын 27 хувь нь өмгөөлөгчөө өөрөө сонгосон бол, 39 хувь нь хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, садангийн хүнээрээ дамжуулж өмгөөлөгчөө сонгосон байна. Тэгвэл 14 хувь нь буюу 75 хоригдогч мөрдөн байцаагчийн санал болгосноор өмгөөлөгчөө сонгожээ.



Хувийн болон улсын өмгөөлөгчийг хэрхэн сонгож байгааг харьцуулан доорх хүснэгтэд харуулав.





Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй” гэжээ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаар иргэдийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь өмгөөлөгч болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагаа өгч болно. Мөн хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь энэ тухай Монголын Хуульчдын холбоонд

мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авдаг байна. Ингэхдээ хууль зүйн туслалцаа хүсэгчид өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж, тулгахыг хориглосон байна.

Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх бололцоогоор хангах үүрэгтэй болохоос хэн нэг өмгөөлөгчийг нэр зааж тухайн этгээдийн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах эрхэд халдах ёсгүй билээ. Судалгааны дүнгээс үзэхэд өмгөөлөгчийг нэр зааж, өмгөөлөгчөөр авахыг тулгах тохиолдол гарч байна.



Тохиолдол:

Миний хэргийг шалгаж байгаа мөрдөн байцаагч өөрөө надад өмгөөлөгчийг санал болгосон. Би төлбөрийн чадваргүйн улмаас улсын өмгөөлөгчтэй болсон. Гэвч улсын өмгөөлөгч манай гэрийнхэнтэй яриад нэмэлт хөлс өгвөл илүү найдвартай өмгөөлнө гэсэн зүйл хэлсэн байсан. Үгүй бол шүүх хуралд орохоос чинь өмнө амжвал хэргийн материалтай чинь танилцана гэсэн...


(Цагдан хорих 461 дүгээр ангид цагдан хоригдож буй иргэн О-той хийсэн ярилцлагаас)

Улсын хэмжээнд нийслэлийн 8 дүүрэг, 21 аймаг, 2 суманд төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх төв байгуулагдан, нийт 31 салбарт 50 орон тооны өмгөөлөгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хувийн өмгөөлөгчийг дараах нөхцөлд төлбөрийн чадваргүй яллагдагчийн өмгөөлөгчөөр ажиллуулна. Үүнд:

- улсын өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчилтэй;
- нэг хэрэгт харилцан эсрэг сонирхолтой хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгч хууль зүйн туслалцаа авах өргөдөл гаргасан;
- үйлчлүүлэгч нь холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу улсын өмгөөлөгчөөс татгалзсан;
- тухайн нутаг дэвсгэрт Хууль зүйн туслалцааны төвийн салбар байхгүй.

Хууль зүйн туслалцааны төвөөс 2014-2015 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээг харьцуулан авч үзвэл нэг жилийн дотор өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо 49 хувиар өссөн үзүүлэлттэй байна.⁶¹



Тус төвийн нэг өмгөөлөгчид сард дунджаар ноогдох хэргийн тоо 2014 онд 6-8 байсан бол 2015 онд 8-10 болж өсчээ. Мөн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нийт 5000 хуульчийн 1 хувьтай тэнцэх орон тооны улсын өмгөөлөгч шүүхээр шийдвэрлэгдэж байгаа нийт гэмт хэргийн 30-35 хувьд нь өмгөөлөгчөөр оролцож байна⁶².

Улсын өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэйгээ Хууль зүйн сайдын 2014 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан загварын дагуу өмгөөлөл үзүүлэх гэрээ байгуулан ажилладаг ба тухайн гэрээнд үйлчлүүлэгч гарын үсэг зурж баталгаажуулснаар хэргийг ажлын үнэлгээнд оруулдаг учраас улсын өмгөөлөгчдийн зүгээс үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулаагүй тохиолдол гардаггүй байна. Мөн улсын өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэйгээ уулзсан тухай болон уулзалтын товч агуулгыг ярилцлагын маягтад тэмдэглэж үйлчлүүлэгчийн гарын үсгээр баталгаажуулж, ажлын үзүүлэлтэд тооцуулдаг байна.

⁶¹ Хууль зүйн туслалцааны төвийн 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 1/73 дугаар албан бичиг

⁶² Хууль зүйн туслалцааны төвийн 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 1/73 дугаар албан бичиг

Хууль зүйн туслалцааны төв нь хувийн өмгөөлөгчийг ажиллуулахдаа төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээг сайн дурын үндсэн дээр үзүүлэх хувийн өмгөөлөгч байхгүй тохиолдолд үйлчлүүлэгч нь тухайн нутаг дэвсгэрт өмгөөллийн үйлчилгээ явуулж байгаа өмгөөлөгчид хүсэлт гаргаснаар оролцуулах бөгөөд хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн ажлын хөлсийг улсын төсвөөс санхүүжүүлдэг.

Мөн хувийн өмгөөлөгчийг ажиллуулах нөхцөл бий болсон тохиолдолд Хууль зүйн туслалцааны төвийн салбар нь батлагдсан гэрээний загварын дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах бөгөөд гэрээгээр өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн хувийн өмгөөлөгч нь хэргийн материалыг бүрдүүлж, өмгөөллийн үйлчилгээний тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд тухайн Хууль зүйн туслалцааны төвийн салбарт ирүүлэх үүрэгтэй байна.

Тохиолдол:

Миний бие 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Цагдан хорих 461 дүгээр ангиас Хууль зүйн туслалцааны төвд ирүүлсэн ...дугаартай бичгийн дагуу тус ангид цагдан хоригдож буй иргэн Б-гийн улсын өмгөөлөгчөөр ажиллахаар болсон. Ингээд үйлчлүүлэгчтэй очиж уулзахад “Өчигдөр надтай танай томилолтын өмгөөлөгч ирж уулзаад миний хэргийг өмгөөлнө гэсэн. Манай зах дээр зогсдог дүүгийн утсыг аваад түүнтэй ярьж байгаад хэдэн төгрөг аваад өмгөөлөхөөр болно” гэж хэлсэн.

Манай Хууль зүйн туслалцааны төвд М гэдэг өмгөөлөгч байдаггүй, таны гаргасан хүсэлтийн дагуу тус төвөөс томилогдсон улсын өмгөөлөгч би байна, ямар өмгөөлөгч авахаа та өөрөө шийдэх эрхтэй, тантай уулзсан өмгөөлөгч бол хувийн өмгөөлөгч байна, хуульд заасны дагуу үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа өмгөөлөгчдийг улсын өмгөөлөгч гэж нэрлэдэг болсон, таны хувийн мэдээллийг хаанаас авсан юм бол доо гэж асуухад “мэдэхгүй” гэж гайхширснаа “би зөвхөн Хууль зүйн туслалцааны төв рүү өргөдөл гаргасан” гэв...

(Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч А-тай хийсэн ярилцлагаас)

Өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох гэдэг нь тухайн өмгөөлөгчийн мэргэшсэн байдал, туршлага, хувь хүний төлөвшил, нэр хүнд, үйлчилгээний хөлсний хэмжээг харгалзан өөрийн итгэл үнэмшилд үндэслэж сонгохыг хэлнэ. Түүнчлэн, төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан гэдгээр нь аль нэг өмгөөлөгчийг шууд томилох бус түүний сонгосон өмгөөлөгчийг нь оролцуулж өгснөөр олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах эрх хангагдана.

Хууль зүйн туслалцааны төвүүд болон Монголын Хуульчдын холбоогоор дамжуулан төлбөрийн чадваргүй иргэдэд улсын болон хувийн өмгөөлөгчөөр хууль зүйн туслалцааг үзүүлэхдээ тэдний сонголтыг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай. Тодруулбал, тухайн иргэний сонгосон өмгөөлөгчийг оролцуулж өгснөөр өмгөөлөгчөө сонгох эрх хангагдаж, улмаар хууль зүйн туслалцаа авах эрх бодит утгаараа хэрэгжих болно.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт “Хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд

хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь энэ тухай Монголын Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авна” гэж заасныг үндэслэн ялангуяа өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй байгаа баривчлагдан, цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахын тулд холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, мэдээллийн солилцоог тогтмолжуулах, аль болох эрүүгийн хэрэгт холбогдсон үеэс иргэд өмгөөлөгчөө сонгох боломжтой байх чиглэлээр анхаарч ажиллах нь зүйтэй байна.

2.4. Хууль зүйн туслалцаа авсан үе шат

Эрүүгийн хэрэгт холбогдсон хүн өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа, нөхцөлөөр хангагдах эрхтэй. Өмгөөлөлд бэлтгэх боломжит хугацаа нь холбогдох ажиллагааны төрөл (мөрдөн байцаалтын шат, шүүх хуралдаан болон давж заалдах шат г.м) болон тухайн хэргийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг. Хэдийгээр дангаар шийдвэрлэхгүй боловч холбогдох хүчин зүйлсэд хэргийн нарийн төвөгтэй байдал, яллагдагчийн зүгээс шаардлагатай мэдээлэл, нотлох баримттай танилцах боломж, (мөн эдгээр материалын цар хүрээ) өмгөөлөгчтэйгээ харилцах боломж, дотоодын хуульд заасан хугацааны хязгаарлалт зэрэг багтана⁶³.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмаар онцгой тохиолдолд хууль зүйн туслалцаа авах эрхийг хойшлуулахыг зөвшөөрдөг. Дэг журам, аюулгүй байдлыг хангах зорилгоор зайлшгүй нөхцөлд уг эрхийг хязгаарлахаар хуульд тодорхой заах бөгөөд ийм шийдвэрийг шүүхээс эсвэл бусад эрх бүхий байгууллагаас гаргах нь зүйтэй. Ийм тохиолдолд ч гэсэн баривчилж, хорьсноос хойш 48 цагаас илүүгүй хугацаанд өмгөөлөгч авах эрхийг нээх ёстой байна⁶⁴.

“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд”-ын цогцын 15 дугаар зарчимд “Зарчмуудад... зааснаар онцгойлсон боловч саатуулагдсан болон хоригдсон этгээдэд гадаад орчинтой тухайлбал гэр бүл, өмгөөлөгчтэй холбоо тогтоохыг хэдхэн хоногоос хэтрэхгүй хугацаагаар татгалзаж болно”, 18 дугаар зарчмын 3-т “Саатуулагдсан болон хоригдсон этгээдийг нэн даруй, хяналт шалгалтгүй, бусдыг байлцуулахгүйгээр өмгөөлөгчтэйгээ уулзах, зөвлөлдөх, холбоо барих эрхийг шүүхийн болон бусад байгууллагын үзэж байгаагаар аюулгүй байдал дэг журмыг хангахад зайлшгүй онцгой нөхцөл байдал бий болсноос бусад тохиолдолд түр зуур хүчингүй болгож хязгаарлаж болохгүй” гэж тус тус заасан байдаг.

Тохиолдол:


Мөрдөн байцаалтын ажиллагаа дор хаяж 2 сар үргэлжилдэг. Цаашлаад 2 жил ч болно. Мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа бидэнд хэргээ танилцуулдаг. Бидэнд хэргийн материалтай танилцах хангалттай цаг хугацаа, орчин нөхцөлийг бүрдүүлж өгөх хэрэгтэй байна. Гэтэл мөрдөн байцаагчийн өрөөний буланд сууж, хэргийн материалтай танилцаж байна. Хажууд бас өөр хэргийн байцаалт явагдаж байдаг. Сүүлийн үед тухайн хэрэг прокурорт шилжүүлсний дараа хэргийн материалтай өмгөөлөгчийг танилцуулна гэдэг болсон. Хаанаас ч ийм юм гаргаад ирсэн байгаа юм...

(Дархан-Уул аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)


⁶³ Хүний эрхийн хорооны 32 дугаар Ерөнхий тайлбар, 32 дугаар зүйл.

⁶⁴ Хуульчдын Гүйцэтгэх Үүргийн Үндсэн Зарчмуудын 7 дугаар зарчим.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 172.3 дахь хэсэгт заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, ийм ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй” гэж заасны дагуу хэрэгт холбогдсон үеэс эхлэн шүүхийн шат хүртэл аль үе шатанд өмгөөлөгчөөр хангагдсаныг судалж үзэв.



Хувийн болон улсын өмгөөлөгчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль үе шатанд түлхүү авч байгааг харьцуулахад дараах байдалтай байна.



Судалгаанаас үзэхэд яллагдагчаар татагдсан, хэргийг прокурорт болон шүүхэд шилжүүлэх зэрэг хожуу үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч эхэлсэн тохиолдол гарч байна.

Иймээс мөрдөн байцаалтын шатанд тэр бүр өмгөөлөгч оролцож чадахгүй байгаагаас давчуу хугацаанд өмгөөлөгч хэргийн материалтай танилцаж, тухайн этгээд өмгөөлөгчтэйгээ ойлголцох, санал бодлоо солилцох, харилцан итгэлцэл

тогтоох хугацаагүйгээр байцаалтад болон шүүх хуралд оролцож байгаа нь хууль зүйн туслалцаа авах эрх хангагдахгүй байх нэг нөхцөл болж, тухайн этгээдийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

Прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрхэн хангаж байгаад тавих хяналтаа сайжруулах шаардлагатай юм.

Улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлсэн хэргийн бүрдүүлбэрт Шүүхийн тогтоолыг заавал оруулж хавсаргах үүрэгтэй бөгөөд эдгээрт дүн шинжилгээ хийж үзэхэд 2014-2015 онд шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн хэргийн 70 орчим хувь нь улсын өмгөөлөгчийн саналаар хэрэг нь бүхэлдээ болон үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болсон, зүйл анги хөнгөрсөн, улсын яллагчийн саналд туссан ялаас хөнгөн ял оногдуулсан үзүүлэлттэй байна.

Мөн 2014 онд тус төвөөр үйлчлүүлэгчдийн 38.43 хувь нь шүүхийн шатанд өмгөөлөгчөөр хангагдсан бөгөөд 2015 онд энэ үзүүлэлт 30 хувь болж буурчээ. Үүнээс үзэхэд тус төвөөр үйлчлүүлэгчдийн 30 орчим хувь нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эхний шатнаас өмгөөлөгчөөр хангагдаж чадаагүй байна⁶⁵.


2.5. Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ

Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ нь хоёр талын хэлцэл бөгөөд Туслалцаа үзүүлэх гэрээний төрөлд хамаарна. Туслалцаа үзүүлэх гэрээний онцлог нь үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчийн хэрэгцээ, хүсэлтийн дагуу туслалцаа үйлчилгээ үзүүлж, үүрэг гүйцэтгүүлэгч хууль буюу гэрээнд заасан хөлс төлбөр төлөх харилцааг зохицуулна.



Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасны дагуу хууль зүйн туслалцаа хүсэгч аливаа иргэн нь өмгөөлөгчид шууд хандаж хэлцэл хийх эрхтэй бөгөөд эсхүл Монголын Хуульчдын холбоонд хүсэлт гаргаснаар тус холбоо нь өмгөөлөгчдийн нэр, хаягийн лавлагаа өгөх үүрэгтэй болно.

Өмгөөлөгчтэй 530 хоригдогчийн 375 нь хувийн, 155 нь улсын өмгөөлөгчтэй гэжээ. Тэднээс өмгөөлөгчтэйгээ хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг тухай бүр байгуулж чадаж байгаа эсэхийг асуухад 353 хоригдогч буюу 66 хувь нь гэрээ байгуулсан, 29 хувь буюу 152 хоригдогчийн хувьд гэрээ байгуулаагүй гэж хариулсан бөгөөд 25 хоригдогч буюу 5 хувь нь хариулаагүй байна.


⁶⁵Хууль зүйн туслалцааны төвийн 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 1/73 дугаар албан бичиг




Энэхүү үзүүлэлтийг хувийн болон улсын өмгөөлөгчтэй хоригдогчдоор ангилан харуулбал:



Хувийн болон улсын өмгөөлөгчтэй боловч гэрээ байгуулаагүй гэх хоригдогчдоос шалтгааныг нь тодруулахад дараах хариултыг өгсөн болно.







Өмгөөлөгчтэйгээ гэрээ байгуулахдаа өөрийн саналыг гэрээний төсөлд тусгаж чадсан эсэхийг тодруулахад дараах хариултыг өгчээ.



Судалгааны дүнгээс үзвэл гэрээнд хоригдогчийн саналыг тусгаагүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:



Гэрээ нь талуудын хүсэл зоригийн илэрхийлэл бөгөөд өөрсдийн ашиг, сонирхол, хэрэгцээгээ хангах зорилгоор хэлцлийг сайн дураараа байгуулах бөгөөд оролцогч талууд эрх тэгш байх ёстой.

Хууль зүйн туслалцааны гэрээг бичгээр байгуулахдаа үйлчлүүлэгчийнхээ санал хүсэлтийг харгалзан үзэхгүй, зөвхөн нэг талын хүсэл зоригоор хууль зүйн гэрээг байгуулж, үйлчлүүлэгчээр зөвхөн гарын үсэг зуруулах төдий байдалтай байна.

Өмгөөлөгч үйлчүүлэгчтэйгээ гэрээ байгуулахдаа заавал харилцан тохиролцох асуудлын нэг нь өмгөөллийн үйлчилгээний хөлс бөгөөд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт зааснаар өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг гэрээгээр харилцан тохиролцож тогтоохоор байна. Үүнээс үзэхэд өмгөөлөгч үйлчүүлэгчтэйгээ тохирсон өмгөөллийн үйлчилгээний хөлсний талаар бичгээр гэрээ хийж хэвших нь тэдгээрийн хуульд заасан эрхээ эдлэх баталгаа болно.

Хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцсон цагаас эхлэн өмгөөлөгч нь үйлчлүүлэгчдээ өмгөөллийн үйлчилгээний хөлс түүнийг тооцох аргачлалыг заавал мэдэгдэж, үйлчлүүлэгчээсээ хөлс авах бүртээ баримт олгож, өмгөөлөгч байгуулсан гэрээнийхээ заалт бүрийг биелүүлэхийн төлөө үйлчлүүлэгчтэй байнгын холбоотой байж, тогтмол мэдээллээр хангах шаардлагатай юм.

2.6. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо

Өмгөөлөгч нь эрүүгийн хэрэгт хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, ийм ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан, цагдан хоригдсон буюу ял сонсгож яллагдагчаар татах тогтоолтой танилцах үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох бөгөөд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн төрөл садангийн хүмүүсийн санал хүсэлтээр, эсхүл томиллолтоор, харилцан тохиролцсноор өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлнэ.

Өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон үеэс эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг судлах, гэмт хэрэг үйлдэхэд хэрхэн оролцсон, хууль зөрчсөн шалтгааныг тогтоох, нотлох баримтыг зөв үнэлэх, үндэслэлгүй яллаж хэргийг шүүхэд шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагчийг цагаатгах, түүний ял хариуцлагыг хөнгөрүүлэх хууль ёсны үндэслэл бүхий учир шалтгаан, баримт нотолгоонуудыг тодорхой болгох зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээг авч, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Үүний зэрэгцээ өмгөөлөгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй уулзах, хэргийн бүх материалтай танилцах, түүнээс хэрэгцээтэй зүйлийг тэмдэглэн авах, нотлох баримт гаргаж өгөх, хүсэлт гаргах, цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, шинжээчийг томилох, гэрчийг байцаах, мөрдөн байцаалтын бусад ажиллагаанууд хийлгэх тусгай хүсэлт гаргах, байцаагчийн ажиллагаанд гомдол гаргах, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцох эрхтэй болно⁶⁶.

Тохиолдол:

Практикт өмгөөлөгчгүй өдөржин байцаадаг, шөнө хонуулдаг асуудал тасрахгүй байна. Хойшлуулшгүй ажиллагаанаас бусад тохиолдолд шөнийн цагаар мөрдөн байцаалт явуулахыг хориглоно гэсэн байдаг. Гэтэл шөнийн 00, 01 цагийн үед авсан тайлбараа нотлох баримтын хэмжээнд үнэлээд, шүүх дээр аваад очиж байгаа юм. Нөгөө хүн өмгөөлөгч авсны дараа байцаалт өгөхдөө анхны байцаалтаасаа өөр тайлбар өгдөг. Амьдрал дээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар өмгөөлөгч авахуулах дургүй байдаг, өмгөөлөгчгүй байхад л хамаг хэргээ бүрдүүлж авдаг.

(Орхон аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)


⁶⁶ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлд өмгөөлөгчийн эрх, үүргийг тодорхойлсон болно.

Тохиолдол:


Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтнээр тооцогдсон үеэс өмгөөлөгч авахаар зохицуулсан. Тэгтэл яллагдагчаар татагдах хүртэл хэргийн материалтай танилцуулдаггүй. Сэжигтнээр татагдсаны дараа зөвхөн байцаалт өгөх үед л өмгөөлөгч оролцдог. Өөрөөр тэр хүнийхээ төлөө ажиллах, хэргийн материалтай танилцах боломж байхгүй байна...

(Дархан-Уул аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)


Өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр цагдан хоригдсон этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хууль зүйн туслалцаа хэрхэн үзүүлж байгааг өмгөөлөгчтэй хоригдогчдоос тодруулахад дараах байдалтай байна.



Үүнээс улсын өмгөөлөгч болон хувийн өмгөөлөгчдийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож буй байдлыг харьцуулж үзвэл дараах байдалтай байна.



Өмгөөлөгч тухайн хоригдогчийн мөрдөн байцаалтын ажиллагаанд биечлэн байлцаагүй шалтгааныг “заримдаа” болон “үгүй” гэж хариулсан 293 оролцогчоос тодруулахад 113 нь хариулаагүй бол бусад нь дараах байдлаар хариулсан байна. Үүнд:



Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгээр хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг бэхжүүлдэг учраас байцаалт өгөхөд үйлчлүүлэгчтэйгээ хамт байж, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад өмгөөлөгчийн оролцоо чухал үүрэгтэй. Ялангуяа байцаалтын тэмдэглэлд тусгагдсан мэдүүлгийн талаар маргаан гарвал тухайн байцаалтын тэмдэглэл нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх нь маргаантай болно.

Иймээс өмгөөлөгч байцаалтад оролцох нь хүний эрхийн баталгаа болохын зэрэгцээ сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгч хуульд заасан эрхээ бүрэн дүүрэн эдлэх нэг нөхцөл юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй байна.

Иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн талаарх мэдлэг ойлголт хангалтгүй, нөгөө талаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж байдаг өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлэх эрх хэмжээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хязгаарлагдмал байгаа бөгөөд зөвхөн “хүсэлт” гаргах хэмжээнд хуульчлагдсан байдагтай холбоотой.

Эрүүгийн хэргийн нотлох ажиллагаа нь хэргийг хуулийн дагуу шударгаар, бүх талаас нь бүрэн дүүрэн бодит үндэслэлтэйгээр хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тогтоох зорилгоор явуулж буй нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх үйл ажиллагааны цогц юм⁶⁷. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг чухал хэсэг нь нотлох ажиллагаа бөгөөд үүнд хэргийг цагаатгах, хөнгөрүүлэх нотлох баримтыг цуглуулж, үнэлэхэд өмгөөлөгчийн оролцоог өргөн хүрээнд хуульчлан баталгаажуулах нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийн баталгаа хангагдах гол нөхцөл болно.

⁶⁷ Б.Амарбаясгалан, Ж.Эрхэсхулан, “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”, Сургалтын гарын авлага, УБ, 2007 он

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл заалтад дүн шинжилгээ хийж үзэхэд өмгөөлөгч тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3.8-д заасны дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах эрхтэй байна. Энэхүү зохицуулалтаас үзэхэд өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хязгаарлагдмал хүрээнд оролцож, аливаа хэрэгт холбогдсон этгээдийн эрхийг зохих ёсоор хамгаалж чадахгүй нөхцөл байдалд хүрч байна.

Тохиолдол:

...Мөрдөн байцаалт, прокурорын шатанд тулгарч буй бэрхшээл нь өмгөөлөгчийн гаргаж байгаа үндэслэл бүхий санал, хүсэлтийг нарийн нягталж үздэггүй, ёс төдий ханддаг.

(Орхон аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн үүргээс татгалзах, хууль бусаар нотлох баримт цуглуулах эрхгүй. Тэгвэл өмгөөлөгч нотлох баримтыг хууль ёсоор цуглуулах боломж нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3.6-д заасны дагуу өөрсдийнх нь зөвшөөрснөөр иргэн, хуулийн этгээдээс, тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авахаас өөр нотлох баримттай холбоотой зохицуулалт алга байна.

Харин өмгөөлөгч нотлох баримт цуглуулах ажиллагаанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3.2-т зааснаар ... хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, түүнийгээ шалгуулан хавтаст хэрэгт тусгуулах, эсхүл мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.3 дахь хэсэгт зааснаар өмгөөлөгч баримт сэлт гарган өгч болно. Мөн хуулийн 102, 103, 107 дугаар зүйлүүдэд заасан хүсэлт гомдол гаргах нийтлэг журмын дагуу нотлох баримт цуглуулахаар өмгөөлөгчийн хүсэлт гомдлыг шийдвэрлэхээр байна. Нотлох баримтыг цуглуулах үндсэн арга хэрэгсэл бол байцаан шийтгэх тодорхой ажиллагаа бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт заасны дагуу хураан авах, нэгжлэг хийхэд хөндлөнгийн гэрч, эд зүйл, бичиг баримтаа хураалгаж байгаа буюу нэгжүүлж байгаа этгээд, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгчийн аль нэгийг заавал байлцуулахаар байна.

Үүнээс үзэхэд өмгөөлөгч нотлох баримтыг бие даан цуглуулах эрхгүй гагцхүү хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг шалгуулж, нотлох баримтын хэмжээнд үнэлүүлэхээр хуулиар тодорхойлсон эрх бүхий албан тушаалтнуудад хандаж шийдвэрлүүлэх эрхтэй байгаа нь тэдний үйл ажиллагаанаас шууд хараат байх нөхцөл бүрдэж байна.

Тохиолдол:

...Өмгөөлөгч Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход хүч дутагддаг, нийгмээс болон хуулийн байгууллагуудын үнэлэмж бага гарсан. Аливаа хэрэг маргааны шийдвэр нь өмгөөлөгчийг үл тоосон байдалтай байдаг. Яллах талын нотлох баримтыг туйлын үнэн гэж ойлгосон, цагаатгах талын нотлох баримтыг

бүрдүүлдээгүй, цагаатгах нотлох баримтыг өмгөөлөгч л гаргадаг. Гэтэл шүүх хурал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад өмгөөлөгч цагаатгах нотлох баримтыг гаргахаар хулгайчийг өмөөрсөн зүйл гэж шууд хэлдэг болсон. Та нар үйлчлүүлэгчээ өмөөрөөд хуурамч юм зохиогоод байна гэдэг, гэрч байгаа гэхээр аль хэдийн та нар тохиролцсон гэдэг. Үнэндээ Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчиж авсан нотлох баримтыг хэрэгт хавсаргадаг. Хэзээ, хаана, хэн, яаж бүрдүүлсэн тодорхойгүй камерын бичлэг ч байдаг.

(Орхон аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)

Хэдийгээр нотлох үүрэг болон түүнд тавигдах шаардлага нь олон улсын эрх зүйд тодорхой тусгагдаагүй боловч Хүний эрхийн хорооноос “гэм буруугүйд тооцох зарчмын дагуу нотлох үүргийг яллагч талд хүлээлгэж, гэмт хэрэг үйлдсэн нь эргэлзээгүй тогтоогдохоос нааш гэм буруугүйд тооцогдох баталгаа, аливаа эргэлзээ нь сэжигтэнд ашигтайгаар хэрэглэгдэх явдлыг хангах ёстой”⁶⁸ гэжээ.

Ялангуяа өмгөөлөгчийг оролцуулахгүйгээр өгүүлсэн мэдүүлэг нь хүний эрхийг ноцтой зөрчиж олж авсан мэдүүлэг учраас түүнийг нотлох баримтаас хасахыг олон улсын гэрээний бус хэм хэмжээнүүд шаарддаг. Тухайлбал, “Прокурорын гүйцэтгэх үүргийн тухай удирдамж”-д прокурор нь аливаа нотлох баримтыг хууль бусаар, сэжигтний эрхийг зөрчиж олж авсан гэж үзэх үндэслэл байвал ийнхүү хүний эрхийг зөрчсөн буруутай этгээдийн эсрэг ашиглахаас бусад тохиолдолд уг нотлох баримтыг ашиглахаас татгалзах ёстой⁶⁹.

“Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд⁷⁰” болон Хүний эрхийн хорооны 32 дугаар Ерөнхий зөвлөмжид “Бүх талуудад процессын тэгш эрхийг хангах ёстой бөгөөд хэрэв хуульд тодорхой нэг ялгааны талаар заасан бол тэр нь тодорхой үндэслэлтэй, бодит шалтгаанаар тогтоогдсон байх ёстой ба өмгөөлөх талд ямар нэгэн сул тал бий болгосон шударга бус бүхий л нөхцөл байдлыг тогтоосон шинжтэй байж болохгүй” гэж заажээ.

Тохиолдол:

2015 онд манай аймагт эрүүгийн төлөөлөгч насанд хүрээгүй хүүхдийг хэрэгт сэжиглэсэн, нөхөн илрүүлсэн гээд өрөөндөө авч ирээд тайлбар авсан, ингэхдээ насанд хүрээгүй хүүхдийг заавал өмгөөлөгчтэй байцаах ёстой хуулийн заалтаа хэрэгжүүлээгүй. Ямар ч хяналт байхгүй, өдөржин суулгана, хонуулна, тэгээд ийм үйлдлийг ярь гэдэг, нөгөө хүүхэд нь ч төлөөлөгчийн хэлсний дагуу л ярьдаг. Нөгөө насанд хүрээгүй хүүхэд маань ч энэ талаараа өмгөөлөгчид хэлдээгүй. Мэдүүлгээ ч энэ хэвээр нь өгөөд явуулдаг. Харин шүүхийн шатанд очсон хойноо үнэнээ ярихаар шүүх нотлох баримт байхгүй, энэ асуудлаараа гомдол гаргаж байсан юмуу, өмгөөлөгчдөө хэлж байсан юмуу гэж асуугаад үгүй гэж хариулахаар тогтоогдохгүй байна гээд л өнгөрдөг

(Орхон аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)

⁶⁸Хүний эрхийн хорооны 32 дугаар Ерөнхий тайлбар, 30 дугаар зүйл

⁶⁹Куба Улсын Гавана хотноо 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх” Нэгдсэн Үндэстний Байгууллагын VIII их хурлаас баталсан “Прокурорын гүйцэтгэх үүргийн тухай удирдамж”-ийн 16 дугаар удирдамж

⁷⁰ Куба Улсын Гавана хотноо 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх” Нэгдсэн Үндэстний Байгууллагын VIII их хурлаас баталсан

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар дараах тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулж байна. Үүнд:

- хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;
- насанд хүрээгүй;
- монгол хэл, бичиг мэддэггүй;
- цаазаар авах ялаар шийтгэгдэж болох;
- хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан.

Дээрх тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй⁷¹.

Судалгаанаас үзэхэд өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх бүх ажиллагаанд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг зохих ёсоор хангахгүй байна. Ялангуяа байцаалт өгөхөд улсын болон хувийн өмгөөлөгчийн аль аль нь шүүх хуралтай байсан, ажлын ачаалал ихтэй байсан, байцаалтын товыг урьдчилан мэдэгдээгүй гэсэн шалтгаанаар үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах, өмгөөллийн үйлчилгээг хангалттай түвшинд үзүүлэхгүй байгаа явдал түгээмэл байна.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгээр хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг бэхжүүлдэг учраас байцаалт өгөхөд үйлчлүүлэгчтэйгээ хамт байж, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад өмгөөлөгчийн оролцоо чухал үүрэгтэй. Судалгаанаас үзвэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд өмгөөлөгчид оролцож чадахгүй байна.

Тохиолдол:

Авлигатай тэмцэх газрын хэд хэдэн хэрэг дээр өмгөөлөгчөөр ажиллаж байна. Гэтэл миний үйлчлүүлэгчийг өмгөөлөгчид ерөөсөө мэдэгдэлгүйгээр шууд хорьчихдог. Тухайн сэжигтний өмгөөлөгчид ийм шалтгаанаар хорих гэж байна гэж урьдчилан хэлэх ёстой шүү дээ. Тэгээд үндэслэлгүй мөрдөнд суулгаж байгаад 14 хоногийн дараа гэм буруугүй гээд, хэрэг нь хэрэгсэхгүй болдог. Энэ асуудалд танай байгууллага анхаарал хандуулаасай гэж хүсэж байна.

(Дархан-Уул аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагаас)

Иймд өмгөөлөгч зөвхөн тодорхой нөхцөл заасан үндэслэл журмын дагуу байцаалтын мэдүүлэг өгөхөд оролцож байгаа одоогийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын зарчимд нийцүүлэн өмгөөлөгч байцаалтын мэдүүлэг авах бүхий л үед үйлчлүүлэгчтэйгээ хамт оролцдог байхаар шинэчлэх шаардлагатай байна.

⁷¹Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдах ёстой.

Дээр дурдсанаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч бие дааж нотлох баримт цуглуулах эрхгүй, хэрэгт ач холбогдол бүхий гэрчийг өөрийн санаачлагаар дуудах эрхгүй зэрэг хязгаарлагдмал хүрээнд оролцож, ялангуяа шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгч нь мэтгэлцээний үр нөлөөтэй тал болж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөл байдлыг өөрчилж, үндэсний эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишиг стандарт, хэм хэмжээнд нийцүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна.

2.7. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах нөхцөл боломж

“Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд⁷²”-ын 8 дугаарт “Баривчлагдсан, саатуулагдсан, шоронд хоригдсон бүх этгээдүүд, хуульчтай уулзах зохих боломж, хугацаа нөхцөл, түүнтэй саадгүй бусдын оролцоогүй, хяналтгүйгээр бүрэн ганцаарчлан харьцах, зөвлөлдөх, ийм зөвлөлгөөнийг хууль хэрэгжүүлэх албан тушаалтны дэргэд, тэгэхдээ тэд нар сонсох боломжгүйгээр хийлгэх явдлыг хангах ёстой”, “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд⁷³”-ын цогцын 18 дугаарт “Саатуулагдсан болон хоригдсон этгээд өмгөөлөгчтэй холбоо барьж зөвлөлдөх эрхтэй”, “Саатуулагдсан буюу хоригдож байгаа этгээдэд өөрийн өмгөөлөгчтэйгээ зөвлөлдөх шаардлагатай цаг, нөхцөлийг олгох ёстой”, “Саатуулагдсан болон хоригдсон этгээдээс, өмгөөлөгчтэй уулзахад хууль хэрэгжүүлэх байгууллагын албан тушаалтан харж болох боловч харин яриаг сонсохгүй нөхцөлд байлгана” гэж тус тус заасан болно.


Эрүүгийн гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг өмгөөлөлд бэлтгэх, өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, холбоо барьж зөвлөлдөх цаг, нөхцөл бололцоогоор хангахыг шаарддаг. Энэхүү эрх нь шүүн таслах ажилллагааны бүх шатанд ялангуяа шүүхийн өмнөх шатанд илүү хамаарна.

Судалгаанд оролцсон хоригдогчдоос өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадаж байгаа эсэхийг тодруулахад өмгөөлөгчтэй 530 хоригдогчийн 36 нь хариулаагүй бол 262 нь уг эрхээ эдэлж чадаж байгаа гэж, үлдсэн 100 хоригдогч буюу 19 хувь нь “заримдаа”, 132 хоригдогч буюу 25 хувь нь “үгүй” гэж хариулжээ.


⁷² Куба Улсын Гавана хотноо 1990 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд хуралдсан “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх” Нэгдсэн Үндэстний Байгууллагын VIII их хурлаас баталсан.

⁷³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан.


Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхээ эдэлж чадаж байгаа эсэх



Хувийн болон улсын өмгөөлөгчтэй оролцогчдоор дээрх үзүүлэлтийг задалж үзвэл:



Дээрх хүснэгтээс үзвэл улсын өмгөөлөгчтэй хоригдогчдын 16.7 хувь нь өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгаа бол хувийн өмгөөлөгчтэй хоригдогчдын 30 хувь нь уг эрхээ эдэлж чадахгүй байна.




Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр өмгөөлөгчид цаг хугацаандаа ирж уулздаггүй, хүнд суртал гаргадаг талаар, мөн цагдан хорих ангийн ажилтан, албан хаагчид хурдан уулзахыг шаарддаг зэрэг асуудлаар гомдлоо илэрхийлж байлаа.

Тохиолдол:

... Миний бие 8 сарын турш цагдан хоригдохдоо өмгөөлөгчийнхөө царайг 2 удаа л харснаас биш ганцаарчлан уулзаж, ярилцаагүй...

(Цагдан хорих 461-р ангид хоригдож буй иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)



Судалгаанаас үзэхэд өмгөөлөгч цаг хугацаандаа ирж уулзахгүй байгаагаас баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд нь өмгөөлөгчтэйгээ уулзах хүсэлтээ ар гэрийнхэн, хамт хоригдож байгаа хүмүүс өмгөөлөгчөөр болон бусад холбогдох байгууллагуудаар дамжуулан гаргаж байгаа нь тэдэнд өмгөөлөгчдийн зүгээс үзүүлж буй хүнд суртал, чирэгдлийн нэг хэлбэр юм. Иймээс өмгөөлөгчдийн ажлын хариуцлагыг сайжруулахад зайлшгүй анхаарах шаардлагатай байна.

Тохиолдол:

Цагдан хорих 461 дүгээр ангид өмгөөлөгчид үйлчлүүлэгчтэй уулзах дараалал, дуудах журмын зохицуулалтыг боловсронгуй болгож, өмгөөлөгчид шүүхэд төлөөлөх эрхийнхээ дагуу дугаартай учир энэхүү дугаараар нь цахим бүртгэлжүүлж, өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ уулзах цаг хугацааг утсаар, цахимаар мэдэгддэг тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна. Олон жил ярьж байгаа ч одоог хүртэл шийдэгдээгүй. Хэрвээ өмнөх өмгөөлөгч маань 10-15 үйлчлүүлэгчтэй уулзах бол бусад өмгөөлөгчид өөрсдийн үйлчлүүлэгчтэй уулзах дарааллаа хүлээн 2-3 цаг хүртэл хугацаагаар хүлээх болдог нь ихээхэн чирэгдэлтэй байна.

(Улаанбаатар хотын өмгөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)

Тохиолдол:

...үйлчлүүлэгчтэйгээ цагдан хорих байранд очиж уулзая гэхээр ганцаарчлан уулзах боломж байхгүй. Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ уулзах боломж нь бүрдээгүй. Эрх нь байгаа ч төрийн байгууллага үүнд хаалт хийж байна. Цагдан хорих байранд мөрдөн байцаагчийн өрөө байна. Цуг суугаад ярьж болж байна. Гэтэл өмгөөлөгч хананы хоёр талаас, шилэн хаалтны цаанаас утсаар ярьдаг. Гэтэл дуу чимээ тусгаарлах зүйл байхгүй, гадаа нь үйлчлүүлэгчээ хүлээгээд сууж байгаа өмгөөлөгчид болон бусад цагдан хоригдож байгаа хүмүүс дээр эргэлтээр ирсэн хүмүүс бидний хоорондын яриаг сонсоод л сууж байдаг.

...цагдан хорих байрны уулзалтын өрөө нь нэг л хүн уулзах боломжтой, өмгөөлөгч нар зэрэгцээ оччихвол хүний яриа сонсоод зогсоод байлтай биш, гадаа хүйтэнд хүлээгээд л өдөржин зогсдог.

(Дархан-Уул аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Тохиолдол:

...Ховд аймаг дахь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албаны Цагдан хорих байранд эргэлт, уулзалтын өрөө байхгүй, улмаар ар гэрийнхэнтэйгээ уулзах, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, хууль зүйн туслалцаа авах эрх зөрчигдөж байна.

...Говь-Алтай аймаг дахь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албаны Цагдан хорих байрны эргэлт, уулзалтын өрөөний талбайн хэмжээ маш бага, жижүүрийн өрөөнд байрладаг тул сэжигтэн, яллагдагч нар өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах боломж бүрдээгүй тул эргэлт уулзалтын байрны талбайн хэмжээг нэмэгдүүлэх, өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжийг бүрдүүлэх.

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт хүргүүлсэн 2014 оны 1/15, 2015 оны 1/140 Зөвлөмжөөс)

Төрөөс цагдан хоригдож байгаа хүн нь хойшлуулалгүйгээр, ямар нэг саад, хяналтгүйгээр өмгөөлөгчтэйгээ уулзах орчныг бүрдүүлэх, цагдан хорих ангийн ажилтнууд нь баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд болон түүний өмгөөлөгчийн хоорондын харилцаа болон зөвшилцлийн нууцлалыг хүндэтгэн үзэх ёстой. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, харилцах эрх хүн бүрт, ялангуяа эрүүгийн хэргийн улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон ба яллагдсан бүх хүнд хамаарна.

Цагдаагийн хэлтэс, цагдан хорих анги баривчлагдсан, цагдан хоригдсон бүх хүнийг өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах, харилцах нөхцөлөөр хангана. Энэхүү нөхцөлийг цагдан хоригдож буй хүн болон түүний өмгөөлөгчийн хоорондын аман ба бичгийн харилцаа холбооны нууцлалыг хадгалахуйц хэлбэрээр бүрдүүлэх ёстой.

2.8. Өмгөөлөгч ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшилж буй байдал

Эрүүгийн хэрэгт холбогдсон хүн бүр шүүх хуралдааныг хойшлуулалгүй явуулах боломжит хугацаанд хэргээ шүүхээр шүүлгэх эрхтэй. Шүүх хуралдаан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлох ёсгүй бөгөөд хэргийн ээдрээтэй нөхцөл байдлаас хамаарч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацааг тогтоодог хэдий ч эрүүгийн хэрэгт татагдан, баривчлагдан, цагдан хоригдсон нөхцөлд аль болох богино хугацаанд шүүн таслах ажиллагааг явуулах нь төрийн үүрэг болно.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3 (с)-д заасны дагуу хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн байх баталгаагаар хангагдах ёстой.

Шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулах нь эрүүгийн хэрэгт буруутгагдаж, баривчлагдан, цагдан хоригдсон аливаа этгээдийн аль болох богино хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх зөрчигдөх нэг нөхцөл болно.


2015 онд Нээлттэй нийгэм форумаас хийсэн “Шүүх хуралдааны ажиглалт” судалгааны нэгдсэн тайланд өмгөөлөгч ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшлох явдал түгээмэл гарч байгааг баримтжуулсан байна. Тухайлбал, өмгөөлөгч томилолттой, цаг тухайд нь мэдэгдээгүй, өвчтэй байсан, хурал давхардсан, ар гэрт ажил гарсан, өмгөөлөгч нэмж авах хүсэлт гаргасан, шинжээч оролцуулах хүсэлт гаргасан, гэрч оролцуулах хүсэлт гаргасан, шүүгдэгчийн өмгөөлөгч солигдсон зэрэг шалтгаанаар шүүх хурал хойшилжээ. Ялангуяа эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшлох явдал улсын яллагч, өмгөөлөгчөөс шалтгаалах нь их байна.

Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хурал хойшлуулах хүсэлтийг урьдчилан мэдэгдэж байж хэргийн бусад оролцогч болон шүүхийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахаас сэргийлэх боломжтой. Гэтэл практикт шүүх хуралдаан нээсний дараа гэнэт хүсэлт тавьдаг жишиг бий болсон байна⁷⁴.

Судалгаанд оролцогчдоос өмгөөлөгч ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшилж байсан эсэхийг тодруулахад дараах байдалтай байна.


⁷⁴ “Шүүх хуралдааны ажиглалт” Судалгааны нэгдсэн тайлан, Нээлттэй нийгэм форум, УБ, 2015 он

Өмгөөлөгч ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшилсон эсэх



Тийм гэж хариулсан 130 хоригдогчоос чухам ямар үндэслэлээр хойшилж байсныг тодруулахад 23.8 хувь нь өмгөөлөгчийн бусад шүүх хурал давхацсан, 13,8 хувь нь өмгөөлөгч өвчтэй байсан, 10.7 хувь нь өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаантай, 5 хувь нь өмгөөлөгч томилолттой байсан, 2 хувь нь өмгөөлөгч шүүх хуралдаанд хоцорч ирсэн гэдэг шалтгаанаар шүүх хурал хойшлуулж байсан гэж хариулжээ.

Шүүх хуралдаан хойшилсон шалтгаан




Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс 2015 оны 1 дүгээр сарын 2-оос 9 дүгээр сарын 30-ыг хүртэлх хугацаанд хийсэн судалгаагаар Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 4378 шүүх хуралдаан товлосноос 2001 удаа хойшлуулсан нь 45.7 хувийг эзэлжээ. Өөрөөр хэлбэл, 2 хурлын нэг нь хойшилдог үзүүлэлттэй байна.

Хойшилсон 2001 удаагийн шүүх хуралдааны 532-т нь өмгөөлөгч өвчтэй, 248-д нь өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, 207-д нь өмгөөлөгчийн бусад хурал давхацсан гэх зэрэг шалтгаанаар хойшлуулж байжээ⁷⁵.

⁷⁵Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс хийсэн “Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс хэрэг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа”, 2015 он

Шүүх хуралдаанд өмгөөлөгч ирээгүйн улмаас таны таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, цагдан хорьсон уу гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна.




Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй.

Иймээс шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулах нь эрүүгийн хэрэгт буруутгагдаж, баривчлагдан, цагдан хоригдсон аливаа этгээдийн аль болох богино хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх зөрчигдөх нэг нөхцөл болно. Ялангуяа өмгөөлөгч, улсын яллагч хэд хэдэн хэрэгт давхар ажиллаж байгаа тохиолдолд шүүх хуралдааны товыг давхардуулахгүй байх үүднээс бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх нь чухал байна.

Шүүхийн зүгээс тодорхой хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй өмгөөлөгчид хариуцлага тооцох саналыг Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд тавьж шийдвэрлүүлдэг байх шаардлагатай байна.

Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хангасан уу гэсэн асуултад судалгаанд оролцогчид дараах хариултыг өгчээ.



“Үгүй” гэж хариулсан оролцогчдоос шалтгааныг тодруулахад 33 хувь нь давж заалдах гомдлоо гаргах хүсэлтэй байсан ч өмгөөлөгч ирж уулзаагүй, 20 хувь нь гомдол гаргах эрхийг хангаагүй шалтгааныг мэдэхгүй байна, 16 хувь нь давж заалдах хэрэггүй, ял чинь хүндэрнэ гэж зөвлөсөн, 13 хувь нь давж заалдах шаардлагагүй, тохирсон ялаа авсан, 11 хувь нь давж заалдах хэрэггүй, би ажлаа мэдэж байна гэсэн шалтгаанаар давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдлыг нь гаргуулаагүй гэж хариулжээ.

Тохиолдол:

Цагдаа дээр ч, шүүх дээр ч өмгөөлөгч хэргийн материалтай танилцах ямар ч боломж байхгүй. Өрөө гаргаж өг гэхээр гаргаж өгдөггүй. Хэргийг шалгаж байгаа мөрдөн байцаагч нь хажууд хараад суучихдаг. Мөрдөн байцаагчийн өрөөний буланд суугаад хэргийн материалаас шаардлагатай юмаа тэмдэглэж авна. Шүүх дээр ч ялгаагүй Эрүүгийн хэргийг нарийн бичгийн өрөөнд, иргэний хэргийг коридорт суугаад үздэг. За тэгээд үйлчлүүлэгчээ дуудуулахаар та ажил дээрээ очиж уулз, энд уулзуулахгүй, оруулахгүй гэдэг.

Тахарын албаныхантай ойлголцоход хэцүү. Зүгээр нэг цалин аваад шүүхээ хамгаалаад байж байдаг. Бид нар үг хэлэх гэхээр чи дуугүй байж бай, яагаад шүүгчийн урдаас юм яриад байгаа юм гэдэг. Гэтэл бидний ажлын нэг хэсэг тэр шүүхийн танхимд явагдахгүй өөр хаана явагдах юм бэ? Давахын шүүх дээр ч гэсэн ийм байдалтай байна. Манай аймгийн хувьд зөвхөн прокурорын газар л өмгөөлөгчдөд зориулсан тусдаа өрөөтэй.


(Дархан-Уул аймгийн өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

2.9. Өмгөөлөгчөөс татгалзаж буй тохиолдол, шалтгаан

Гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүн бүр өөрт тулгаж буй ялын эсрэг өөрийгөө өмгөөлөх бүрэн эрхтэй. Өөрийгөө төлөөлөх зарчмын дагуу яллагдагч этгээд нь байцаалтын үеэр болон шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч авалгүй, шүүх хуралдаанд өөрийгөө төлөөлөхөөр шийдэж болно. Тухайн хүний байцаалтын болон бусад үед өмгөөлөгч байлцуулах эрхээсээ татгалзахаар гаргасан шийдвэр нь эргэлзээ төрүүлэхээргүй байх ёстой ба зохих баталгаагаар хангагдана. Мөн өмгөөлөгч авах эрхээсээ татгалзсан этгээд уг татгалзлаа хүчингүй болгох эрхтэй.

Судалгааны үзүүлэлтээс үзвэл өмгөөлөгчтэй хоригдогчдын 19 хувь нь өмгөөлөгчөөсөө татгалзаж байсан байна.

Өмгөөлөгчөөсөө татгалзаж байсан эсэх



Улсын өмгөөлөгчөөс татгалзсан, 25, 25%




Хувийн өмгөөлөгчөөс татгалзсан, 75, 75%

■ Хувийн өмгөөлөгчөөс татгалзсан ■ Улсын өмгөөлөгчөөс татгалзсан

Өмгөөлөгчөөсөө татгалзаж байсан хоригдогчдын хувьд хувийн өмгөөлөгчөөсөө татгалзаж байсан хоригдогчдын тоо харьцангуй их байна. Хувийн өмгөөлөгчтэй хоригдогчдоос өмгөөлөгчөөсөө татгалзаж байсан шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна.


UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Улсын өмгөөлөгчтэй хоригдогчдоос өмгөөлөгчөөсөө татгалзаж байсан шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна.




Хоригдогчдын тодорхой хувь нь өмгөөлөгчөө сольж байсан бөгөөд эдгээрийг улсын болон хувийн өмгөөлөгчийн ангиллаар гаргаж үзвэл:



Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу өмгөөлөгч өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчээс хөлс авах бөгөөд өмгөөллийн үйлчилгээний хөлсийн хэмжээг өмгөөлөгч, үйлчлүүлэгч гэрээгээр харилцан тохиролцоно. Иргэний эрх зүйн гэрээний чөлөөт байдлын зарчим ёсоор тухайн гэрээний гүйцэтгэлийг талууд дүгнэх, төлөх хөлсний хэмжээг бууруулах, ихэсгэх, эсхүл буцаан шаардах боломжтой.

Өмгөөлөгчөө солих үед өмгөөллийн хөлсөө буцаан авч чаддаг эсэхийг хувийн өмгөөлөгчтэй хоригдогчдоос асуухад дараах хариултыг өгчээ.




Тохиолдол:

...Би өмгөөлөгч аваад 1 жил 4 сар болж байна. Өмгөөллийн хөлсөнд 3 сая гаруй төгрөг төлсөн. Гэтэл цагдан хоригдсоноос хойш уулзахгүй, бусад цагдан хоригдож байгаа хүмүүсийн өмгөөлөгчөөр дамжуулж надад хэл хүргэж, ажлаа хийдэг байсан. Өмгөөлөгчөөсөө болоод давж заалдах гомдлоо бичиж чадаагүй. Өмгөөлөгч солих асуудал ярихаар өмгөөлөгч маань шалтгаан тоочоод амлалт өгөөд явдаг, тэгээд ор тас алга болдог. Сураг сонсох нь хүүхдээ төрүүлээд гэртээ ажлаа хийхгүй байгаа гэсэн. Дахин өмгөөлөгч авахаар болж байна...

(Цагдан хорих 461 ангид цагдан хоригдож буй иргэнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Өмгөөллийн хөлсөө буцаан авч чадахгүй байгаа шалтгаан




- буцаах талаар ярилцаж байгаагүй
- буцааж авъя гэвэл хэрэгт буруугаар нөлөөлнө гэж бодоод хэлээгүй
- тодорхой үйлчилгээ үзүүлсэн талыг нь өгнө гэдэг
- буцааж авч болдог гэж мэддэггүй
- тодорхой үйлчилгээ үзүүлсэн буцааж өгөхгүй гэдэг
- буцааж авч чадаагүй, өгдөггүй, зугтдаг
- гэрээнд төлбөрийг буцаан өгөхгүй гэж заасан байдаг
- мөнгөө буцаан авах гэтэл нэмж мөнгө нэхсэн
- чи өөрөө надаас татгалзсан болохоос би татгалзаагүй гээд өгөөгүй




2.10. Хууль зүйн туслалцааны талаар гомдол гаргаж буй байдал

Судалгаанд оролцогчид өмгөөлөгчдийн үзүүлж буй хууль зүйн туслалцааны чанарыг дараах байдлаар үнэлжээ.



Өмгөөлөгчийн үзүүлж буй хууль зүйн туслалцааг “дунд, муу” гэж үнэлсэн оролцогчид ийнхүү үнэлсэн шалтгаанаа дараах байдлаар илэрхийлжээ.



Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо хянан шийдвэрлэдэг⁷⁶. Тус хороо нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд Хуульчдын холбооны хүсэлтээр дүгнэлт гаргах, хуульч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэх болон Хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргааныг гомдлын дагуу хянан шийдвэрлэдэг болно.

⁷⁶Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.5.1

Мэргэжлийн хариуцлагын хороо нь 2014 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд, иргэд байгууллагаас өмгөөлөгчидтэй холбогдуулан ирүүлсэн 330 гомдол, мэдээллийг хянаж, үүнээс 178 гомдолд маргаан үүсгэхээс татгалзаж, 127 гомдолд маргаан үүсгэн хянан шалгасан байна.

Өмгөөлөгчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд 16 сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан этгээдээс гомдол гаргасан бол бусад гомдлыг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн ар гэрийнхэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг талын оролцогчид түүнчлэн байгууллага, аж ахуйн нэгж, шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар болон хөндлөнгийн иргэд гаргасан байна.

Өмгөөлөгчид холбогдуулан гаргаж байгаа гомдлын агуулгыг авч үзэхэд хууль зүйн туслалцаа үзүүлээгүй буюу зохих ёсоор үзүүлээгүй, ам хэлээр доромжилдог, загнадаг, ажлын хөлснөөс гадна илүү мөнгө үйлчилгээ шаарддаг, худал мэдүүлэхийг зөвлөдөг, эсрэг талд үйлчилдэг, цагдан хорих байрны дотоод журам зөрчсөн, шүүх хуралдаанд ирдэггүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэл хийдэг асуудлаар болон өмгөөллийн үйлчилгээний хөлсөнд төлсөн зардлаа буцааж авах хүсэлт дийлэнх нь байна⁷⁷.

Өмгөөлөгчөө сонгох, хууль зүйн туслалцаа авах эрхийнхээ асуудлаар бусад байгууллагад өргөдөл, гомдол гаргаж байсан эсэхийг тодруулахад 456 хоригдогч хариулсны 51 нь буюу 11.2 хувь нь “тийм” гэж хариулжээ. Тэднээс аль байгууллагад хандсаныг судалж үзэхэд Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв, Хүний эрхийн Үндэсний Комисст, УИХ-ын Хүний эрхийн дэд хороонд ханджээ.

Хүний салшгүй эрхийг хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорьж мөрдөх ажиллагаа нь гарцаагүй тохиолдолд хэрэгжүүлэх эцсийн арга хэрэгсэл бөгөөд түүнийг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлдэг байх нөхцөлийг холбогдох хууль тогтоомжоор бүрдүүлж, хангадаг байх шаардлагатай юм.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг зөрчихгүй байх, хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдахгүй байх, гэм буруугүй хүний эрх, эрх чөлөөнд халдан баривчлах, цагдан хорихгүй байх, улмаар хилсээр ял шийтгэл хүлээлгэхгүй байх нэг чухал нөхцөл нь өмгөөлөгчийн оролцоо байдаг.

Судалгаанд оролцсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчидтэй хийсэн ярилцлагын үеэр өмгөөлөгчид үйлчлүүлэгчээ хүндлэх, харилцан ойлголцох, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалах, хэргийн зүйлчлэл болон төлбөрийн чадваргүй байгаагаас хамаарч ялгаварлан гадуурхахгүй байх, үйлчилгээний хөлсөө тооцох аргачлал, нөхцөлөө ямар нэгэн хоёрдмол ойлголтгүйгээр харилцан тохиролцох, хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг хүсч байна гэсэн санал хүсэлтийг тавьж байв. Гэвч үйлчлүүлэгчдээ худал амлалт өгч хуурах, хууль зүйн туслалцааны үйлчилгээгээ хангалттай гүйцэтгээгүй байж дахин хөлс шаардаж, дарамт үүсгэдэг, шүүх хуралд ирэхгүй чирэгдүүлдэг зэрэг асуудлаар гомдол гарч байна.

⁷⁷ Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны 2015 оны 11 дүгээр сарын 10-ны 3/445 дугаар албан бичиг

Иймээс өмгөөлөгч ажил үүрэгтээ хайхрамжгүй хандан, үйлчлүүлэгчээ үл хүндэтгэн, ялгаварлан гадуурхаж байгаа үйлдлийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил гаргахгүй байх, түүнчлэн өмгөөлөгчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагууд тодорхой ажлууд зохион байгуулах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнг дүгнэж, цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, өмгөөлөгчийн эрх үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах асуудалд анхаарах шаардлагатай байна.

- Анх хэрэгт холбогдсон үеэс хууль зүйн туслалцаа авах эрхээр хангагдах нөхцөлийг бүрдүүлэхэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид онцгойлон анхаарах шаардлагатай байна. Ялангуяа прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрхэн хангаж байгаад тавих хяналтаа сайжруулах;
- Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын холбоогоор дамжуулан төлбөрийн чадваргүй иргэдэд улсын болон хувийн өмгөөлөгчийг оролцуулахдаа тэдний сонголтыг заавал анхаарч үздэг болох;
- Хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцсон цагаас эхлэн өмгөөлөгч нь үйлчлүүлэгчдээ өмгөөллийн үйлчилгээний хөлс, түүнийг тооцох аргачлалыг гэрээндээ тодорхой зааж, үйлчлүүлэгчээсээ хөлс авсан тухай бүрт баримт олгож хэвших;
- Өмгөөлөгчид хууль зүйн туслалцааны үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, үйлчлүүлэгчээсээ хууль бус хөлс шаардсан тохиолдлыг шалгаж, ёс зүйн хариуцлага хүлээлгэж хэвших;
- Өмгөөлөгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж байнга холбоотой байж, тогтмол мэдээллээр хангаж ажиллах;
- Мэргэжлийн байгууллага өмгөөлөгч үйлчлүүлэгчдээ гэрээнд заасан нөхцөлийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа талаар мониторинг хийх;
- Мэргэжлийн ёс зүйгүй, хариуцлагагүй ажиллаж байгаа өмгөөлөгчийн талаарх гомдлыг холбогдох байгууллагын зүгээс шуурхай хүлээн авч шийдвэрлэдэг байх;
- Өмгөөлөгч, улсын яллагч хэд хэдэн хэрэгт давхар ажиллаж байгаа тохиолдолд шүүх хуралдааны товыг давхардуулахгүй байх үүднээс бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
- Шүүхийн зүгээс тодорхой хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй өмгөөлөгчид хариуцлага тооцох саналыг Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд тавьж шийдвэрлүүлэх;
- Мэргэжлийн байгууллагын сургалтын чанарыг сайжруулах, гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүйгүй ажилласан өмгөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг гаргаж олон нийтэд мэдээллэх;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АХМАД НАСТНЫ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

“Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.”

(Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 22 дугаар зүйл)

“...өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт)

Нийгмийн хамгааллын бодлого нь аль ч улс орны хөгжлийн бодлогод чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэхдээ нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээг шаардлагатай бүлэгт хүргэх, үр ашигтай хэлбэрээр хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Ялангуяа ахмад настнуудын эрхийг баталгаатай эдлүүлэхэд тэдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын цогц бодлого, үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Дэлхий дахинд ахмад настны тоо эрчимтэй өсч байна. Ахмад настнууд 1994 онд дэлхийн хүн амын 9 хувийг эзэлж байсан бол 2014 онд 12 хувь болсон бөгөөд 2050 он гэхэд 21 хувьд хүрэх төлөвтэй байна⁷⁸. Монгол Улсын хувьд 2040 он гэхэд хүн амын 16 хувь нь насжиж, хөдөлмөрийн насны хүн амд ногдох ахмад настны тоо нэмэгдэж, 2010 онд 10:1 харьцаатай байсан бол 2040 он гэхэд 4:1 болох төлөвтэй байна⁷⁹.

Өдгөө ахмад настны эрхийг тусгайлан баталгаажуулсан хүний эрхийн олон улсын гэрээ байхгүй ч насаар ялгаварлан гадуурхахыг хориглох үзэл санаа олон улсын гэрээнүүдэд тусгалаа олжээ. Хэдийгээр олон улсын гэрээний зохицуулалт дутмаг боловч ахмад настан хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлэх, тэдний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр дэлхий дахинд тодорхой ахиц дэвшил гарч байна. Үүнд Венийн 1982 оны Насжилтийн талаарх Олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөө, 1991 оны Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ахмад настны талаарх зарчим, Мадридын 2002 оны Насжилтийн талаарх Олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг дурдаж болно.

⁷⁸Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн газрын (ST/ESA/SER.A/354) Дэлхийн хүн амын талаарх нөхцөл байдлын илтгэл, 2014 он.

⁷⁹Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн A/RES/65/182 тогтоолоор ахмад настны эрхийг цогцоор нь хамгаалж, баталгаажуулсан олон улсын гэрээг боловсруулах шаардлагыг судлуулахаар Насжилтын асуудал хариуцсан Ажлын хэсэг байгуулсан юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга 2011 онд Ерөнхий Ассамблейд анх удаа дэлхий дахинд ахмад настны эрхийн нөхцөл байдлыг илтгэжээ. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссар 2012 оны 4 дүгээр сард ахмад настныг хамгаалах олон улсын тогтолцоог бэхжүүлэх шаардлага байгааг тайландаа дурджээ. Ингэснээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн A/HRC/24/L.37/Rev.1 тогтоолоор ахмад настны эрхийн хэрэгжилт хариуцсан Тусгай шинжээчийг томилсон байна.

Үүний зэрэгцээ улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллагууд, Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон улсын Зохицуулах Хороотой хамтран ахмад настны эрхийн чиглэлээр ажиллаж, туршлага хуримтлуулж байна. Зарим улс орны хүний эрхийн үндэсний байгууллага ахмад настны эрхийн хэрэгжилт эмзэг бүлэгт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Тухайлбал, Марокко Улсын Хүний эрхийн Үндэсний Зөвлөл Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон улсын Зохицуулах Хороотой хамтран Маракеш хотноо 2014 оны 11 дүгээр сард Дэлхийн хүний эрхийн II чуулганыг “Ахмад настай хүний эрх: Ахмадыг хамгаалах, хөхиүлэн дэмжих боломж, арга зам” сэдвээр зохион байгуулж, улмаар чуулганд оролцсон шинжээчид ахмад настны эрхийн асуудлаар Маракешийн Тунхаглалыг боловсруулан баталжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” болохыг баталгаажуулж, Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн халамжийн багц хуулийг тус тус мөрдөж байгаа нь төрөөс зайлшгүй дэмжлэг туслалцаа үзүүлбэл зохих иргэдийн “ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрх”-ийг⁸⁰ хангаж, хамгаалах нийгмийн хамгааллын тогтолцоог олон улсын хэм хэмжээ, зарчимд нийцүүлэхэд томоохон дэвшил болсон юм.

Монгол Улсад 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй⁸¹ ахмад настан гэж үзнэ.

Манай улс бүс нутагтаа тэтгэврийн хэмжээгээр тэргүүлэгч улсуудын нэг бөгөөд ахмад настны дунд ядуурал бага, халамжийн түвшин өндөртэй улсын тоонд багтаж, Дэлхийн насны хяналтын индекс⁸²-ийн 72 дугаарт бичигдсэн

⁸⁰Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор баталсан Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйл.

⁸¹ Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг

⁸²Дэлгэрэнгүй тоо баримт, мэдээллийг <http://www.helpage.org/global-agewatch/> цахим хуудаснаас авах боломжтой ба Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан газар, Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага зэрэг байгууллагаас боловсруулсан мэдээллийн санд тулгуурладаг болно.

байна. Харин уг индекст ахмад настны нийтийн тээврийн үйлчилгээ, хувийн аюулгүй байдлын үзүүлэлт хангалтгүй дүнтэй гарсан байна. Мөн төрийн алба болон хувийн хэвшилд ахмад настны хөдөлмөрлөх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас насаар ялгаварлан гадуурхах нөхцөл байдал үүсч байгааг сануулжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр 2014 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”-наас үзэхэд сүүлийн 10 жилд Монгол Улсын нийт хүн амын тоо 16.1 хувиар өссөн бол ахмад настны тоо 21.9 хувиар өсчээ.

Испани Улсын Мадрид хотноо 2002 онд баталсан Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 5 сарын 26-ны өдрийн 156 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратеги”-д хүн амын эрүүл насжилтын асуудлыг тусгасан байна.

Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 97 дугаар тогтоолоор Хүн амын асуудлаарх Үндэсний хороог байгуулав. Уг хороо 2014 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын Хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратеги”-ийг 2014-2016 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж, Хүн амын асуудлаарх үндэсний хорооны дарга бөгөөд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/77 дугаар тушаалаар баталсан байна.

Гэвч хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, ахмад настны талаарх нийгэм, эдийн засгийн нарийвчилсан судалгаа, статистик мэдээ дутмаг байгаа нь Засгийн газраас бодит ажил төлөвлөхөд хүндрэл учруулж байгааг зарим судалгаа харуулж байна⁸³.

Дээрх нөхцөл байдалд үндэслэн Комисс ахмад настны нийгмийн хамгаалал, ахмад настны эрхийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар энэхүү илтгэлд тусгалаа.

3.1. Олон улсын санаачилга, үйл ажиллагаа

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад ахмад настны эрхийг нарийвчлан тодорхойлоогүй ч тус пактын 9 дүгээр зүйлд “Энэхүү пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэснээр ахмад настны нийгмийн даатгал, халамжид хамрагдан тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулжээ. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын зохицуулалт нийгмийн бүх гишүүнд чиглэсэн учир уг пактад заасан бүх эрх, эрх чөлөөг ахмад

⁸³Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.

настан мөн адил эдлэх эрхтэй юм. Мөн уг пакт эдгээр эрхийг эдлүүлэхийн тулд нэгдэн орсон улс бүр өөрийн нөөц бололцоог боломжит дээд хэмжээгээр дайчлан ажиллахыг шаарддаг.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 2 дугаар зүйлд⁸⁴ заасан ялгаварлан гадуурхахыг хориглосон ерөнхий заалт нь хүнийг насаар ялгаварлан гадуурхахыг хориглох санааг агуулдаг юм.

Бүс нутгийн шинжтэй олон улсын гэрээнд, тухайлбал, Америк тивийн Хүний эрхийн тухай конвенцийн Нэмэлт протоколын 17 дугаар зүйл⁸⁵, Европын холбооны суурь эрхүүдийн тухай дүрмийн 25 дугаар зүйл⁸⁶, Африк тивийн Хүний ба ард түмний эрхийн тухай дүрмийн 18 дугаар зүйл⁸⁷-д ахмад настны эрхийн талаар заажээ.

Австри Улсын Вена хотноо 1982 онд болсон Насжилтын асуудлаарх Дэлхийн бага хурлаас Венийн Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөө⁸⁸ гаргасныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей баталсан байна. Энэ төлөвлөгөө нь ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр оролцогч улс бүрийн авах ёстой арга хэмжээг нарийвчлан тодорхойлсноороо чухал удирдамж болжээ. Төлөвлөгөөнд багтсан 62 зөвлөмжийн дийлэнх нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакттай шууд холбоотой юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1991 онд ахмад настанд чиглэсэн “Нэгдсэн Үндэстний зарчмууд”⁸⁹-ыг гаргаж, ахмад настны бие даасан байдал, нийгэм дэх оролцоо, нийгмийн халамж, өөрийгөө хөгжүүлэх боломж, эрхэм чанар зэргийг тухайлан авч үзжээ.

Венийн Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргасны 10 жилийн ойгоор буюу 1992 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей Насжилтын асуудлаарх тунхаглалыг баталжээ⁹⁰. Энэхүү тунхаглалд ахмад настан эмэгтэйчүүдийн нийгэмд оруулсан хувь нэмрийг дутуу үнэлж байгааг онцолж, тэдний оролцоог зохистой үнэлдэг болох, нийгэм, соёл, сэтгэл санааны чадавхиа хөгжүүлж чадаагүй ахмад настан эрэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх, мөн тэдний асаргаа сувилгаанд нь зориулж гэр

⁸⁴ Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.

⁸⁵<http://www.oas.org/juridico/english/treaties/a-52.html>

17 дугаар зүйл. Ахмад настны хамгаалалт

Бүх хүн ахмад насандаа тусгайлан хамгаалуулах эрхтэй. Энэхүү эрхийг бодитой эдлүүлэхийн тулд оролцогч улс тодорхой үе шат бүхий дараах арга хэмжээг авахыг зөвшөөрнө. Үүнд:

а. Өөрсдийгөө орон байр, хоол хүнс, дагнасан эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах боломжгүй, түүгээр дутагдаж буй ахмад настныг хангах;

б. Ахмад настныг тэдний хүсэл сонирхолд нь нийцсэн, чадамжид тохирсон бүтээлч үйл ажиллагаанд хамрагдах боломжоор хангахад чиглэсэн ажил эрхлэлтийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх;

с. Ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэхээр нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг байгуулахыг дэмжих;

⁸⁶<http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:12012P/TXT>

25 дугаар зүйл Ахмад настны эрх. Ахмад настныг эрхэм чанараа дээдлүүлж, бие дааж амьдрах, нийгмийн болон соёлын амьдралд оролцох эрхийг нь хүлээн зөвшөөрч, хүндэтгэх үүргийг Холбоо хүлээнэ.

⁸⁷<http://www.achpr.org/instruments/achpr/#a18>

18 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг. Ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн бие махбодийн болон оюун санааны хэрэгцээгээ хадгалж хамгаалуулах тусгай туслалцаа авах эрхтэй.

⁸⁸<http://www.un.org/es/globalissues/ageing/docs/vipaa.pdf>

⁸⁹<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/OlderPersons.aspx>

⁹⁰<http://www.un.org/documents/ga/res/47/a47r005.htm>

бүлийн гишүүдэд нь туслалцаа үзүүлэх зэрэг санаачилгыг дэмжсэн байна. Үүний зэрэгцээ хүн амын насжилт нэмэгдэж байгаатай уялдуулан 1999 оныг Олон улсын ахмад настны жил болгон зарлажээ⁹¹.

Дэлхий нийт XXI зууныг “Насжилтын зуун” хэмээн нэрлэж, 2002 онд Мадрид хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 156 орны Засгийн газрын тэргүүнүүд оролцсон Ерөнхий чуулганаараа насжилтын асуудлаарх олон улсын төлөвлөгөөг хэлэлцэж, Улс төрийн тунхаглал гарган бүс нутаг, гишүүн орнуудад насжилтын асуудлаар өөрийн онцлог байдлыг тусгасан бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллахыг зөвлөсөн юм⁹².

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 65/182 дугаар тогтоолоор Нээлттэй ажлын хэсэг⁹³ байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг нь ахмад настны эрхийг баталгаажуулж, зохицуулж буй олон улсын хэм хэмжээнд судалгаа хийх, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг тодорхойлох зорилготой ажилласан байна. Улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 67/139 дүгээр тогтоолын хүрээнд Нээлттэй ажлын хэсэгт “ахмад настны эрх, эрхэм чанарыг хамгаалах, хөхиүлэн дэмжих олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үндсэн элементүүдийг агуулсан санал бэлтгэх...”⁹⁴ үүрэг өгчээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2015 оны 7 дугаар сарын 29-ний өдөр Нээлттэй ажлын хэсгийн тайланг хэлэлцээд⁹⁵ ойрын хугацаанд ахмад настны эрхийг хамгаалахад чиглэсэн олон улсын хэм хэмжээний төслийг бэлэн болгох чиглэлээр ажиллахыг хүссэн байна. Үүнээс гадна Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл 2013 онд зохион байгуулсан 24 дэх хуралдаанаараа⁹⁶ ахмад настны бүхий л хүний эрхийн хэрэгжилтийг үнэлэх чиг үүрэг бүхий бие даасан шинжээчийг томилон ажиллуулж байна.

Гэсэн хэдий ч улс орнууд үндэсний хэмжээнд ахмад настны эрх, нийгмийн хамгааллын бодлогыг харилцан адилгүй тодорхойлж, хэрэгжүүлж байна.

3.2. Ахмад настны нийгмийн хамгааллын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын хэмжээнд 2014 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 345,800 хүн байгаагаас өндөр насны тэтгэвэр авагч 242,500 ахмад настан байгаа бөгөөд нийт хүн амын 8.1 орчим хувийг эзэлж байна. Тэтгэвэр авдаг нийт ахмад настны 51.4 хувь нь 64 хүртэл насныхан, 17.3 хувь нь 65-69 насныхан, 31.3 хувь нь 70-аас дээш насныхан байна.

Нийт хүн амын 4.1 хувийг эзэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 108,100 иргэний 12,500 нь ахмад настан байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн

⁹¹ Ерөнхий Ассамблейн 1992 оны 10 сарын 16-ны № 47/5 тогтоол, “Насжилтын талаарх тунхаглал”.

⁹²<http://social.un.org/index/Ageing/MadridPlanofActionanditsImplementation/RegionalImplementationStrategiesoftheMIPAA.aspx>.

⁹³<http://social.un.org/ageing-working-group/> (OEWG)

⁹⁴“Ахмад настны эрх, эрхэм чанарыг хамгаалах, хөхиүлэн дэмжих олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үндсэн элементүүдийг агуулсан санал бэлтгэх” Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 67/139 дүгээр тогтоолын 2 дахь заалт (A/RES/67/139) http://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/67/139

⁹⁵<http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N15/235/92/PDF/N1523592.pdf?OpenElement>

⁹⁶Ахмад настны эрх, Хүний эрхийн Зөвлөлийн 24 дүгээр хуралдаан, A/HRC/24/L.37/Rev.1 (2013), зүйл 5. http://ap.ohchr.org/documents/alldocs.aspx?doc_id=22360
<http://www.ohchr.org/EN/HRBodies/HRC/RegularSessions/Session24/Pages/24RegularSession.aspx>

амын 11.6 хувь, ахмад настны 8.3 хувийг эзэлж байна. Тэдний 47.4 хувь нь эрэгтэй, 52.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн 90.3 хувь нь олдмол, 9.7 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Түүнчлэн, 40 хувь нь хөдөлгөөний, 24 хувь нь харааны, 18 хувь нь сонсголын, ярианы, 6.3 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй ахмад настны 37.4 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна⁹⁷.

“Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллагаас гаргасан судалгаагаар нийгмийн даатгалын сангаас 241,900 өндөр настан, нийгмийн халамжийн сангаас 7900 ахмад настан тэтгэвэр авч, 70 хүртэл настай 146,900, 71-80 настай 54,700, 81-90 настай 15,000, 91-100 настай 3100, 100 ба түүнээс дээш настай 136 иргэн байна гэжээ.

Нийт ахмадуудын дотор хөдөлмөрийн баатар 158, ахмад дайчин 465, ардын болон гавьяат цолтон 1222, алдарт эхийн одонтой 116,582 эхчүүд байна. Түүнчлэн ахмад настнуудын амьжиргаа нь жил тутам буурч, 23.6 хувь нь эмзэг бүлэгт хамрагдаж байгаа бөгөөд 26,800 ахмад настан амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой, 5800 ахмад харж хандах хүнгүй ганц бие, 13,600 ахмад настан байнгын бусдын асрамжинд, 7870 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй байна⁹⁸.

3.2.1. Ахмад настны тэтгэвэр

Ахмад настны амьжиргааны гол эх үүсвэр нь өндөр насны тэтгэвэр юм. Ахмад настны тэтгэвэр тогтоолгох нөхцөл, үндэслэл журмыг 1994 онд баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулж байна. Тус хуульд 1996, 1997, 1999, 2000, 2012, 2015 онд тус тус 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Улсын Их Хурал 1999 онд Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль баталсан бөгөөд уг хуулиар тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, тухайн дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтоон олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байна. Тус хуульд 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 2015 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тэтгэвэр тогтоолгох дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох 5 жилийг зөвхөн нэг удаа сонгодог байсныг дахин нэг удаа өөрчлөх боломж олгож, тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ архивын баримтаар нотлогдохгүй тохиолдолд ижил ажил мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгохоор, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар тооцож нэмэгдэл олгохоор тус тус зохицуулжээ.

“Монголын Ахмадын чөлөөт холбоо” төрийн бус байгууллагаас гаргасан судалгаагаар ахмад настны хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 195,000, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 230,000, дундаж тэтгэвэр 283,800 төгрөг байна. Энэ нь

⁹⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.

⁹⁸ “Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллагаас Комисст ирүүлсэн 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 81 дүгээр албан бичиг

2004 онтой харьцуулахад хувь тэнцүүлсэн тэтгэвэр 9.75 хувь, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 7.18 хувь, дундаж тэтгэвэр 8.0 хувиар тус тус өссөн байна. Ахмадуудын 95 хувь зөвхөн тэтгэврээр, 5 хувь нь тэтгэврийн болон бусад орлогоор амьдарч байна. Зөвхөн тэтгэврээр амьдарч буй ахмадуудын 90 хувь нь тэтгэврийн зээлтэй. Тэтгэврийн зээлийн 78 хувийг ахмадууд гэр бүлдээ зориулдаг байна⁹⁹.

“Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллагаас гаргасан судалгаагаар тэтгэврийн хэмжээг сүүлийн 4 жилийн хугацаанд 2 удаа 20.0 орчим мянган төгрөгөөр буюу тэтгэврийн доод хэмжээг 14.8 хувиар, бусад тэтгэврийг 2-5 хувиар нэмэгдүүлсэн нь бага байна гэж үзжээ. Улс орны эдийн засаг дордож, валютын ханш өсч, бараа бүтээгдэхүүний үнэ өдөр тутам нэмэгдэж байгаагаас нэмэгдсэн тэтгэвэр нь ахмад настны амьжиргааны наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Тухайлбал, дунджаар 4 ам бүл бүхий өрхийг дан ганц тэтгэврээрээ тэжээж байгаа ахмад настан олон байна.

Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 53.3 хувь буюу 116.3 мянган ахмад настан тэтгэврийн доод хэмжээгээр өндөр насны тэтгэвэр авдаг бол 200.0-400.0 мянган төгрөгийн тэтгэвэртэй 86.2 мянга, 400.0-700.0 мянган төгрөгийн тэтгэвэртэй 14.5 мянга, 700.0 мянгаас дээш төгрөгийн тэтгэвэртэй 1.1 мянган ахмад настан байна. 500.0 мянган төгрөгөөс дээш тэтгэвэртэй хүмүүс нь нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 3.1 хувийг эзэлж байгаагаас үзэхэд ихэнх ахмад настан буюу 97 хувь нь бага тэтгэвэртэй амьдарч, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас ахмадууд тэтгэврийн зээл ихээр авч байна¹⁰⁰ гэжээ.

Засгийн газраас бүрэн тэтгэврийн доод хэмжээг 2006 онд 25 хувиар, 2007 онд дунджаар 30 хувиар, 2008 онд дунджаар 20 хувиар, 2010 онд 30 хувиар тус тус нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа боловч хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчид тэтгэврийн даатгалд хамрагдаагүйгээс тэдний ирээдүйн нийгмийн баталгаа алдагдаж, тэтгэврийн сан орлогоороо зарлагаа нөхөхгүй, тэтгэвэр авагчдын 60 гаруй хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна¹⁰¹.


Бүрэн тэтгэвэр ба хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг авч үзвэл дараах байдалтай байна. (мянган төгрөгөөр)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁹⁹ “Монголын Ахмадын чөлөөт холбоо” төрийн бус байгууллагаас 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн мэдээлэл.

¹⁰⁰ “Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллага 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 81 дүгээр албан бичиг.

¹⁰¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.



Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоон үзүүлэлтийг харьцуулж үзвэл дараах байдалтай байна¹⁰².

Үзүүлэлтүүд	2011 он	2012 он	2013 он	2014 он
Тэтгэвэр авагчдын тоо, мян/хүн	332.3	334.6	336.9	345.8
Өндөр насны	219.6	224.7	230.3	242.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний	67.0	65.8	64.5	65.4
Тэжээгчээ алдсаны	32.1	29.9	27.4	23.3
Цэргийн	13.6	14.2	14.7	14.6
Олгосон тэтгэвэр сая/төг	458 206.0	734 130.6	837 486.3	1 011 858.0
Өндөр насны	328 724.0	516 542.0	593 268.5	724 779.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний	70211.0	111 798.7	124 946.0	156 258.8
Тэжээгчээ алдсаны	30 677.6	47 147.6	50 364.2	54 852.4
Цэргийн	28 593.4	58 642.3	68 907.6	75 967.7

“Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллага “тэтгэврийн зөрүү, ялгаа нэмэгдэж байгаа тул түүнийг арилгах чиглэлээр 1991 оноос хойш бага цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгосон 64,500 гаруй иргэдийн анх бодсон тэтгэврийн өсгөх индексийг шинэчлэн тогтоох шаардлагатай байгаа бөгөөд үүнд олон хүүхэд төрүүлж өсгөсөн, он удаан жил ажилласан, хөдөлмөрийн нөхцөл зэргээс шалтгаалан нас харгалзахгүйгээр эрт тэтгэвэрт гарч нөхөн олговор авч байсан иргэдийн тэтгэврийг хамруулах хэрэгтэй байна. Ялангуяа тэтгэвэрийг нэмэгдүүлэхэд сонгуулийн амлалт, тухайн үеийн хөрөнгийн эх үүсвэрт тулгуурлан шийдвэрлэдэг байдлыг халж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Иймээс үнийн инфляцын өсөлтөөс шууд хамааралтайгаар тэтгэвэр дээр нөхөн олговор олгох асуудлыг Засгийн газрын мэдлээс гаргаж зөвхөн хуулиар зохицуулж шийдвэрлэдэг тогтолцоог бүрдүүлж,

¹⁰²Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 1/1962 дугаар албан бичиг

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай, Нийгмийн халамжийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй” гэжээ¹⁰³.

Тохиолдол:

“Ахмадуудад ялгамжтай хандаж байна. Байрны хөнгөлөлттэй зээлд хамрагдах гэхээр батлан даагч байхгүй, өөрсдөө тэтгэврээрээ төлнө гэхээр зээлээ төлж чадахгүй, нас барна гээд зээл олдохгүй. Насаараа бөөрөнхий гэрт амьдарлаа одоо нас ахиад түлээ нүүрсээ ч оруулж чадахаа болиод байна. Жижиг ч жижигдэхгүй халаалттай өрөөнд үлдсэн насаа өнгөрүүлэхийг хүсэхгүй хэн байхав дээ.”

(Сүхбаатар аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг 2012 онд шинээр баталснаар өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэний даатгуулагч өөрөө төлөх 10 хувийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлүүлэн нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөнд тооцуулах боломжтой болсон билээ.

Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 587.2 мянган иргэн ажилласан жилээ 1-11 жилээр тооцуулсан байх бөгөөд эдгээр иргэдийн 45.6 хувь нь эрэгтэйчүүд, 54.4 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Ажилласан жилээ тооцуулсан иргэдийн 40 хүртэл насны 135.6 мянга, 40-55 насны 284.4 мянга, 55 ба түүнээс дээш насны 60 орчим мянган иргэн хамрагдснаар тэдэнд бүрэн тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөл бүрдсэн байна¹⁰⁴.

Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 53 дугаар тогтоолоор тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, тэтгэврийн шинэчлэлийг хийх, ялангуяа хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхийг үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2015-2030 он хүртэл “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ыг баталжээ.

Тус бодлогын баримт бичигт ахмадуудын өндөр насны тэтгэвэртэй холбоотой дараах бодлогын чиглэлийг баримтлахаар тусгасан байна. Үүнд:

- Одоогийн нэг давхаргат тогтолцоог ахмад настан бүрд олгогдох суурь тэтгэвэр, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн жил, тэтгэврийн даатгалын шимтгэлтэй уялдаатай тогтоох тэтгэвэр, сайн дурын үндсэн дээр даатгуулж тогтоох нэмэлт тэтгэвэр гэх мэт гурван давхаргат тогтолцоонд шилжүүлэх;

¹⁰³ “Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллагаас 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн мэдээлэл.

¹⁰⁴ “Ахмад настны хөгжил, хамгааллын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт” үндэсний зөвлөгөөнд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Амарсайханы тавьсан “Ахмад настны хөгжил, хамгааллын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт” илтгэл, 2015 он.

- Малчид, албан бус салбарт ажиллагчдыг тэтгэврийн орлоготой болгох үүднээс улсын төсвийн дэмжлэгтэй тэтгэврийн даатгалын тусгай хөтөлбөрийг бий болгох, хувийн нэмэлт даатгалын даатгуулах эрх зүйн орчныг бий болгох;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаар, тэтгэвэр бодох аргачлалыг сайжруулах зэрэг болно.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчид тэтгэврийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа нь тэднийг ирээдүйд өндөр насны тэтгэвэр авах эрх үүсгэхгүй байх нөхцөлд хүргэх эрсдэлтэй байна. Энэ нөхцөлд тэтгэврийн шинэчлэлийн одоогийн нэг давхаргат тогтолцооноос гурван давхаргат тогтолцоонд шилжүүлэх, тэтгэвэр тогтоолгох үндэслэлийг шинэ хандлага, зарчмаар хэрэгжүүлэх бодлого чиглэлийг баримталж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Хамтын тэтгэврийн тухай хуулийг шинээр баталсан бөгөөд уг хууль нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжих юм. Тус хуульд албан ёсоор гэрлэлтээ батлуулаад 15-аас доошгүй жил болсон, эхнэр, нөхөр хоёулаа 20-оос доошгүй жил нийгмийн даатгалын шимтгэл төлж, бүрэн тэтгэвэр авдаг байх зэрэг шаардлагыг хангасан тохиолдолд хамтын тэтгэвэр авах эрх үүсэх бөгөөд хамтын тэтгэврийн хэмжээ хамгийн багадаа 20 хувь байхаар тогтоожээ. Хуулийг буцаан хэрэглэх хугацаа, хамрах хүрээ, хувь хэмжээг тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газар тогтоохоор хуульчилжээ.

Дэлхийд тэтгэврийн зээлийн талаар тусгайлсан хуультай улс орон байхгүй ч зарим улс оронд өндөр насны тэтгэвэр авагчдад тодорхой хугацаагаар, тодорхой хэмжээний зээлийг хүүгүй олгодог байна. Тухайлбал, Австрали Улсын Засгийн газраас зээл хүссэн тэтгэврийн насны иргэдэд зориулан “Засгийн газрын тэтгэвэр авагчдад зориулсан дэмжлэг” хөтөлбөрийн хүрээнд бага орлоготой тэтгэвэр авагчид болон бусад ахмад настанд санхүүгийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай үед тэдний нийгмийн асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 төрлийн богино хугацааны зээлийг арилжааны банкаар дамжуулан олгодог байна¹⁰⁵.

Иймд тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн индекс тогтоон нэмэгдүүлэх, ялангуяа нийгмийн даатгалын хүрээнд үндсэн тэтгэвэр, нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр авах тэтгэвэр, нэмэгдэл даатгалын тэтгэврийн хосолмол тогтолцоог бий болгох, түүнчлэн ахмадуудын тэтгэврийн зээлийн хүүг бууруулах чиглэлээр бусад улс орнуудын тэтгэврийн зээлийн бодлогын талаарх туршлага, практикийг судалж нэвтрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

3.2.2. Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт, дэмжлэг туслалцаа

Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Нийгмийн халамжийн тухай хуульд 1998, 2000, 2005, 2008, 2012 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан байна.

Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан,

¹⁰⁵“Тэтгэврийн зээлийн талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа” Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл, 21 дэх боть, Улаанбаатар хот, 2015 он.

эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно гэжээ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн зарчмын гол өөрчлөлт нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Үндэсний Статистикийн Хорооны хамтран баталсан "Орлогыг орлуулан тооцох аргачлал"-ын дагуу нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, улмаар уг мэдээллийн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүдийг эрсдэлээс хамгаалах, тэдний наад захын хэрэгцээг хангах зорилгоор улсаас дэмжлэг, туслалцаа үзүүлэхээр заажээ.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас 2013 онд өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг хийж, Монгол Улсын нийт өрхийн 90 орчим хувийг хамруулан 712,044 өрхийн мэдээллийг амьжиргааны түвшингээр эрэмбэлэн, өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсний үр дүнд нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэх зорилтод өрх, иргэнийг оновчтой тодорхойлох боломжийг хангасан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авагчдын тоон үзүүлэлтийг харьцуулж үзвэл дараах байдалтай байна¹⁰⁶.

Хүний тоо, тэтгэмжийн төрлөөр (мян/хүн)		2011	2012	2013	2014
Бүгд		619.6	1 478.4	1 587.8	1 665.6
Халамжийн тэтгэвэр		57.9	60.7	63.4	64.9
Нөхцөлт мөнгөн тэтгэмж		119.0	123.3	131.6	140.7
1	Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	87.2	91.4	94.9	98.6
2	Ахмад настныг асарч буй иргэний	15.1	14.8	16.7	20.0
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний	14.8	15.1	17.7	19.6
4	Бусад	1.9	2.0	2.3	2.5
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт		407.4	372.9	396.1	434.8
5	Нийгмийн халамжийн үйлчилгээ	42.9	21.9	24.1	32.4
6	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт	118.7	112.1	126.0	140.0
7	Алдарт эхийн одонтой ахмадуудад үзүүлсэн тусламж	204.3	205.0	202.5	208.1
8	Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн тусламж	5.0	4.1	4.8	4.9
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт	36.5	29.8	38.7	49.5

¹⁰⁶Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 1/1962 дугаар албан бичиг

Улсын Их Хурлын 2004 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, ахмад настны эрхийн талаар тус бодлогын 2.5 дугаар зүйлд ахмад настан нийгмийн идэвхтэй гишүүн байх, тэдний амьдралын чанарыг нь дээшлүүлэх, нөхөн сэргээх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэхийг дэмжин, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх, эрүүл насжилтыг дэмжих бодлого баримтлахаар тусгасан байна.


Ингэхдээ ахмад настанд туслах, тэднийг идэвхтэй амьдрахад чиглэсэн нийгмийн үйлчилгээг сайжруулах, энэ чиглэлээр ажиллаж байгаа иргэний нийгэм, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг дэмжиж урамшуулахаар заажээ.

Нийгмийн хамгаалал, тэр дундаа нийгмийн халамжийн бодлогод зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, туслалцаа үзүүлэхдээ төр, хамт олон, бүлэг буюу хуулийн этгээд, байгууллага, хувь хүний оролцооны нэгдэлд тулгуурлаж байдгаараа онцлогтой. Анх 1996 онд Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль, 1998 онд “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал” үндэсний хөтөлбөрийг тус тус баталсан байна.

Ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний төрөл, хэмжээг тогтоож, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын энэ талаар хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар 2005 онд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг баталснаас хойш энэ хуульд 2007, 2008, 2009, 2012 онд тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.

Комисс 2015 онд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд заасан тусламж, хөнгөлөлтийг ахмад настнууд тухай бүр, бүрэн эдэлж чадаж буй эсэхийг 18 аймгийн 360 ахмадыг хамруулан судалсан болно. Судалгаагаар тогтоогдсон зарим асуудлыг тоймловол дараах үр дүн гарсан болно.

Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт заасны дагуу ахмадууд хөл, гар, шүд (үнэт металлаар хийхээс бусад)-ний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн авах эрхтэй бөгөөд хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу зардлаа нөхөн гаргуулж авч байсан эсэхийг харьцуулан үзэхэд 33 хувь нь “аливаа төрлийн протез, ортопед хийлгэж байгаагүй”, 5 хувь нь хийлгэж байсан ч зардлаа буцаан авч байгаагүй, 8 хувь нь ийм эрхтэйгээ мэддэггүй гэж хариулсан бол оролцогчдын 37 хувь нь шүдний протез хийлгэсэн гэж хариулжээ.



Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд хөл, гар, шүд (үнэт металлаар хийхээс бусад)-ний протез, сонсох, харах эрхтний ортопедын хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн авах тухай заалтад өөрчлөлт оруулж, ямар төрлийн протез, ортопед хийлгэж байгаагаас хамааран хугацааг ялгамжтай тогтоож өгөх шаардлагатай гэжээ.



Тохиолдол:

“Ахмад настнууд бидэнд нүд, гар, хөл, чих, шүдний аль нэг өвчин тусахад төрөөс хөнгөлөлт туслалцаа үзүүлдэг мөртлөө үүнээс хүнд элэг бөөр зүрх зэрэг дотор эрхтний хүнд өвчлөлтэй болох, хагалгаанд орох үед ямар нэгэн дэмжлэг туслалцаа үзүүлдэггүй.”


(Ховд аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

Ахмадын зориулалттай амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр авч чаддаг уу? гэсэн асуултад 47 хувь нь “Үгүй” гэжээ. “Үгүй” гэж хариулсан оролцогчдоос шалтгааныг нь тодруулахад 21 хувь нь амарч сувилуулах эрхтэй гэдгээ мэддэггүй, 20 хувь хөнгөлөлттэй үнээр амрах эрхийн бичгийг хаанаас яаж авахаа мэддэггүй, 18 хувь нь амралтад амрах шаардлага гардаггүй, 16 хувь нь эрхийн бичиг олддоггүй, 13 хувь нь хүнд суртал, чирэгдэл ихтэй тул эрхийн бичиг авч чаддаггүй, 12 хувь нь бусад гэж хариулсан байв.

“Бусад” гэсэн шалтгааныг тодруулахад дараах хариултыг өгсөн байна.

- амралт сувилалд явж ирээд зардлынхаа 50 хувийг л буцаан авдаг ч энэ нь тэтгэврийн зээлтэй ахмадуудад хүндрэлтэй байдаг тул санхүүгийн байдлаасаа хамаараад явж чаддаггүй,
- өөр өөрсдийн өвчний байдалдаа тохирсон амралт сувилалд амрах гэхээр зөвхөн магадлан итгэмжлэгдсэн амралтад амар гэдэг хязгаарлалт тавьдагаас амарч чаддаггүй,
- амралт сувиллын эрхийн бичиг тэр бүр олддоггүй, сум, багаас өөрсдийн танил тал, ойр дотныхондоо өгдөг, жирийн ядарсан ахмадуудад өгдөггүй,
- эмч нар амралт сувилалд явах талаар зөвлөдөггүй,
- хөдөөгийн малчин ахмадууд мэдээлэлгүй тул хөөцөлдөж явах зав гардаггүй,
- хэдийгээр явах хүсэлтэй байвч өөрөө бие дааж явж чадахгүй тул хажуудаа заавал хэн нэгэн хүн дагуулах шаардлага гардаг.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэгт заасны дагуу тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд болон хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа олгодог мөнгөн тусламж авч чаддаг эсэхийг судлахад 41 хувь нь “уг болзолд хамрагддаггүй”, 36 хувь нь “үгүй” 13 хувь нь “тийм”, 10 хувь нь “мэдэхгүй” гэжээ.



Мөн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дэх хэсэгт заасны дагуу нийслэл болон аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих эрхээ эдэлж чаддаг эсэхийг тодруулахад судалгаанд оролцсон 360 оролцогчоос 5 нь хариулаагүй, 355 оролцогчийн 26 хувь нь “тийм”, 74 хувь нь “үгүй” гэж хариулсан байна.


Тохиолдол:

...Хөдөөгийн ахмадууд Улаанбаатарт очоод хэдхэн хонодог энэ үед яагаад хотын ахмадуудын адил эрх эдэлж болохгүй гэж. Хууль хоёр өөр үйлчилж болохгүй биз дээ. Бид нэгэн ижил нийтийн тээврээр яагаад үнэ төлбөргүй зорчиж болдоггүй юм бэ.


(Говьсүмбэр аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

Дээрх дүнгээс үзвэл Нийслэл болон аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих эрх олгосон хуулийн заалт орон нутгийн ахмадуудын хувьд хэрэгжихгүй байна.

Түүнчлэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь хэсэгт заасны дагуу нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох ёстой байна. Энэхүү заалтын хэрэгжилтийг хангаж, нөхөн олговор өгч байгаа эсэхийг тодруулахад 7 оролцогч хариулаагүй бол бусад 353 оролцогч дараах байдлаар хариулжээ.



Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь хэсэгт заасны дагуу худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газар тэргүүн ээлжинд үйлчлүүлдэг эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын 1.4 хувь нь хариулаагүй бөгөөд 98.6 хувь нь дараах хариултыг өгсөн байна.



Ахмадуудаас харьяа өрхийн болон сумын эмнэлгээс эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тогтмол, түргэн шуурхай авч чаддаг эсэхийг тодруулахад шаардлагатай эмчилгээг анхан шатны эмнэлгээс авч чаддаг, харин нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэхэд ажлын ачааллаасаа болдог юм уу, хүнд сурталтай, үл ойшоосон, тоомжиргүй байдлаар хандах хандлага гаргадаг, орон нутгийн эмч нарын мэдлэг чадвар муу, гар харсан, жаахан ч гэсэн юм өгөхгүй бол хөдөлдөггүй гэжээ.


“Танай баг, хорооны Засаг дарга ахмад настныг судалж бүртгэх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоох болон тусламж үзүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж үнэн зөв тодорхойлолт гаргаж өгдөг үү?” гэсэн асуултад оролцогчдын 2 хувь нь хариулаагүй бол 65 хувь нь “тийм”, 21 хувь нь “заримдаа”, 12 хувь нь “үгүй” гэж хариулжээ.

Оршин сууж буй баг, хорооноос ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээллийг тогтмол цаг хугацаа алдалгүй авч чаддаг эсэхийг тодруулахад дараах байдалтай байна.




Төрөөс ахмад настны эрх, нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны талаар мэдээллийг хаанаас яаж авдаг талаар асуухад аймаг, сумын төвд амьдарч буй ахмадуудын хувьд сумын засаг дарга, нийгмийн ажилтан, эсвэл хөршүүд, радио телевизээр мэдээллийг түргэн шуурхай авч чаддаг гэсэн бол малчин ахмадуудын хувьд хол ойроос ирсэн хүмүүсээс сураг сонсох, радио, телевизээс, хэсгийн ахлагчаас

мэдээлэл авдаг гэсэн юм. Ахмад настнуудад зориулсан аливаа арга хэмжээнд бүрэн хамрагдаж чаддаг эсэхийг тодруулахад дараах хариултыг өгчээ.



Дээрх асуултад “Заримдаа” болон “Үгүй” гэж хариулсан 220 оролцогчоос шалтгааныг тодруулахад дараах үр дүн харагдаж байна.



Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх хэсэгт заасны дагуу бүх шатны Засаг дарга ахмад настны кабинет, төв байгуулж ажиллуулах, энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах үүргийг хүлээсэн байдаг.

Судалгаанд оролцогчдоос сум, баг, дүүрэг, хороодод ахмад настны кабинет, төв байдаг эсэхийг асуухад 56,7 хувь нь “тийм”, 27,8 хувь нь “үгүй”, 14,7 хувь нь өөрийн оршин сууж буй сум, багт ахмад настнуудад зориулсан кабинет, төв байдаг эсэх талаар “мэдэхгүй” гэж хариулсан байна.

Засгийн газраас хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарт 2012 оноос хойш 60 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 15 тэрбум гаруй төгрөгийг зөвхөн ахмад настны амьдрах чадамжийг дэмжих, хөгжлийн орчин бүрдүүлэх чиглэлээр зарцуулсан байна. Тухайлбал, Батсүмбэр дэх Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн асрамжийн байрыг өргөтгөн засварлаж, Нөхөн сэргээх, сувиллын төвийг шинээр барьж, эмнэлгийн болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэн, Сэргээн засалт хөгжлийн

үндэсний төвийн нөхөн сэргээх сувиллын барилгыг худалдан авч, тохижуулан өргөтгөж, улмаар протез ортопедийн болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, Увс аймаг, Сүхбаатар дүүргийн ахмадын сувиллын барилга, Орхон, Завхан аймагт ахмадын хөгжлийн төвийг ашиглалтад оруулсан байна¹⁰⁷.

Ахмад настны кабинет, төв байгуулах санхүүгийн эх үүсвэр орон нутгийн жил бүрийн төсөвт тэр бүр тусгагдахгүй байгаагаас зарим орон нутагт ахмад настан өөрийгөө хөгжүүлэх, идэвхтэй амьдрах, чөлөөт цагаа өнгөрөөх орчин нөхцөлөөр хангагдаж чадахгүй байна. Ахмадуудад адил тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хүргэхийн тулд асрамжийн, нөхөн сэргээх газрыг бүсчлэн байгуулах, мөн ахмадын хөгжлийн төвийг аймаг бүрт бий болгоход анхаарах шаардлагатай байна.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах бөгөөд мөн хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан төсөвт байгууллага үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, аж ахуйн нэгж, байгууллага үлдэгдэл ашгаас цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулахаар байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 5 сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Ахмадын сан” байгуулан ажиллуулах журмыг баталсан ч түүний хэрэгжилт аж ахуйн нэгж, байгууллагад тэр бүр хангагдахгүй байна. Судалгаанд оролцсон орон нутгийн ахмад настнуудаас “Таны ажиллаж байсан байгууллагад ахмад настнууддаа дэмжлэг үзүүлэх зорилготой Ахмадын сан байдаг уу?” асуултад судалгаанд оролцогчдын 51 хувь нь “үгүй”, 24 хувь нь “мэдэхгүй” гэж хариулснаас харахад аж ахуйн нэгж, байгууллагууд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна.

Оршин амьдарч байгаа сум, баг, дүүрэг, хороонд ахмад настны нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах нэгж ажилладаг эсэхийг асуухад оролцогчдын 5 хувь нь хариулаагүй бол 51 хувь нь “Ахмадын хороо” байдаг, 28 хувь нь “Ахмадын зөвлөл”, 16 хувь нь “бусад” гэж хариулсан байна. “Бусад” гэж хариулсан 58 оролцогчдоос өөр ямар байгууллага байдаг талаар тодруулахад 44 нь хариулаагүй бол 14 оролцогчийн 2 нь өмнө ажиллаж байсан байгууллагын Ахмадын хороо, 8 нь “Монголын ахмадын чөлөөт холбоо” төрийн бус байгууллага, 4 нь Эрдэнэт хотын анхдагч Ахмадын холбоо гэж хариулжээ.

Тохиолдол:

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг таниулах, ойлгуулах, хэрэглүүлэх үйл ажиллагаа хийгдээгүй орхигдсон нь нийт ахмадуудын 87 хувь нь тус хуулийг 2005 онд батлагдсан гэж огт мэдэхгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.”

“Ахмад настнууд XXI зууны хөгжлөөс хоцрохгүйн тулд компьютер эзэмших, гар

¹⁰⁷Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 1/1962 дугаар албан бичиг

утсыг бүрэн ашиглах, мэдээллээс хоцрохгүй байх, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахад туслах сургалтыг насан туршийн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд хийж байгаа ч нийт ахмадуудын 14 хувийг л хамарч байна. Үүнээс орон нутгийн ахмадуудын 90 хувь нь насан туршийн боловсролоос хоцорч байна. Ахмадуудын өөртөө итгэх итгэлийг бий болгох, тохирсон сургалтад хамрагдах боловсролын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, ахмад настан хүмүүст нийгмийн боловсролын, соёлын, оюун санааны шинэ түвшний төлөвшилийг бий болгох шаардлага их байна.”

("Монголын Ахмадын чөлөөт холбоо"
төрийн бус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл)

Гишүүнчлэлтэй ахмадын байгууллагууд эрх ашгийг нь хамгаалж ажиллаж чаддаг эсэхийг лавлахад судалгаанд оролцогчдын 42 хувь нь "тийм", 30 хувь нь "үгүй", 23 хувь нь "мэдэхгүй" гэжээ.

Тохиолдол:

"Аймгаас ахмадуудаа дэмжлээ гэж сонсож байгаагүй. Харин саяхан нэг хувийн байгууллагаас автобус бэлэглэсэн байсан. Дархан хотын Болд сан гэдэг байгууллагаас автобус өгч урлагийн тоглолт зохиосон, Сэлэнгэ аймгийн ахмадын зөвлөлтэй хамтран харилцан туслалцах ажлууд зохиогдож байсан. Хавар төлийн бэлтгэл хангахад тусалсан."

(Дархан-Уул аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

Тохиолдол:

"Дорнод худалдаа" ХХК-аас ахмадуудын дунд зохион байгуулсан шатрын тэмцээн, "Дорнод Онон" ХХК-аас Ахмадын баяр зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Ер нь манай аймгийн олон байгууллага, аж ахуй нэгжүүд боломжоороо тусалж дэмждэг.

(Дорнод аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

Ахмадын хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд сум, дүүрэг, баг, хорооны Иргэдийн хурал, Засаг даргын зүгээс үзүүлж буй дэмжлэг ямар байгаа талаар судалгаанд оролцогчдын 42 хувь нь хангалттай, 58 хувь нь хангалтгүй гэсэн хариулт өгсөн байна.

Хангалттай дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан оролцогчид аймагт ахмадын ордон барьж өгсөн, ахмадуудад зориулсан байр, бялдаржуулах танхим, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулж урамшуулах, сар шинэ болон ахмадын баяраар ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх зэргээр дэмждэг гэжээ.

Харин дэмжлэг үзүүлдэггүй гэж хариулсан оролцогчдоос шалтгааныг нь тодруулахад 80 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол 20 хувь нь ахмадуудыг намын харьяаллаар ялгаварладаг, ахмадын байгууллагыг хоёр хэсэг хувааж нэгдсэн зохион байгуулалтгүй болгосон, ахмадуудад чиглэсэн ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар ямар ч мэдээлэл өгдөггүй гэжээ.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлд ахмадын байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжиж, мөн зүйлийн 9.2 дахь хэсэгт

“Ахмадуудын санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд нийт ажиллагсдын 70-аас доошгүй хувийг нь ахмад настан эзэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад Засгийн газар болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлж болно” гэж заасан боловч энэхүү заалтын хэрэгжилт мөн л хангагддаггүй байна.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, түүнчлэн төрийн өндөр албан тушаал эрхэлж байсан ахмад настанд төрөөс олгох нэмэгдэл тогтоох нөхцөл, журмыг хуулиар тогтоож болно” гэж заасны дагуу 2008 онд Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Ардын болон Гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хуулийг батлан гаргаж, уг нэмэгдлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлттэй уялдуулан Улсын Их Хурлаас тогтоож байхаар хуульчилжээ.

Дайнд оролцсон ахмад дайчдад тусламж, дэмжлэг үзүүлэх, тэдэнд тэтгэмж олгох, ялангуяа орон сууц хувьчлахад тэгш хандах, ялгаварлахгүй байхаар 1993 онд Ерөнхийлөгчийн зарлиг гарч, ахмад дайчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж байжээ. Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 170 дугаар зарлигаар ахмад дайчдад сар бүр тэтгэмж олгодог болох, тэдэнд орон сууц олгох, эсвэл түүнтэй дүйцэхүйц мөнгөн тэтгэмж олгох асуудлыг Засгийн газарт чиглэл болгосон байна. Үүний дагуу ахмад дайчинд олгох мөнгөн тэтгэмжийн сарын хэмжээг 200,000 төгрөг болж, нийт 2000 орчим ахмад дайчдад орон сууц болон түүнтэй дүйцэхүйц мөнгөн тэтгэмжийг олгосон байна¹⁰⁸.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль нь ахмадуудын нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулж байгаагаас бусад тэдний хөгжих, хөдөлмөрлөх, нийгмийн амьдралд оролцох эрхийн хамгаалалтыг хуульчлан баталгаажуулж, төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан орон нутагт ахмадуудад зориулсан кабинет, төв байгуулж ажиллуулах асуудал шийдэгддэггүй, хуулийн зүйл, заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх хариуцлагын тогтолцоо тодорхойгүй байгаагаас тус хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.

Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь хэсэгт “нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох” хэмээн 1000 км-ээс цааш алслагдсан бүс нутгаар хязгаарлалт тавьсан нь ахмадуудад тэгш бус нөхцөлийг бүрдүүлсэн, ялгаварласан зохицуулалт болж байна.

Иймд энэхүү хязгаарлалтыг тавихгүйгээр эмнэлгийн дүгнэлтийг харгалзан ахмадуудад унааны хөнгөлөлт эдлүүлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.

Мөн тус хуульд тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хариуцлах тооцох зохицуулалтгүй байгаагаас ялангуяа ганц бие, өвчтэй, хэвтэрт байгаа ахмадуудын хууль ёсны үр хүүхэд, ах дүү нар харж хандах үүргээ биелүүлэхээс зайлсхийж, бие болон сэтгэл санааны хүчирхийлэл үзүүлэх, эд хөрөнгө, өндөр

¹⁰⁸ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 1/1962 дугаар албан бичиг

насны тэтгэврийг нь өөрт нь зарцуулахгүйгээр амьжиргааны түвшинг дордуулах, мөн хуульд тэгш бус, ялгаварласан шалгуур тогтоосон нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй байгаа тул түүнийг арилгахад чиглэсэн хууль, эрх зүйн орчны шинэчлэлийг олон улсын зарчим, хэм хэмжээгээр тодорхойлсон ахмад настантай холбоотой стандартад нийцүүлэх нь зүйтэй юм.

Дээрх нөхцөл байдлаас үзвэл аймаг, орон нутгийн төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй ахмад настнуудад чиглэсэн үйл ажиллагаа нь харилцан адилгүй байна.

Цаашид Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд ахмадуудын хөгжих, хөдөлмөрлөх, нийгмийн амьдралд оролцох эрхийн хамгаалалтыг хуульчлан баталгаажуулахаас гадна тусламж, хөнгөлөлт, дэмжлэгийг баталгаатай эдлүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, хөнгөлөлт, тусламжийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх шаардлагатай байна.

“Цаазлагдсан улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд” төрийн бус байгууллагын төлөөлөл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст удаа дараа хандаж, олон санал хүсэлт уламжилж байсан юм. Эдгээр иргэд “Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байхад төрийн байгууллага, албан тушаалтан энэхүү эрхийг хангаж, өргөдөл, гомдлыг хүлээн авдаггүй, шийдвэрлэдэггүй, төрийн бодлого боловсруулах эрх бүхий хүмүүст гомдол хүсэлт гаргахад хариу өгөхгүй дардаг, хууль боловсруулахдаа бидний төлөөллийг өргөнөөр оролцуулж, санал бодлыг нь авдаггүй нийтлэг дүр зураг нийгэмд бий болсонд гомдолтой байна. Хохирогч үр хүүхэд бид хэлмэгдүүлэлтийн үеэр эцэг эх нь хорих ялаар шийтгүүлж цаазаар авахуулж, хөрөнгөө хураалгаж байсан төдийгүй тухайн гэр бүл ядуурч, нийгмийн хамгийн эмзэг давхаргад хамрагдаж, ялангуяа ялгаварлан гадуурхахаас ангид байх, хүүхэд эцэг эхээрээ овоглох, өөрийн гэсэн нэртэй байх, сурч боловсрох, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх, эвлэлдэн нэгдэх, оршин суух газраа чөлөөтэй сонгох, зорчих, төрийн үйл хэрэгт оролцох зэрэг эрхээ эдэлж чадахгүй байдалтайгаар төрийн бодлогын гадна үлдэж ирсэн юм.

“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн¹⁰⁹ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй” хэмээн тус тус заасан нь эрүү шүүлтийн улмаас учирсан хохирол, эрүүл мэнд, сэтгэл санааны нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулсан болно.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 95 дугаар хуралдааны 1985 оны 11 сарын 29-ний өдрийн A/RES/40/34 дугаар тогтоолоор батлан гаргасан “Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмууд”-ын 3.3-т төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээд үндэсний хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан хэтрүүлж ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй хэмээн заасан байна.

¹⁰⁹ Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэж орсон.

Төр иргэнийхээ амьд явах эрхэд халдаж, улс төрийн хилс хэргийн улмаас амь насыг нь хороосны төлөө хариуцлага хүлээх ёстой. Ялангуяа амь насаа алдсан хэлмэгдэгчдийн өнчирч үлдсэн хүүхдүүдэд нөхөн олговор олгох ажлыг нэн тэргүүнд зохион байгуулах учиртай. Бидний эцэг шүүхээр гэм буруугүй болох нь тогтоогдож, цагаадсан шийдвэр хүчин төгөлдөр болсон атал бид амссан зовлон, учирсан хохирлоо бүрэн төлүүлж чадалгүй өдий хүрлээ. Мөн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цаазлуулсан хүмүүсийн үр хүүхэд бид жил ирэх тусам цөөрсөөр байна. Иймээс Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хэлмэгдэгчийн үр хүүхэд өнөөгийн нийгмийн нөхцөл байдлыг харгалзаж тооцсон нөхөн олговор олгох шаардлагатай байна.

Бид 1930-1940 оны улс төрийн хэлмэгдэгчдийн үр хүүхдийн хохиролд олгох нөхөн төлбөрийн бүтцийг¹¹⁰ доор дурдсанаар байвал зохистой гэж үзэж байна.

Төлбөрийн ангилал	Төлбөрийн үнэлгээ (сая төгрөгөөр)	Төлбөрийн хэмжээ		
		Цаазлуулсан ялтны ар гэрт	10 (5.1-ээс дээш) жил хорих ялтай ялтны ар гэрт	5 ба түүнээс доош жил хорих ялтай ялтны ар гэрт
Нэг. Бодит хохирол				
1.а.гэмгүй эцгээ төрд хилс хэргээр цаазлуулсны төлбөр	70	70	-	-
б.гэмгүй эцгээ төрд амь өршөөлгөж, хилс хэргээр 10 (5.1-ээс дээш) жилээр шийтгүүлсний төлбөр	35	-	35	-
в.гэмгүй эцгээ төрд хилс хэргээр 5 ба түүнээс доош жилээр шийтгүүлсний төлбөр	17,5	-	-	17,5
2.Насан туршдаа эцэггүй, өмөг түшиггүй болж, тэжээгчгүй, тэтгэвэр ч үгүй өнчирч хохирсны төлбөр	5	5	-	-
3.Бүх малаа, бүх эд хөрөнгөө, гэр орноо хүртэл төрд хилсээр хураалган хоосорч байсны төлбөр	25 (12,5)	25	25	12,5
Хоёр. Хийсвэр хохирол				
1. “Эсэргүүнийхэн” гэж төрд гүтгэгдэн, хянагдан хавчигдаж, анкет бүртгэлдээ тэмдэглүүлж, нөр төрөө гутаалгаж, элдвээр эрхээ хасуулж, эцгээрээ овоглох аргагүйд хүрч явсны хохирлын төлбөр	100 %	100 %	50 %	25 %
2. “Эсэргүүгийн” гэгдэж ажил, сургуулиас хөөгдөж, боловсрол, мэргэжилгүй болж, бүх амьдралаараа хохирч, насаараа эцгээ санагалзаж явсан насан туршийн сэтгэл санааны хохирлын төлбөр	100 %	100 %	50 %	25 %

Бидний хүсэлтийг Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт уламжилж шийдвэр гаргуулж өгөхийг хичээнгүйлэн хүсэж байна¹¹¹ гэсэн юм.

¹¹⁰ “Цаазлагдсан улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд” төрийн бус байгууллагаас Комисст ирүүлсэн 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 28 дугаар албан бичгийн хавсралт

¹¹¹ Комисс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн үр хүүхдийн төлөөлөлтэй 2015 оны 11 дүгээр сарын 27-нд хийсэн уулзалтын тэмдэглэл, “Цаазлагдсан улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд” төрийн бус байгууллагаас Комисст ирүүлсэн 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 28 дугаар албан бичиг

Иймд Комисс эдгээр ахмадуудын тавьсан асуудлыг судлан үзэж зохих шийдвэр гаргуулахаар Улсын Их Хурал, Засгийн газарт санал оруулж байна.

3.2.3. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Комисс 2014 онд улсын хэмжээнд төрөлжсөн асрамжийн байгууллагын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг¹¹² хангаж буй ахмад настны асрамжийн үйлчилгээ үзүүлж буй 9 байгууллагад хяналт шалгалт хийж, эдгээр асрамжийн газарт хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнд тавих хяналт хангалтгүйн улмаас ахмад настнууд хуульд заасан эрхээ бүрэн, хангалттай эдэлж чадахгүй байгааг тогтоосон билээ.

Ахмад настан иргэдийн асрамжийн газрын асруулагч нарт хүргэх асрамжийн газрын үндсэн гол үйлчилгээ нь хөгжлийн ажиллагаа, нөхөн сэргээлт, эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээ, асаргаа сувилгаа юм. Гэвч эдгээр асрамжийн газрын ажиллах хүчин чадлаас хамаарч Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5823:2013 стандарт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5798:2008 стандартын хэрэгжилт хангалтгүй байна.

Иймээс Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээ явуулах эрх олгох журам”-ын магадлан итгэмжлэлд орж ажил үйлчилгээ явуулах эрх олгох шаардлагыг боловсронгуй болгох, ялангуяа төрөөс асрамж, халамжийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагын зардлын нормативыг дахин нэмэгдүүлэх асуудлыг судалж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлж буй иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг төрөөс дэмжих, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах замаар асруулагчдын эрх зөрчигдөхөөс сэргийлэх, хамгаалах боломжийг нэмэгдүүлэхээр 2015 онд Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлдээ тусгаж, холбогдох санал зөвлөмж гаргасан билээ¹¹³.

Улс орнууд төрөлжсөн асрамжийн газруудыг иргэдийнхээ онцлог хэрэгцээнд тулгуурлан байгуулж байна. Тухайлбал, нэг нутаг дэвсгэр дээр төвлөрсөн, ахмад настны онцгой хэрэгцээ шаардлагад нийцсэн, эрүүл мэнд-нийгмийн үйлчилгээний хосолсон орчныг бүрдүүлсэн оршин суух байрны цогцолборуудыг хөгжүүлж “Өндөр настны асрамжийн цогцолбор” хэмээн нэрлэдэг болно. Ийм хэлбэрийн цогцолбор нь тусдаа амьдрах сууц, ассистант тусламжийн сууц, урт хугацааны асрамжийн байр, өндөр настны асрамж, хоспис гэсэн хэд хэдэн янзын орон сууц, суурингаас бүрддэг байна¹¹⁴.

¹¹²2014 оны 7 дугаар сард Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад магадлан итгэмжлэл хийсэн байна. Энэхүү магадлан итгэмжлэлд нийт 11 байгууллага шалгуурыг хангаж, 2017 он хүртэл магадлан итгэмжлэгдсэн байна.

¹¹³“Төрөлжсөн асрамжийн газар дахь хүний эрхийн зарим асуудал” Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, Улаанбаатар хот, 2015 он.

¹¹⁴“Ахмад настны асрамж, халамжийн асуудлаарх бусад орны туршлага ба Монгол Улсын статистик мэдээлэл” Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл, 19 дэх боть, Улаанбаатар, хот, 2015 он.

Үүний зэрэгцээ улс орнуудад төрөлжсөн асрамжийн газрууд нь Гэр бүлийн асрамжийн газар¹¹⁵, Ассистант тусламжийн сайн дурын асрамж¹¹⁶, Өндөр настны асрамжийн газар¹¹⁷, Байнгын асрамжийн тэтгэврийн нийгэмлэг¹¹⁸ гэсэн хэлбэрээр хөгжиж байна.

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрлүүд болох ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “өдрийн үйлчилгээний” болон “гэрийн асрамж”, “халамжийн үйлчилгээ”-ний чанарт тавигдах шалгуурыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/63 дугаар тушаалаар баталжээ.

Иймд ахмад настнуудад адил тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хүргэх, төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандарт, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээг шинэчлэн тогтоож, асаргаа, сувилгаа, нөхөн сэргээх, эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зөвшөөрлийг хууль тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн хангасан этгээдэд олгож байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.2.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/901/201 дугаар тушаалаар “Монголын ахмад мэргэжилтнүүдийн Үндэсний сүлжээ, бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, Ахмад мэргэжилтнүүдийг зөвлөгөө өгөх, гэрээгээр, түр хугацаагаар ажиллуулах хөтөлбөр”-ийг баталснаар Ахмад мэргэжилтнүүдийн мэдээллийн тогтолцоог бий болгож, тэднийг зөвлөгөө өгөх, гэрээгээр, түр хугацаагаар ажиллахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

¹¹⁵“Гэр бүлийн асрамжийн газар” энэ нь хоёроос зургаа хүртэл өндөр настан хамт амьдрах байртай, тусгай нийгмийн агентлаг, буяны байгууллагын мэргэжлийн ажилтан болон сайн дурынхан тэдэнд туслан гэр бүлийн уур амьсгал бүхий нөхцөлд тохитой амьдрах, нөхөн сэргээх бүхий л талын туслалцаа, үйлчилгээг авах боломж бүрдсэн байдаг байна. Ийм сууринд амьдрах өндөр настнуудын асаргаа, үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэр улс орон бүрт өөр өөр байх боловч сүүлийн үед улсаас болон өндөр наснаас өөрөөс нь хамтран санхүүжүүлэх хэлбэр нэлээд зонхилж байгаа ажээ.

¹¹⁶“Ассистант тусламжийн сайн дурын асрамж” энэ нь гэр бүлийн асрамжийн газар, өндөр настны асрамжийн газрын завсрын хэлбэр юм. Энд өндөр настнуудад өдөр тутмын амьдралд нь туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ эмч нарыг урьж авч ирэн үзлэг, эмчилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах, эмчилгээг хянах, бэлтгэгдсэн ажилтнууд тухайн хувь хүнд хандсан эмнэлгийн тусгай үйлчилгээ үзүүлэх, оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй, амар тайван аж төрөх бүхий л нөхцөлийг ханган ажиллахаар зохион байгуулагдсан байдаг.

¹¹⁷“Өндөр настны асрамжийн газар” энэ нь өндөр настны асрамжийн газар ба тусгай сувиллын газруудын цогцолбор бөгөөд энд байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, биеийн болон оюун ухааны сааталтай хүмүүст үйлчилдэгээрээ онцлогтой. Энэхүү газарт амьдран үйлчлүүлэгчид нь сувиллагч, тэдгээрийн туслахуудын байнгын хяналтан дор байх ба нөхөн сэргээх мэргэжилтнүүд тэдний бие, оюун ухаан, дадал, хэл ярианы чадварыг сэргээхэд тусладаг. Мөн байр, хоол, унаа, тээврийн хэрэгслээр хангадаг. Энд өндөр мэргэжлийн сувиллагчид гэхээс илүүтэйгэр бэлтгэгдсэн сувиллагчийн туслахууд гол үүргийг гүйцэтгэдэг байна. Ийм төрлийн асрамжийн газрын санхүүжилтийг улс орон бүрт янз бүрээр шийдвэрлэдэг.

¹¹⁸“Байнгын асрамжийн тэтгэврийн нийгэмлэг” энэ нь дээр дурдсан төрлүүдийг нэгтгэсэн хэлбэр эдгээр нь нэг дор, нэг цогцолборт оршиж үйл ажиллагаа явуулна. Ийм маягийн цогцолбор нь ахмад, өндөр настны өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодог байна. Гэвч ийм төрлийн газар нь нэлээд өндөр үнэтэй, улсаас санхүүждэггүй, санхүүжилтийн гол эх үүсвэр нь буяны байгууллагын хандив, үйлчлүүлэгчдийн өөрсдийн тэтгэвэр, хадгаламж, бусад орлогоос бүрддэг байна.

Тохиолдол:

“Ахмадууд бид аймагтаа хүүхдийн тоглоомын талбай байгуулах, түүнийхээ эргэн тойрны хогийг цэвэрлэж хүүхэд багачуудын тав тухтай орчинд тоглох нөхцөлийг хэд хэдэн удаа хангаж байсан. Бид нарын чадах зүйл бол энэ л байна.”

(Архангай аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

“Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд болон залуучуудад ахмад настнуудын сургаал, туршлагыг хуваалцах ажлууд ер нь хийгддэг.”

(Төв аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

“Би аймгийнхаа Ахмад багш нарын холбооны өдөр тутмын ажлыг гүйцэтгэж байна. Манай холбооны ахмад багш нар хүүхдүүдийн оюун ухаан хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс өөрсдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дугуйлан секц ажиллуулдаг.”

(Дархан-Уул аймгийн ахмадуудтай хийсэн ярилцлагаас)

Хөдөлмөрийн тухай хуулийн 112 дугаар зүйлд зааснаар тэтгэвэр авагч ахмад настан хөдөлмөр эрхэлж болох ба өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг хязгаарлах үндэслэл болохгүй бөгөөд ажил олгогч хөдөлмөр эрхэлж буй ахмад настны хүсэлтээр ажлын өдрийн цагийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй ажилд шилжүүлэхээр байна.

Хөдөлмөрийн яамны статистик мэдээгээр манай улсын 60-аас дээш насны 184.732 ахмад настны 24.662 буюу 13.5 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна¹¹⁹.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас хийсэн ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаанд оролцсон 576 ахмад настны 50.2 хувь нь тусгай мэргэжлийн болон дээд боловсролтой байна. Гэтэл өнөөгийн байдлаар манай улсын нийт ахмад настны 4.3 хувь нь буюу 12.7 мянган хүн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 31.8 хувь нь ач, зээгээ буюу хүүхэд харах ажил эрхэлж байна¹²⁰.

Хөдөлмөрийн яамнаас 2013 онд ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 658 сая төгрөгийн санхүүжилт хийснээр мэргэжлийн өндөр ур чадвартай 639 ахмад мэргэжилтэн хамруулсан бол 2014 онд “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтсүүдээр дамжуулан хэрэгжүүлэхэд нийт 999 зөвлөх багийн төсөлд 984.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 3.302 тэтгэврийн насны ахмад мэргэжилтэн, ахмад настны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 төрийн бус байгууллагын 91 зөвлөх багийн 272 ахмад мэргэжилтэн хамрагдсан байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2015 онд 300 сая төгрөгийн санхүүжилт хийж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийн

¹¹⁹ “Ахмад настны хөгжил, хамгааллын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт” Үндэсний II зөвлөгөөнд Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханы тавьсан илтгэл, 2015 он.

¹²⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.

ур чадвар олгох, ажлын байрыг хадгалах”, “Хувиараа нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих”, “Залуучууд, мэргэжлийн сургалт боловсролын байгууллагын төгсөгчдийг дэмжих” зэрэг гурван хөтөлбөрийн хүрээнд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлснээр 1500 гаруй ахмад мэргэжилтэн хамруулсан байна¹²¹.

Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаанд оролцсон 576 ахмад настны 50.2 хувь нь тусгай мэргэжлийн болон дээд боловсролтой байна.

Комиссоос хийсэн судалгаагаар орон нутгийн ахмадуудаас ямар нэгэн ажил хөдөлмөр эрхэлдэг эсэхийг тодруулахад ахмадуудын цөөн хувь нь манаач, хэсгийн ахлагч, төрийн бус байгууллагын тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг гэсэн бол дийлэнх нь ач зээгээ харах, цэцэрлэг, сургуульд нь хүргэж өгөх, авах, мал маллах зэргээр тусалдаг, үр хүүхдүүд маань ч тэр хэмжээгээр бидний хөдөлмөрийг үнэлж дэмждэг гэж хариулжээ.

Тохиолдол:

“Гавьяаны амралтад байгаа ахмадуудын 95 хувь хөдөлмөр эрхлэхийг хүсдэг. 2014 оны судалгаагаар ахмадуудын 5 хувь хөдөлмөр эрхэлж байна. Ахмад настны хөдөлмөрлөх эрхийг хангах, ялангуяа ажлын баялаг туршлагатай өндөр мэргэжлийн ахмад настны бүртгэл сүлжээг бий болгож, тэднийг залуу мэргэжилтнүүдтэй холбож өгч, ажил хөдөлмөрт сургаж дадлагажуулах асуудал чухлаар тавигдаж байна.

“Манай байгууллага нийслэлийн 8 дүүрэг, 3 аймагт ахмад настны зөвлөх багийн ажлыг удирдаж 240 гаруй багт 630 гаруй ахмад настан хамрагдаж 197.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төсөл амжилттай хэрэгжиж байна.”

(“Монголын Ахмадын холбоо” төрийн бус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл)

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар 65 хүртэл насны ахмад настууд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх боломжтой болсноор хөдөлмөрийн чадамжтай ахмад настан орлогоо нэмэгдүүлэх нөхцөл бүрдэж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Цаашид хөдөлмөрийн харилцаанд ахмад настантай тэгш харьцах, нас, хүйс, боловсрол, гадаад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх, ахмад настан өөрөө хүсвэл үргэлжлүүлэн богиносгосон цагаар ажиллах, цалин хөлсийг адил тэгш тогтоох эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.

3.2.5. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ

Улсын Их Хурлаас 2015 онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар тус хуульд даатгуулагчийн эрх, үүрэг, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүн амын бүлгийг нарийвчлан зааж, эрүүл мэндийн даатгалын цахим картыг

¹²¹2015 онд зохион байгуулсан “Ахмад настны хөгжил, хамгааллын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт” Үндэсний II зөвлөгөөнд Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханы тавьсан илтгэл

шинээр нэвтрүүлэн, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлэн тодорхойлжээ.

Үүний үр дүнд эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагч жилдээ 1800.0 мянган төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал гаргуулах эрхтэй төдийгүй энэ хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч гишүүний зөвшөөрснөөр, түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах боломж бүрдсэн байна. Энэ нь даатгуулагч иргэн, тэр дундаа ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн жагсаалт, түүний жишиг үнэ, даатгалын сангаас олгох хэмжээг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан “Жагсаалт батлах тухай” 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 245/161/88 дугаар тушаалд зааснаар өндөр үнэтэй 84 төрлийн эмнэлгийн хэрэгсэлд хөнгөлөлт эдлэх боломжтой болжээ.

Ахмад настнуудын хувьд 10 хүний 8 нь ямар нэг өвчтэй байна. Тэргүүлж буй өвчлөлд зүрх судасны өвчин, бөөр шээсний замын эмгэг, нүд ба түүний дайвар өвчнүүд, амьсгалын замын өвчлөлүүд, сэтгэц зан төрхийн гаралтай эмгэгүүд орж байгаа бөгөөд нэг хүнд 3-4 өвчин хавсарсан байдаг байна¹²².

Тохиолдол:

“Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн таатай үйлчилгээ хөгжөөгүй, халамж үзүүлэхээс өөр арга хэмжээ авдаггүйгээс хэвтрийн ахмадуудад үзүүлэх үйлчилгээний хүртээмж 18 хувьтай байна. Ахмадуудад “насны доройтол”, “насны юм” гэсэн хавтгайруулсан онош тавьж, нарийвчилсан үзлэг оношлогоо хийхээс зайлсхийх хандлага зонхилж байгаагаас ахмад настны өвчлөлт хүндрэх, эдгэх боломжоо алдах, эрт нас барах хувь хэмжээ ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд буурахгүй байна.”

(“Монголын Ахмадын чөлөөт холбоо” төрийн бус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл)

Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 416 дугаар тогтоолоор хүн амын эрүүл насжилтыг дэмжин, ахмад настны эрүүл мэнд, халамж, хамгаалал, нийгмийн оролцоо болон амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрүүл насжилт-настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг баталжээ. Тус хөтөлбөрийг 2020 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 15 тэрбум гаруй төгрөг зарцуулахаар төлөвлөжээ. Гэвч зайлшгүй асаргаа шаардлагатай ахмад настанг асрах сайн дурын идэвхтэнд өгөх урамшуулал, тэднийг бэлтгэж сургах, эрүүл насжилтыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажилд санхүүжилт дутмаг байна¹²³.

¹²² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.

¹²³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, “Хүний хөгжил судалгаа, сургалтын төв” төрийн бус байгууллага хамтран хийсэн “Ахмад эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”, Улаанбаатар хот, 2015 он.

Ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд, ялангуяа хүний хөгшрөлт, наслалттай холбоотой гардаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, ахмад настны идэвхтэй, эрүүл амьдралыг цогцлоож, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд насжилт, настны эмгэг судлал буюу “геронтологи, гериатр”¹²⁴-ийн асуудалд улс орнууд ихээхэн анхаарах болжээ.

Манай улсад 1972 онд ахмад настанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх “Ахмад настны кабинет”-ыг 2 их эмч 1 сувилагчтайгаар анх байгуулж байсан бол одоо Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолоор Геронтологийн үндэсний төв болжээ. Улсын хэмжээнд нийт 22 гериатр эмч, 20 гериатр сувилагч ажиллаж байгаагаас Улаанбаатар хотод 7 эмч, 3 сувилагч байна. Гериатр эмч нь ахмад настныг эмчлэгч эмч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сувилагч нартай хамтран эмнэлгээс гарахын өмнөх үеийн хамтарсан үзлэгийг багаар зохион байгуулж, шаардлагатай эмчилгээний тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, ахмад настны гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч нартай уулзалт хийж, төлөвлөгөөг танилцуулж, зөвшөөрлийг авч, эмчилгээ үйлчилгээг хүргэн, үйлчлүүлэгчийнхээ эрхийг дээдлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх ёстой.

Манай улсад ахмад настанд үзүүлэх герантологи, гериатрын тусламж үйлчилгээг шинэчлэн хөгжүүлэх шаардлагатай байгаа болно. Тухайлбал, насжилт, настны эмгэг судлалын бодлогын баримт бичгийг боловсруулан батлах, ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээнд гериатрын төрөлжсөн мэргэжлийн тусламжийг шатлал бүрт өргөжүүлэн хөгжүүлэх, геронтологи, гериатрын чиглэлийн хүний нөөцийг бэлтгэн чадавхжуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, төр болон төрийн бус байгууллагуудын ахмад настанд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудал тулгамдаж байна¹²⁵.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹²⁴“Геронтологи” гэдэг нь “өвгөн хүн судлал” буюу гэсэн грек үг болно. Өөрөөр хэлбэл насжилт, насны эмгэг судлалыг тодорхойлсон ойлголт юм.

¹²⁵“Ахмад настны хөгжил, хамгааллын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт” Үндэсний II зөвлөгөөнд Насжилт судлал настны эмгэг судлалын нийгэмлэгийн тэргүүн Т.Дулмаагийн тавьсан “Настны эрүүл мэндийн онцлог тусламж, үйлчилгээ, түүнийг хөгжүүлэх шаардлага” илтгэл, 2015 он.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

“Хүн бүр хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах ... эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт)

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газартай Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон 2008, 2010, 2014 онд хамтран ажиллах Санамж бичиг байгуулан ажиллаж байна. Тус 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хамтран ажиллах Санамж бичгийн 2.2.10-т “Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа хорих ангид ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлаар судалгаа хийх”-ээр тусгасан билээ.

Комисс 2015 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлтэй танилцаж, Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, бусад хууль тогтоомж, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, мэргэших, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс авах, амрах зэрэг хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт, судалгаа хийв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэгтэй байгууллага бөгөөд тухайн байгууллагын үйл ажиллагааны чадавх, үр дүн нь албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн баталгаа хэрхэн хангагдаж байгаагаас хамаарна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 2013 онд 2998, 2014 онд 3026, 2015 онд 3045 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байх бөгөөд албан хаагчдын тоо жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна. Тэдгээрээс 2015 оны байдлаар 21-60 насны 2052 эрэгтэй албан хаагч, 993 эмэгтэй албан хаагч ажиллаж байна¹²⁶.

Хяналт шалгалт, судалгаанд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Хорих 401, 405, 407, 411, 415, 421, 425, 429, 443 дугаар ангиуд, Цагдан хорих 461 дүгээр анги, Согтуурах болон мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар болон Архангай, Дорнод, Дорноговь, Баянхонгор, Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хамрагдаж, санал асуулгад 646 албан хаагч оролцов.

¹²⁶Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газраас ирүүлсэн 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 02/186 дугаар албан бичиг.

4.1 Ажлын байрны орчин нөхцөл

Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын¹²⁷ 23 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын¹²⁸ 7 дугаар зүйлийн (b)-д “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.” гэж тус тус заажээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй”, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь хэсэгт “төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах баталгаагаар хангагдана.” гэж тус тус зааснаар албан хаагчдын хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг баталгаажуулжээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 72 дугаар тогтоолоор баталсан “Барилга ашиглалтын дүрэм”-ийн 2.2-т “Өмчлөгч нь барилга байгууламжийг ашиглахдаа Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасныг баримтлан дараах шаардлагыг хангаж ажиллана.” гээд 1-д “эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх”, 5-д “галын аюулгүй байдал болон ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийн шаардлагыг биелүүлэх”, 7-д “барилгын хийц, бүтцэд ан цав, цууралт үүссэн зэрэг ноцтой эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж дүгнэлт гаргуулан холбогдох арга хэмжээ авах” гэж заажээ.

Комиссоос баривчлах, цагдан хорих байр, хорих ангийн ахуй нөхцөлтэй тогтмол танилцаж, үзлэг шалгалт хийж, нөхцөл байдлыг олон улсын болон үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх талаар шаардлага, зөвлөмж хүргүүлсний үр дүнд дээрх байгууламжуудын нөхцөл сайжирсан байна.

Гэвч хяналт шалгалт, судалгааны үр дүнгээс үзвэл зарим Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын байрны (албаны өрөө, тасалгаа, хорих анги, цагдан хорих байр, согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар) орчин нөхцөл шаардлага хангахгүй, хуучирч муудсан, хана таазнаас мөөгөнцөрдөж, ан цав үүссэн, агааржуулалт, гэрэлтүүлэг хангалтгүй зэрэг дараах нөхцөл байдалтай байв.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны үйл ажиллагаа явуулж буй конторын барилга 1944 онд ашиглалтад орсон, олон жилийн ашиглалтын явцад барилга муудсанаас бороо, цасны ус гоожиж хана, таазны шавардлагын drank мод өмхөрч шавар нь суларсан, дам нуруу, хучилт хotoйж цүлхийж ачаалал даах боломжгүй болсон, гадна дотор хана, суурийн чулуун өргийн барьцалдуулагч ашиглалтын явцад суларч хөдөлгөөн орсон, бат бөх чанараа алдсан, шалны дэр мод илжирч хөгцөрч мөөгөнцөртсөн, бүх өрөөнүүд

¹²⁷Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/АIII/тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан.

¹²⁸Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200 (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

маш их чийгтэй байгаа нь халдварт өвчин үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн, цэвэр бохир усны шугамд холбогдоогүй, газар хөдлөлтөд тэсвэргүй, цахилгааны монтаж ашиглалтын хугацаа дуусч богино холбоо үүсч галын аюул гарах нөхцөл бүрдсэн зэрэг нь холбогдох хууль тогтоомж, барилгын норм стандартын шаардлагыг хангахгүй байх тул үйл ажиллагааг нь бүрэн зогсоох тухай тус аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт¹²⁹ гарчээ.

Гэвч тус барилгад 2007, 2008, 2013 онд урсгал засвар хийж үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байгаа нь албан хаагчдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны барилга 2006 онд ашиглалтад орсноосоо хойш их засвар хийгдээгүй, барилгын хана цуурсан, борооны усны дусаал гоожсоны улмаас шохой нь ховхорсон, сантехникийн шугамнууд муудаж, ус гоожсон байдалтай байна. Барилгад их засварын ажлыг хийхэд 25,234,000 төгрөгийн төсөв шаардлагатай гэх бөгөөд уг төсвийн асуудлыг шийдвэрлүүлэхээр 2014, 2015 онд тус тус Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын даргад хандсан байх боловч уг асуудлыг шийдвэрлээгүй байна.

Үүнээс гадна Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа хорих ангийн ялтны амьдрах байр, цагдан хорих байр, баривчлах байрны орчин нөхцөл нь тэнд үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын ажлын байрны нөхцөл ямар байгаагийн шууд илрэл юм.

Тухайлбал Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Цагдан хорих байрыг 1992 онд аж ахуйн аргаар барьж ашиглалтад оруулсан, батлагдсан зураггүй, барилгын сууринд хагарал үүссэн, эргэн тойрны хаяавч байхгүй, гадна өрлөгийн нэгдүгээр үе гэмтэж ховхорсон, өрөөнүүдийн зай багтаамж бага, нэг хүнд ногдох талбайн хэмжээ 2,5 метрээс бага, ажиллаж, амьдрах таатай, эрүүл, аюулгүй орчин нөхцөл бүрдээгүй зэргээр барилгын норм стандартын шаардлагыг хангаагүй талаар тус аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлт гарсан байна. Үүнийг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт уламжлан шинээр цагдан хорих байр барих санхүүжилтийн асуудлыг 2016 оны төсөвт тусгах, мөн ондоо багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Хорих 411 дүгээр ангийн барилга 1960-аад онд ашиглалтад орсон, ашиглалтын үед хийгдэх засварын ажлууд хугацаандаа норм, дүрмийн дагуу хийгдээгүйгээс хана таазанд чийг цохиж, мөөгөнцөр ургасан, коридорын модон таазны шавардлага хагарч хөндийрөн унах нөхцөл бүрдсэн, хучилт ханын хийц бүтээцэд ан цав үүссэн нь барилгын бат бэх тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж байх тул барилгад үүссэн эвдрэл, гэмтлийг мэргэжлийн байгууллагаар тооцоо хийлгэж, зураг төсөл боловсруулан, засварын ажлыг эрх бүхий барилга угсралтын байгууллагаар гүйцэтгүүлэх талаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт¹³⁰ гарсан байна.

¹²⁹Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2010 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн улсын байцаагчийн 30/56/57 дугаартай дүгнэлт.

¹³⁰Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 07-339/1526 дугаар дүгнэлт.

Хорих 433 дугаар ангийн ялтны байр нь Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд модны үйлдвэрийн “Улаан булан”-гийн зориулалтаар 1958 онд баригдсан модон хийц бүхий барилгыг Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 1997 онд орон нутгийн өмч хувьчлалаар шилжүүлж, түүнийг 1998 онд буулгаж барилгын материалыг зөөвөрлөн ялтны байрыг барьсан байх бөгөөд мэргэжлийн инженер, зураг төсөл, суурь бетонгүйгээр барьсны улмаас барилга урдаасаа хойш чиглэлтэй 25 градус хазайсныг 2003 онд засварлаж, хойд хананы дөрвөн хэсэгт тулгуур багануудыг суулгасан байна. Гэвч барилгын булан, шал хэсгээр мөөгөнцөрдөх, туурганы шавар хананд цууралт үүсэх, углуурга, булангууд өмхөрч, зарим газраар унасан, барилгын булангийн суурь цөмрөх, зай завсар их гарсан учир дулаан алдагдах зэрэг хүндрэл үүссэн хэвээр байна.

Тус албанаас Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт, Комиссоос удаа дараа хүргүүлсэн шаардлага, зөвлөмжийг тус тус үндэслэн ялтны байрыг шинээр барихаар барилгын зураг төсөл, төсвийн тооцоог гаргаж Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт хүргүүлжээ¹³¹.

Мөн Хорих 429 дүгээр анги буюу сүрьеэ өвчтэй ялтнуудыг тусгаарлан эмчилдэг уг ангийн ялтны амьдрах 1, 2, 3 дугаар байр нь нэг давхар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын (хуучнаар) цэргийн ангийн түр байрны зориулалттай ашиглагдаж байсан бөгөөд хуучирч муудсан, дээврээс дусаал гоожиж шавар шохой нурсан, хана туурга нь цуурсан, модон шал нь өмхөрч ховхорсон байдалтай байв. Уг ялтны байруудыг цаашид амьдрах зориулалтаар ашиглах боломжтой эсэх талаар мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гараагүй байна.

Комиссоос хорих анги, цагдан хорих байранд хяналт шалгалтыг тогтмол хийж, тэдгээрийн орчин нөхцөлийг сайжруулах, засварлах, шинэчлэх талаар Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт асуудлыг тавьдаг боловч санхүү төсөвтэй холбоотойгоор энэхүү асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.

4.2 Ажлын цаг, цалин хөлс

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлд “Хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн (а)-д “бүх хөдөлмөр эрхлэгчдэд наад зах нь цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ тухайлбал эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгох, энэхүү пактын заалтын дагуу хөдөлмөр эрхлэгч, түүний гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох”, (с)-д “гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох”, (d)-д “амрах зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгохыг хамаарна”, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Цалин хөлс нь үндсэн цалин,

¹³¹Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Хорих 443 дугаар ангиас ирүүлсэн мэдээлэл. 2016 он.

нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ”, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Ажилтанд үндсэн цалин дээр нь ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгож болно”, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь хэсэгт “тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэж тус тус заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2 дахь хэсэгт заасны дагуу хорих байгууллагын албан хаагчдад үндсэн цалингаас гадна хоригдолтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн болон тусгай албаны, цэргийн цол, зэрэг дэвийн нэмэгдэл олгодог бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 217 дугаар тогтоолоор хоригдолтой ажилласны нэмэгдлийг хорих ангийн дэглэмээс хамаарч тухайн албан хаагчийн сарын үндсэн цалингийн 6-8 хувиар тооцож, Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг хорих байгууллагын албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож, Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг төрийн алба хаасан хугацаанаас хамаарч тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 5-27 хувиар тус тус тооцож нэмэгдлийг олгож байна.

Хяналт шалгалт, судалгааны ажлын явцад албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой зөрчил, санал, гомдол гараагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.”, Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт “Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна.” мөн зүйлийн 70.2 дахь хэсэгт “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна.”, мөн зүйлийн 70.3 дахь хэсэгт “Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна.” гэж заасан байна.


Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг түүний харьяа анги, албадууд мөрдөн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, байгууллагуудын захиргааны албан хаагчид өдрийн 8 цагаар, долоо хоногт 40 цаг хүртэл ажилладаг бөгөөд харин гадна, дотор хамгаалалтад ажиллаж буй ерөнхий жижүүр, ээлжийн дарга, шалган нэвтрүүлэх хянагч, даалгавар гүйцэтгэгч хянагч, холбоочин, сувилагч, гадна хамгаалалтын офицер, гадна хамгаалалтын харуул, телекамерын хяналтын ажилтан зэрэг ээлжийн ажилтай албан хаагчид жижүүрлэлтийн үүргийг 24 цагаар тасралтгүй гүйцэтгэж нэг өдөр ажиллаад 2 өдөр амрах буюу 24/48 цагаар ажилладаг байна. Энэхүү ээлжийн ажилтай албан хаагчдын ажил, амралтын цагийг дээрх Хөдөлмөрийн дотоод журамд тодорхой тусгаагүй байна.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтан өдөрт 8 цаг буюу 7 хоногт 40 цаг ажиллах заалтын дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан


хаагч сард 160 цаг, жилд 1920 цаг ажиллах ёстой боловч 24 цагаар жижүүрлэлтийн үүргийг гүйцэтгэж буй ээлжийн ажилтай албан хаагчдын ажлын цагийг тооцвол шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэгт ажилласан цагийг оролцуулахгүйгээр нэг сард 240 цаг, жилд 2880 цаг ажиллаж байна.

Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ? гэсэн асуултад 22,5 хувь нь 8 цаг хүртэл, 28,4 хувь нь 8-10 цаг, 49,1 хувь нь 10-12 цаг хүртэл болон түүнээс дээш цагаар ажилладаг талаар дурджээ. Энэхүү санал асуулгын дүнгээс үзэхэд санал асуулгад оролцсон албан хаагчдын дийлэнх хувь нь илүү цагаар ажилладаг болох нь харагдаж байна.




Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт “Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг нь 2 дахин нэмэгдүүлж олгоно.”, мөн хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт “Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1,5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно.” гэж тус тус заасан байна.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдаас илүү цагаар болон 7 хоногийн амралтын өдөр ажиллаад нөхөж амраагүй бол 1,5 буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс авч чаддаг уу? гэсэн асуултад 2,9 хувь нь тийм, 70,7 хувь нь үгүй, 11,5 хувь нь заримдаа, 14,9 хувь нь хариулаагүй байна.



Мөн нийтээр амрах амралтын өдөр ажиллаад нөхөж амраагүй бол 2 дахин нэмэгдүүлсэн цалин хөлс авч чадаж байна уу? гэсэн асуултад 9,8 хувь нь тийм, 56,1 хувь нь үгүй, 17 хувь нь заримдаа гэж хариулсан бол 17,1 хувь огт хариулаагүй байна.



Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад илүү цагаар, амралтын болон баярын өдөр ажилласан нэмэгдэл цалинг олгохгүй байгаа нь тэдний хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт ажил олгогчийн зүгээс зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, мөн зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд амрах, хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан нэг цагийн завсарлага нэмж олгоно гэж заасан хуулийн заалт хэрэгжихгүй, холбогдох тушаал шийдвэр гардаггүй нийтлэг зөрчил байна.

Тохиолдол:

... Би шийдвэр гүйцэтгэгчээр ажилладаг. Хүүхдээ төрүүлээд 7 сартай байхад нь саяхан ажилдаа орсон. Байгууллагын зүгээс хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулж хорогдуулсан цагаар ажиллуулдаггүй, энэ талаар тушаал шийдвэр гарч байгаагүй.

(Судалгаанд хамрагдсан албан хаагчийн ярилцлагаас)

Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт “... эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ... шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.” гэж заасан атал шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид тушаалын дагуу ажил үүрэг хавсран гүйцэтгэж байх боловч тэдэнд дээрх хуульд заасан нэмэгдэл хөлсийг олгодоггүй байна.

Тохиолдол:

Надтай хамт ажилладаг эмэгтэй албан хаагч төрөхийн өмнөх жирэмсний амралтаа авсан тул удирдлагын зүгээс намайг түүний ажлыг давхар хавсран гүйцэтгэх талаар тушаал гарсан юм. Ингээд би өөрийн үндсэн ажлаас гадна өөр эзгүй байгаа ажилтны ажлыг хавсран гүйцэтгэж байгаа хэдий ч надад нэмэгдэл хөлсийг олгодоггүй. Би маш их ачаалалтай ажиллаж байна.

(Судалгаанд хамрагдсан албан хаагчийн ярилцлагаас)

Албан хаагчдын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/188 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам” батлагдсан байна. Тус журмын 2.7-д “Сэлгэн ажиллуулах тухай шийдвэрийг албан хаагчид ажлын 21-ээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.” гэсэн заалтыг албаны бэлэн байдал, шуурхай зарчимд нийцэхгүй гэх үндэслэлээр Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2015 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/08 дугаар тушаалаар хүчингүй болгожээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид дээрх журмыг бүрэн судлаагүй, холбогдох заалт хүчингүй болсон талаар мэдээгүй байсаар байх тул гэх үндэслэлээр Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 2а/3039 дугаар албан бичгээр Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн дарга нарт үүрэг чиглэл өгчээ.

Мөн журмын 2.1-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг дараах байдлаар 2-3 жил хүртэлх хугацаагаар сэлгэн ажиллуулна.”, 4.2-т “Сэлгэн ажиллуулах тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын гаргасан шийдвэрийг биелүүлээгүй нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг түүнд өөрт нь урьдчилан мэдэгдэлгүйгээр өөр ажил, албан тушаалд сэлгэн ажиллуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан “Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.” гэснийг зөрчиж байна.

Мөн хяналт шалгалт, судалгааны явцад албан хаагчидтай хийсэн ганцаарчлан болон бүлгийн ярилцлагын үеэр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам”-тай холбоотой гомдол, хүсэлт цөөнгүй гаргаж байсан болно.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, албан хаагчдын эрх ашиг зөрчиж байгаа Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/188 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам”-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг нийтийн үймээн самуун, эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлд сэлгэн ажиллуулахаас бусад

тохиолдолд өөрт нь урьдчилан мэдэгдэлгүйгээр шилжүүлэн ажиллуулахыг хориглох тухай өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

4.3 Дүрэмт хувцасны хангалт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй”, мөн зүйлийн 15.2 дахь хэсэгт “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч нь цэргийн цол, дүрэмт хувцастай байна.” гэж тус тус заажээ.

Хяналт шалгалт, судалгаанд хамрагдсан зарим анги, албадын албан хаагчдын хувцасны хангалт сүүлийн жилүүдэд хийгдэхгүй байгаагаас хуучирч гандсан дүрэмт хувцастай албан хаагч цөөнгүй байв.

Офицер, ахлагчийн хувцас, хэрэглэлийг “Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн норм, өнгө, материалын ялгааг батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 279 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад зааснаар албаны китель, өмд (мөрдэс, цэргийн байгууллагын таних тэмдэгтэй), албаны цамц (урт, богино ханцуйтай, мөрдэстэй) эдлэх хугацаа 2 жил, хагас түрийтэй гутал болон өвлийн гутал эдлэх хугацаа 3 жил, зуны ботинк эдлэх хугацаа 1 жил байхаар тус тус заасан байх боловч уг хугацаанд хувцасны хангалт хийдэггүй байна.

Иймээс албан хаагчид албаны хувцас эдэлгээний явцад нормт хугацаандаа хүрэхгүй элэгдэж хуучирсан тохиолдолд тэд өөрсдийн мөнгөөр хувцсаа захиалгаар хийлгэж, худалдан авдаг байна.

Тохиолдол:

Албаны өдөр тутмын хувцас, гуталны нормт хугацаа дууссан байхад хугацаандаа хувцасны хангалтыг хийдэггүй. Хувцас, гутлыг маш чанаргүй материалаар хийж байгаагаас эдлэх хугацаанаасаа өмнө мууддаг, эдэлгээ даадаггүй амархан гандаж, урагдаж, сэмэрчихдэг тул солихоос өөр аргагүй болдог. Тиймээс бид өөрсдийн мөнгөөр албаны хувцсаа “Бөртэ” цэргийн хувцасны үйлдвэрт захиалгаар хийлгэхээс гадна Нарантуул захаас худалдан авдаг.

(Албан хаагчидтай хийсэн бүлгийн ярилцлагаас)

4.4 Тусгай хэрэгсэл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмын 2-т “Засгийн газар, хууль сахиулах байгууллага, албан тушаалтан аль болох ялгамжтай хэрэглэх, боломжтой олон төрлийн зэвсэг, тусгай хэрэгслийг хүртээмжтэйгээр олговол зохино. Хөнөөл ихтэй тусгай хэрэгсэл хэрэглэх нөхцөлийг бууруулах үүднээс бамбай, хамгаалалтын хувцас, сум нэвтэрдэггүй

тээврийн хэрэгсэл, хантааз гэх мэт хамгаалах хэрэгслээр бүрэн хангана.” гэж заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 139 дүгээр зүйлд “шийдвэр гүйцэтгэгч резинэн ба хуванцар сумтай буу, нулимс асгаруулагч” хэрэглэнэ гэж заасан байх боловч шийдвэр гүйцэтгэгч нарт тусгай хэрэгсэл байхгүй, энгэрийн камерыг 2013 онд хангалтаар өгсөн боловч ашиглалтын шаардлага хангаагүй гэх шалтгаанаар 2014 онд тэдгээрийг буцаан татан авсан байна.

Дээрх хуульд зааснаар хорих байгууллагын ажилтан гар, хөл, хурууны гав, хүлэг, ороох цамц, резинэн, цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн ба хуванцар сумтай буу зэрэг тусгай хэрэгсэл ашиглах, галт зэвсэг хэрэглэх, зөвшөөрөгдсөн галт зэвсэг, тусгай хэрэгслийг зөвхөн албан үүрэг гүйцэтгэх үедээ биедээ авч явах эрхтэй болохыг заажээ.

Хяналт шалгалт, судалгаанаас үзэхэд шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч бүрт тусгай хэрэгсэл хүрэлцээгүй, ашиглалтын хугацаа дууссан, чанар муудсан зэрэг байдалтай байна. Жишээлбэл Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хэрэгцээнд 2010 онд олгосон цахилгаан бороохой (шаардлага хангахгүй, эвдэрсэн), 2009 онд олгосон гав (шаардлага хангахгүй, эвдэрсэн), резинэн бороохой зэрэг тусгай хэрэгсэлүүд бүртгэлтэй байна.

Тохиолдол:

... Бид төрд тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагчид хэрнээ ямар ч хамгаалалтгүй ажиллаж байна. Тусгай хэрэгсэл байдаггүй, байгаа нь хүрэлцээ муутай, олон жил болсон, ашиглалтын хугацаа дуусч чанарын шаардлага хангаахааргүй болсон зэрэг нь албан үүргээ явуулахад хүндрэл учруулдаг.

(Албан хаагчидтай хийсэн бүлгийн ярилцлагаас)

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 51 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журмын 8.3-т ерөнхий жижүүр нь “Хоногийн жижүүрийн хугацаанд хөтлөгдөх баримт бичиг, галт зэвсэг, тусгай хэрэгсэл зэргийг биечлэн хүлээн авч тусгай төмөр сейфэнд хадгалж, түлхүүрийг өөртөө байлгана.” гэж заасны дагуу тухайн анги, албадад ашиглагдаж буй тусгай хэрэгслийн тодорхой хэсгийг харуул шалган нэвтрүүлэх байрны харуул хамгаалалтын сейфэнд хадгалдаг байна.

Тусгай хэрэгслийн чанар, хүрэлцээ, хадгалалт, тэдгээрийг хэзээ, хэрхэн, яаж ашиглах журам нь тодорхойгүй байгаагаас ялтны амьдралын болон үйлдвэрлэлийн бүсэд эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд тэнд үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын биед халдах, үүссэн нөхцөл байдлыг богино хугацаанд таслан зогсооход тусгай хэрэгслийг ашиглах боломжгүй байдал харагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын тусгай хэрэгсэл хүрэлцээгүй, ашиглалтын хугацаа дуусаж хуучирсан, чанарын шаардлага

хангахгүй байгаа нь тэдний амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулах, ажил үүргээ гүйцэтгэх явцад сөрөг нөлөө үзүүлж болох тул цаашид албан хаагч бүрийг нэг бүрийн тусгай хэрэгслээр хангах, тусгай иж бүрэн агсамжтай болох талаар холбогдох арга хэмжээг авах шаардлагатай болжээ.

4.5 Эрүүл мэндийн асуудал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалтад “Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна, эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.” гэж заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, албадын төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан болон хугацаат үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах зардал тусгагдаагүй байна.


Тохиолдол:

... Тус албаны албан хаагчдыг төрийн зардлаар эрүүл мэндийн иж бүрэн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан тохиодол байхгүй бөгөөд харин жилд нэг удаа албаны санаачлагаар нэгдсэн эмнэлгийн зарим нарийн мэргэжлийн эмч нарт санал тавьж хөнгөлөлттэй үнээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж ирсэн.

(Хяналт шалгалт, судалгаанд хамрагдсан
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны мэдээллээс)

“Байгууллагаас жил бүр эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулдаг уу” гэсэн асуултад 62 хувь нь тийм, 16 хувь нь үгүй, 22 хувь нь заримдаа гэж тус тус хариулсан байна.

ОУИАН
СУДАЛГААНЫ САН



Санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь нь байгууллагаас жил бүр эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулдаг гэж хариулсан боловч албан хаагчидтай хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үеэр зарим аймгууд дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албад тухайн аймгийн эрүүл мэндийн нэгдэлтэй гэрээ байгуулсны үндсэн дээр албан хаагчдаас 20,000-35,000 төгрөгийн төлбөр авч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж байна.

Үүнийг тухайн албадын удирдлагуудын зүгээс албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах төсөв байхгүйтэй холбон тайлбарлаж байв.

4.6 Сургалт

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх хэсэгт “төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах”, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн А/128 дугаар тушаалын хавсралтаар баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн зааврын 10.3.2-т “байгууллагын албан хаагчийг 2 жилд нэгээс доошгүй удаа сургалтад хамруулсан байна” гэж тус тус заасан байхад албан хаагчдад сургуульд суралцах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад ажлаас чөлөө олгохгүй, сурч байгаа гэх шалтгаанаар ээлжийн амралтыг эдлүүлдэггүй зэрэг зөрчил нийтлэг байна.

Тохиолдол:


... Би Хууль сахиулахын их сургуульд суралцаж байгаа бөгөөд байгууллагын удирдлагын зүгээс намайг сурч байгаа гэх шалтгаанаар 2015 оны ээлжийн амралтыг биечлэн эдлүүлээгүй. Ер нь албан хаагчдыг Хууль сахиулахын их сургуулиас өөр сургуульд суралцсан тохиолдолд ажлаас чөлөө олгодоггүй.

(Хяналт шалгалтын явцад албан хаагчтай хийсэн ярилцлагаас)

Албан хаагчдыг ажлаас чөлөө авч сургуульд сурч байгаа гэх шалтгаанаар ээлжийн амралтыг биечлэн эдлүүлэхгүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож

биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно.” гэж заасныг зөрчиж байна.

“Та сүүлийн гурван жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан уу” гэсэн асуултад 35,8 хувь нь тийм, 58,9 хувь нь үгүй, 5,7 хувь нь заримдаа гэж хариулснаас үзэхэд нийт албан хаагчдын дийлэнх хувь нь гүйцэтгэж буй ажил үүрэгтэйгээ холбоотойгоор мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагддаггүй болох нь харагдаж байна.



Хяналт шалгалт, судалгааны дүнгээс үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийг хангах чиглэлээр дараах саналыг гаргаж байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зарим анги, албадын ажлын байрны (албаны өрөө, тасалгаа, хорих анги, цагдан хорих байр, согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар) орчин нөхцөлийг сайжруулахад шаардагдах төсвийг батлах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад илүү цагаар, амралтын болон баярын өдөр ажилласан нэмэгдэл цалинг заавал олгож хэвших, шаардагдах төсвийг батлах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын тухайн улирлын албаны дүрэмт хувцасны хангалтыг хугацаанд нь тавьж хэвших, хувцас, гутлын чанарыг сайжруулах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилтан бүрийг нэг бүрийн тусгай хэрэгслээр бүрэн хангах, одоо ашиглагдаж буй тусгай хэрэгслүүдийг сайжруулан шинэчлэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг жил бүр эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, оношилгоонд хамруулах зардлыг төсөвт тусган батлах;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн саналыг харгалздаггүй, түүнд урьдчилан мэдэгдэлгүйгээр сэлгэн ажиллуулдаг зохицуулалт нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчиж, албан хаагчдын эрх ашигт нийцэхгүй байна. Иймд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/188 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам”-д “Хорих анги болон цагдан хорих байранд үймээн самуун, эмх замбараагүй байдал гарсан зэрэг онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн саналыг харгалзахгүйгээр, мөн түүнд урьдчилан мэдэгдэлгүйгээр сэлгэн ажиллуулахыг хориглоно” гэсэн өөрчлөлт оруулах;

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР
ХҮРГҮҮЛЖ БУЙ САНАЛ

Нэг. Эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар:

- 1.1 Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн “албадан хөдөлмөр хийлгэх” гэснийг хасч Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцийн заалтад нийцүүлэн, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх газрыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд шилжүүлэх;
- 1.2 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 7 дахь илтгэл (2008 он), 11 дэх илтгэл (2012 он), 12 дахь илтгэл (2013 он), 13 дахь илтгэл (2014 он), 14 дэх илтгэл (2015 он)-ээр тус тус өгсөн санал, зөвлөмжийн дагуу сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн төрөлжсөн асрамжийн газар байгуулах асуудлыг 2016 онд багтаан шийдвэрлэж, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд байгаа Асрамжийн клиникт асруулж буй сэтгэцийн эмгэгтэй давхар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдарч буй орчин нөхцөлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, тэдний хэрэгцээнд тохирсон тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;
- 1.3 Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн харьяа “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр”-ыг зохих стандартын шаардлагад нийцсэн байранд оруулах, эсхүл шинэ байр барих асуудлыг даруй шийдвэрлэх;
- 1.4 Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад цол нэмэх, тушаал дэвшүүлэхэд тавигддаг шаардлагад “хүний эрхийн зөрчил гаргаагүй байх” гэсэн үзүүлэлт нэмж оруулах;
- 1.5 Ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох асуудлыг конвенцод нийцүүлэн Хөдөлмөрийн асуудал болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан журмаар зохицуулж, ялтнуудад хийсэн ажил хөдөлмөрт нь тохирсон цалин хөлсийг ялгаваргүй олгох;
- 1.6 Хорих ангийн байршил, дэглэмээс үл хамаарч ялтны эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах үүднээс хорих ангийн эмнэлгийг мэргэшсэн хүний нөөц, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм, тариагаар хүрэлцэхүйцээр хангах, стандартад нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

Хоёр. Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар:

- 2.1 Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ тайлбар, мэдүүлэг өгөх бүрт байлцах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд шинэ нотлох баримтыг гаргах, түүнийг хавтаст хэрэгт заавал хавсаргадаг байх, шаардлагатай гэж үзсэн гэрчийг шүүх хуралд оролцуулахыг шаардаж, урьж оролцуулж мэдүүлгийг сонсох, өмгөөлөгчийн санал, хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч заавал шалгаж шийдвэрлэдэг байх, шүүхэд өмгөөлөгчийн шинээр гаргасан нотлох баримтыг үнэлэх, хэлэлцэх журмын зохицуулалтыг Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тусгаж, өмгөөлөгчийг мэтгэлцээний эрх тэгш субъект байх зарчмыг тууштай хэрэгжүүлэх ;
- 2.2 Шүүгдэгчийн цагдан хорих хугацааг олон улсын хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэг мөр болгон зохицуулах;
- 2.3 Улсын өмгөөлөгчийн орон тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа Хууль зүйн туслалцааны төвийн одоогийн салбар бүтэц, үйл ажиллагааг өргөтгөн зохион байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;
- 2.4 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа Цагдан хорих байруудад өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ ямар нэгэн хориг хязгаарлалтгүйгээр ганцаарчлан уулзах нөхцөл боломжийг хүний эрхийн зарчим, стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх

Гурав. Ахмад настны эрхийн талаар:

- 3.1 Ахмадуудын хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийн хамгаалалтыг хуульчлан тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулж Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
- 3.2 Төрөлжсөн асрамж үйлчилгээний газрын нөхцөлийг зориулалт, стандартын шаардлагад нийцүүлэн даруй шинэчлэх;
- 3.3 Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс настны эмгэг судлалын төрөлжсөн мэргэжлийн тусламжийг шатлал бүрт өргөжүүлэн хөгжүүлэх, хүний нөөцийг бэлтгэн чадавхжуулах;
- 3.4 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хэлмэгдэгчийн үр хүүхдэд нөхөн олговор олгоход чиглэсэн тусгайлсан зохицуулалт бий болгох;

Дөрөв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын Хөдөлмөрлөх эрхийн талаар:

- 4.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилтан бүрийг нэг бүрийн тусгай хэрэгслээр бүрэн хангах, одоо ашиглагдаж буй тусгай хэрэгслүүдийг сайжруулан шинэчлэх;

4.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, оношилгоонд хамруулах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, батлах;

4.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн саналыг харгалздаггүй, түүнд урьдчилан мэдэгдэлгүйгээр сэлгэн ажиллуулдаг зохицуулалт нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчиж, албан хаагчдын эрх ашигт нийцэхгүй байна. Иймд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/188 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг сэлгэн ажиллуулах журам”-д “Хорих анги болон цагдан хорих байранд үймээн самуун, эмх замбараагүй байдал гарсан зэрэг онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн саналыг харгалзахгүйгээр, мөн түүнд урьдчилан мэдэгдэлгүйгээр сэлгэн ажиллуулахыг хориглоно” гэсэн өөрчлөлт оруулах;